

ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫН ҮНДЭС (Т.РЕ203) ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНХИЛЦУУЛГА

Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага (CLO):

1. Мэдлэг

- 1.1.Тэгш хамруулах боловсролтой холбоотой эрх зүйн баримт бичгүүдийг нэрлэх, тэгш хамруулах боловсролын үндсэн зарчмууд, хэрэгжүүлэх арга зам, мөн чанарыг орчин үеийн боловсролын үзэл баримтлалтай холбон тайлбарлах [PLO 1.1.6, 2.3.3, 2.4.3, 3.1.2]
- 1.2.Тэгш хамруулах боловсрол шаардлагатай суралцагчдын онцлог ялгаатай байдлыг мэдэх, тэднийг ойлгох, хөгжлийн болон суралцахуйн онцлогийг жишээгээр тайлбарлах, гэр бүл, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх арга замыг тодорхойлох [PLO 1.1.3, 2.1.1, 2.2.4, 3.1.2]

2. Чадвар

- 2.1.Боловсролд тэгш хамрагдахгүй тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдүүд, тэдгээрийн онцлог, үйл ажиллагааны алдагдал, өөрчлөлтийг илрүүлэх [PLO 1.1.2, 1.3.2, 2.1.1, 3.4.2]
- 2.2.Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдүүдэд ГСТ төлөвлөж хэрэгжүүлэх, сургалтын орчин дахь эрх тэгш оролцоог бүрдүүлж, сурагч бүр бие биеэ хүндэтгэсэн шударга, ёс зүйтэй эерэг харилцааг бий болгох [PLO 3.1.2, 3.1.3, 2.3.5, 2.2.6, 2.4.3, 2.5.2]
- 2.3.ЕБС-ийн ердийн анги дахь ялгаатай суралцагчдын онцлог, сургалтын түгээмэл загвар, орчин үеийн суралцахуйн онолд үндэслэн сурах сургах арга, анги танхимын зохион байгуулалтын хувилбар боловсруулах [PLO 2.4.1, 2.4.2, 2.4.6, 3.1.2]
- 2.4.Сурагчийн эцэг эх, асран хамгаалагчидтай нягт хамтран ажиллаж тэдэнд хүүхдийнх нь тусгай хэрэгцээ, онцлог байдлыг ухамсарлуулан ойлгуулж, хүүхдийнхээ чадавхаа бүрэн дайчилж хөгжихөд нь хөтлөх, арга зүйн дэмжлэг үзүүлэх [PLO 2.2.2, 2.5.3]

3. Хандлага

- 3.1.Тэгш хамруулах боловсрол шаардлагатай сурагчид, тэдний эцэг эхтэй хүндэтгэлтэй хандах, хүүхэд бүр сурч чадна гэдэг итгэл өгөх, тэднийг сургалт хүмүүжлийн зорилго зорилтдоо хүрэхэд нь чин сэтгэлээсээ туслан дэмжих [PLO 2.2.1, 3.4.1, 3.5.2, 3.3.1]

Үнэлгээний жин, хэлбэр:

Ирц, оролцоо: 20%

Бие даалтууд: 50%

Явцын сорил I, II: 30%

Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр, код:	Тэгш хамруулан сургах боловсролын үндэс, Т.РЕ203
Улирал:	II дамжааны намрын улирал
Хичээлийн задаргаа:	1:2:0:0 (2) (лекц, семинар)
Заах багш:	Д.Одгэрэл, Ц.Тамир
Е-мэйл хаяг:	odgerel@msue.edu.mn , ts.tamir@msue.edu.mn
Утас:	(976)-70112429
Ажлын өрөө:	5-р байр 117 тоот
Ажиллах цаг:	Даваа-Баасан, 8:40 am - 18:00 pm.

Үндсэн сурах бичиг:

1. Д. Одгэрэл, Б. Намираа (2018) “Тусгай боловсрол” Хөгжлийн онцлог бүхий суралцагчдыг дэмжих онол, арга зүй, Содпресс ХХК, УБ 250 хуудастай, (31,25 х.х), 11 бүлэгтэй.
2. Д.Одгэрэл, Ч. Нямдорж (2022) ”Тэгш хамруулах боловсролын үндэс”
3. Д.Одгэрэл нар (2020)”Тэгш хамруулах боловсрол” 2020 он, ХИС, Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих төсөл
4. Д.Одгэрэл нар (2020)“Суралцахуйн үйл ажиллагааг дэмжих тусгай хэрэгцээт боловсролын 172 шинэлэг санаа /бага ангийн жишээн дээр” гарын авлага
5. Д. Одгэрэл, Н.Оюунтунгалаг (2020) “Зан төрх, танин мэдэхүйн бэрхшээлтэй хүүхдийн талаарх ойлголт, илрүүлэх арга зам” гарын авлага

Нэмэлт унших материалууд:

1. (2016) Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах хууль.
2. (2016) Хүүхдийн эрхийг хамгаалах хууль.
3. БСШУЯ, UNICEF SIDA. (2007) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК
4. ЮНЕСКО, (2015) Инчоно тунхаглал.
5. ДЭМБ. (2001) Олон улсын үйл ажиллагааны ангилал.
6. Бэгз, Н. Цэвээнлхаазал, Я. Энхээ, Д. (2009) Бага Боловсролын сурган хүмүүжүүлэх зүй. Улаанбаатар:
7. Одгэрэл, Д. **ЮНЕСКО. БСШУЯ. нар (2015) Тэгш хамруулан сургах багшийн боловсрол.** Улаанбаатар: Адмон принт
8. Special Needs Education Conference (1994) Salamanca Declaration: Access and Quality, UNESCO. Spain, Salamanca
9. Warnock, H.M. (1978) Special Educational Needs, UK Department of Education and Science, London

Хичээлийн залгамж, холбоо: Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх арга зүй, Т.РЕ409

Хичээлийн товч тодорхойлолт: Тэгш хамруулан сургах болон тусгай хэрэгцээт боловсролын шинжлэх ухааны тулгуур ухагдахуун, концепци, боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн ангилал, боловсролын үнэлгээ, ганцаарчилсан сургалтын төлөвлөлт, суралцахуйн түгээмэл загвар, тусгай болон тэгш хамруулах боловсролын орчны хүртээмж чанарын асуудлуудыг бага ангийн багш мэргэжлийн онцлог, түүнд тавигдах шаардлага зэрэгт нийцүүлэн судална.

Хичээлийн зорилго: Оюутан багш нь тэгш хамруулах болон тусгай хэрэгцээт боловсролын түүхэн хөгжил шинэчлэлт, боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн ангилал, онцлог, боловсролын үнэлгээ, үйлчилгээний хамрах хүрээ, тэгш

хамруулах боловсролын онол, арга зүйг (СТЗ) онол-практикийн үүднээс тайлбарлаж төлөвлөж хүүхэд бүрийн хөгжих нөхцөл боломжоор хангах эрмэлзэл, хандлага мэргэжлийн чиг баримжаатай болоход чиглэж байна.

Агуулга: ТЭХБ-ын түүхэн хөгжил, орчин үеийн чиг хандлага, эрх зүйн орчин, зохион байгуулалт, ТЭХБ-ын байгууллага, мэргэжилтнүүд, тэдгээрийн үйл ажиллагаа, Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн боловсролын үнэлгээ, ТЭХБ-ын үйлчилгээ, Тэгш хамруулан сургах боловсрол, зохион байгуулалтын тухай ойлголт

Хичээлийн сургалтын арга зүй: Хичээлийг оюутны оролцоо төвтэй, бүтээлч үйл ажиллагааг сэдэлжүүлсэн, эрэл хайгуул, эргэцүүлэл хийх боломжийг бүрдүүлсэн сургалтын сэтгэл зүйн таатай орчныг бүрдүүлэн ажиллахад анхаарна. Сургалтад аудио видео хэрэглэгдэхүүн, сурагчид ярилцлага мэтгэлцээн хийх зэрэг интерактив сургалтын арга зүйд тулгуурлана.

Хүснэгт 1. Үр дүнгийн хамаарал

Хичээлийн төлөвлөлт	Хичээлийн эзэмших мэдлэг, чадвар
Бүлэг сэдэв 1. Тэгш хамруулах боловсролын үндсэн ухагдахуун, нэр томъёо	CLO [1.1, 1.2, 1.3]
Бүлэг сэдэв 2. Сургалтын үйл ажиллагаа төлөвлөлт, зохион байгуулалт	CLO [2.1, 2.2, 2.3]
Бүлэг сэдэв 3. Хүүхэд бүрийн онцлог, тусгай хэрэгцээ	CLO [3.1, 3.2]

Хүснэгт 2. Хичээлийн төлөвлөгөө

Нийт цаг: 48 цаг

7 хоног	Сэдэв	Лекц	Семинар
1-4	Тэгш хамруулах боловсролын үндсэн ухагдахуун, концепци	4	8
5-8	Сургалтын үйл ажиллагааг төлөвлөлт, зохион байгуулалт	4	8
9-16	Хүүхэд бүрийн онцлог, тусгай хэрэгцээ	8	16
Нийт цаг		16	32

Үнэлгээ:

№	Үнэлгээний хэлбэр	Эзлэх хувь	Багтаамж
1	Ирц, оролцоо	20%	Лекц ба семинарын ирцийг 10%, семинарын хичээл дэх оюутны оролцоог 10% байхаар үнэлнэ.
2	Бие даалтууд	50%	Бие даалтыг 2 удаа гүйцэтгэнэ: • Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах 50% • Үндэслэл, нотолгоо бүхий эсээ, бүтээлч ажил 50%
3	Явцын сорил I, II	30%	I-VIII долоо хоногийн хичээлийн агуулгаар I сорил (15% байх ба түвшинчилсэн тест, даалгаврын хувийг тооцно) IX-XVI долоо хоногийн хичээлийн агуулгаар II сорил (15% байх ба түвшинчилсэн тест, даалгаврын хувийг тооцно)

ТАНИЛЦАХ ДАДЛАГА (Т.ТР230) ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА

Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага (CLO):

1. Мэдлэг

- 1.1. Сургууль болон бусад боловсролын байгууллагын онцлог, үйл ажиллагааны цар хүрээ, бүтцийг мэдэх, зураглал хийх [PLO 1.1.5, 1.2.1, 2.2.5, 2.4.3]

2. Чадвар

- 2.1. ЕБС-ийн нэгжүүдийн үйл ажиллагаанд ажиглалт хийх, чиг үүргийг тодорхойлж, үр дүнг нэгтгэн дүгнэх, үнэлэх [PLO 1.1.2, 1.1.5, 2.2.4, 2.2.6, 2.3.4]
- 2.2. Багш, сургалтын үйл ажиллагааны хүрээ, онцлог, чиглэл, багшийн эрх үүргийг мэдэх, сургалтын байгууллага дахь багшийн үйл ажиллагааны гүйцэтгэх үүргийг боловсрол судлалын үүднээс тодорхойлох [PLO 1.2.1, 1.2.2, 2.3.1, 2.3.6, 2.3.7, 3.3.2]
- 2.3. Ангийн суралцагчдын нас зүйн онцлог, сурах үйл ажиллагааны хүрээ, чиглэлийг судлах, дүгнэлт боловсруулах [PLO 1.1.2, 1.1.5, 1.1.6, 2.1.1, 2.2.6, 2.4.1, 3.1.1]
- 2.4. Багш боловсролоор сурах үйл ажиллагаагаа төлөвлөх, цагаа оновчтой төлөвлөх [PLO 1.1.1, 2.2.1, 2.3.6, 2.4.8, 3.5.1, 3.5.2]

3. Хандлага

- 3.1. Багш, сурагчийн үйл ажиллагаа, хөгжлийн онцлогийг оношилж судлахын чухлыг ойлгох, судлаачийн ёс зүйг мөрдөх [PLO 1.1.1, 1.1.2, 1.1.5, 1.1.6, 2.1.1, 2.4.8]
- 3.2. Хүүхэд судлах чиглэлд тасралтгүй өөрийгөө хөгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй байх [PLO 1.1.1, 2.4.8]

Үнэлгээний жин, хэлбэр:

Ирц, оролцоо: 10%

Дадлагын дэвтрийн хөтлөлт, дадлагын сан: 50%

Эцсийн үнэлгээ: 40%

Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр, код: Танилцах дадлага, Т.ТР230
Улирал: I дамжааны намрын улирал
Хичээлийн задаргаа: 0:0:0:2(2). (практик)
Заах багш: Н.Цогзолмаа, Ц.Тамир, Г.Бямбатогтох, Б.Мягмаржав, Т.Энхмаа, Ч.Нямсүрэн
Е-мэйл хаяг: tsogzolmaa.n@msue.edu.mn, ts.tamir@msue.edu.mn, byambatogtokh@msue.edu.mn, yarus2020@yahoo.com, t.enkhmaa@msue.edu.mn, nyamsureenchuluundorj@gmail.com
Утас: (976)-70112429
Ажлын өрөө: 5 – 208
Ажиллах цаг: Даваа-Баасан, 8:40 am - 18:00 pm.

Үндсэн сурах бичиг:

1. Ичинхорлоо, Ш. (2012). Багшийн ном. Улаанбаатар: Соёмбо Принтинг
2. Мягмар О., Оюунгэрэл С. (2022). Боловсролын сэтгэл судлал. Улаанбаатар: Мөнхийн үсэг

Нэмэлт унших материалууд:

1. Эрдэнэчулуун Д. (2010) Хүүхдийг судлах арга зүй, I, II дэвтэр. Улаанбаатар:Ганпринт
2. Эрдэнэцэцэг С. (2018). Багшлахуй: Зарчим ба хандлага. Содпресс ХХК
3. Эрдэнэцэцэг С., Хонгорзул Б. (2017). Суралцахуй: Үзэл баримтлал ба хандлага.
4. (2015). Бага ангийн багшийн гарын авлага. Ред Жадамба
5. [Боловсролын тухай хууль \(legalinfo.mn\)](http://legalinfo.mn)

Хичээлийн залгамж, холбоо: Судлах дадлага Т.ТР255

Хичээлийн товч тодорхойлолт: Танилцах дадлага нь багш мэргэжлийг сонгож суралцаж эхэлсэн оюутнуудад мэргэжлийн анхны ойлголтыг өгч, сонгосон мэргэжлээрээ амжилт гаргахын тулд суралцах төлөвлөгөөгөө гаргахад чиглэгдэх бөгөөд багш бэлтгэх сургалтын нэг үндсэн хэсэг болох багшлах дадлагын салшгүй хэсэг байна.

Хичээлийн зорилго: ЕБ-ын сургууль түүний бүтэц, үйл ажиллагааны зохион байгуулалт, агуулга, арга хэлбэртэй танилцах, багш мэргэжлийн үйл ажиллагааны талаар баримжаатай болох

Агуулга: Багшийн эрх үүрэг, сургууль үйл ажиллагааны хүрээ, багш, суралцагчийн үйл ажиллагааны онцлог, сурах үйлийн төлөвлөгөө зорилго, боловсролын бусад байгууллагын үйл ажиллагааны чиглэл, үүрэг

Хичээлийн сургалтын арга зүй: Дадлагыг оюутны оролцоо төвтэй, тэдний бүтээлч үйл ажиллагааг сэдэлжүүлсэн, оюутан нэг бүрийн хөгжих боломжийг нээх, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, асуудал дэвшүүлэх, шийдвэрлэх аргуудаар зохион байгуулна.

Хүснэгт 1. Үр дүнгийн хамаарал

Хичээлийн төлөвлөлт	Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадварууд
ЕБ-ын сургуулийн эрхэм зорилго, үйл ажиллагаатай танилцах	CLO [1.1, 2.1]
Багшийн үйл ажиллагааны чиглэлтэй танилцах	CLO [1.2, 2.1, 3.1]
Багшлахуйн талаарх цаашдын мэдэх, сурах зүйлийг баримжаалах	CLO [2.4, 3.2]
Суралцагч, тэдний сурах үйл ажиллагаанд ажиглалт хийх	CLO [1.3, 2.3, 3.1]
Цаашдын өөрийн сурч хөгжих үйлийг төлөвлөх	CLO [2.4, 3.2]

Хүснэгт 2. Хичээлийн төлөвлөгөө

Нийт цаг: 32 цаг

7 хоног	Сэдэв	Практик
12	ЕБ-ын сургуулийн эрхэм зорилго, үйл ажиллагаатай танилцах	6
13	Багшийн үйл ажиллагааны чиглэлтэй танилцах	8
14	Багшлахуйн талаарх цаашдын мэдэх, сурах зүйлийг баримжаалах	4
15	Суралцагч, тэдний сурах үйл ажиллагаанд ажиглалт хийх	8
16	Цаашдын өөрийн сурч хөгжих үйлийг төлөвлөх	6
Нийт цаг		32

Үнэлгээ:

№	Үнэлгээний хэлбэр	Эзлэх хувь	Багтаамж
1	Ирц, оролцоо	10%	Дадлага гарсан давтамж 10-с доошгүй удаагийн давтамжтай байна. ЕБС-ийн дадлагын зөвлөх багш ирсэн өдөр цагийг бүртгэж 10 удаа ирсэн бол 100 хувь гэж тооцно. Ерөнхий үнэлгээний 10%-ийг эзэлнэ.
2	Дадлагын дэвтрийн хөтлөлт, дадлагын сан	50%	- Дадлагын дэвтэр хөтлөлт-10% - Дадлагын сан -30% - Өөрийн үнэлгээ-10%
3	Эцсийн үнэлгээ	40%	- ЕБС-ийн дадлагын зөвлөх багшийн үнэлгээ-20% - МУБИС-ийн дадлагын зөвлөх багшийн үнэлгээ-20%

СУДЛАХ ДАДЛАГА (Т.ТР255) ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА

Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага (CLO):

1. Мэдлэг

- 1.1. Хүүхэд судлах аргуудыг ЕБС-ийн бодит нөхцөлд хэрэглэх онцлог, хүүхдэд зөвлөн туслах үйл ажиллагааны чиглэлийг хэрхэн боловсруулахыг мэдэх [PLO 1.1.5, 1.1.6, 2.1.1, 2.1.2, 3.1.1, 3.1.2]
- 1.2. Багшийн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох [PLO 1.1.5, 1.1.6, 2.3.1, 2.3.6, 3.4.2]

2. Чадвар

- 2.1. Багшийн өдөр тутмын үйл ажиллагааг ажиглаж, тэмдэглэл зөв хөтлөх аргад суралцах, багшийн хөтөлдөг баримт бичигт задлан шинжилгээ хийж, дүгнэлт гаргах [PLO 2.3.1, 2.3.6, 3.3.2]
- 2.2. Суралцагчдын судлах, оношлох, судалгааны үр дүнг боловсруулах, тэмдэглэл хөтлөх [PLO 1.1.5, 1.1.6, 2.1.3, 2.4.5, 3.1.1, 3.1.2]
- 2.3. Нэг ангийг сонгон авч сэтгэл зүйн үүднээс ажиглан судлах ба сургууль, анги танхимын орчинд хүүхдийн эрхийн хэрэгжилтийг ажиглаж, үр дүнг боловсруулах [PLO 1.1.5, 1.1.6, 2.2.6, 3.4.1, 3.4.3]

3. Хандлага

- 3.1. Судалгаа хийх ёс зүйн хэм хэмжээг баримтлах, аливаа асуудалд шинжлэх ухааны үндэстэй ханддаг, судлан шинжлэх явцдаа ёс зүйтэй байх [PLO 1.1.5, 1.1.6, 2.2.6, 3.3.1]
- 3.2. Судалгааны үр дүнг хүүхэд бүрийг хөгжүүлэхэд ашиглах эрмэлзэлтэй болох [PLO 1.1.2, 2.2.5, 2.2.6, 3.3.1]

Үнэлгээний жин, хэлбэр:

Ирц, оролцоо: 10%

Дадлагын дэвтрийн хөтлөлт, дадлагын сан: 50%

Эцсийн үнэлгээ: 40%

Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр, код: Судлах дадлага, Т.ТР255
Улирал: II дамжааны хаврын улирал
Хичээлийн задаргаа: 0:0:0:4(3). (практик)
Заах багш: Н.Цогзолмаа, Б.Мягмаржав, Г.Бямбатогтох, Г.Энхжаргал, Т.Энхмаа, Ч.Нямсүрэн,
И-мэйл хаяг: tsogzolmaa.n@msue.edu.mn
yarus2020@yahoo.com, byambatogtokh@msue.edu.mn,
eegii2015@gmail.com, t.enkhmaa@msue.edu.mn
nyamsurenchuluundorj@gmail.com
Утас: (976)-70112429
Ажлын өрөө: 5-208
Ажиллах цаг: Даваа–Баасан, 9:00 am – 18:00 pm.
Үндсэн сурах бичиг:

1. Ичинхорлоо, Ш. (2013). Сургалтын онол, хэрэглээ. Улаанбаатар: Мөнхийн үсэг
2. Мягмар О., Оюунгэрэл С. (2022). Боловсролын сэтгэл судлал. Улаанбаатар: Мөнхийн үсэг

Нэмэлт унших материалууд:

1. Туяа Б. (2013) Сэтгэл судлалын хичээлийн бодлого дасгалын хураамж. Улаанбаатар: Мөнхийн үсэг
2. Эрдэнэчулуун Д, (2010) Хүүхдийг судлах арга зүй, I, II дэвтэр. Улаанбаатар:Ганпринт
3. Эрдэнэцэцэг С. (2018). Багшлахуй: Зарчим ба хандлага. Содпресс ХХК
4. Эрдэнэцэцэг С., Хонгорзул Б. (2017). Суралцахуй: Үзэл баримтлал ба хандлага. Содпресс ХХК

Хичээлийн залгамж, холбоо: Туршин заах дадлага, Т.ТР275

Хичээлийн товч тодорхойлолт: Оюутан танхимд үзсэн Ерөнхий сэтгэл судлал, Боловсролын сэтгэл судлал, Суралцахуй ба багшлахуйн үндэс хичээлийн агуулгаа энэхүү дадлагаар бататгадаг.

Хичээлийн зорилго: Хүүхдийн хөгжил төлөвшил, сэтгэл зүйн онцлог, анги-бүлгийн сэтгэл зүйн уур амьсгал, багш-суралцагчийн харилцааг сэтгэл зүйн үүднээс ажиглан судлах чадварыг эзэмших.

Агуулга: Дадлагын явцад оюутан багш сурагч, багшийн үйл ажиллагааг судлах аргуудыг судалж, түүнийг практикт хэрэглэх аргад суралцана.

Хичээлийн сургалтын арга зүй: Дадлага нь оюутны бие даасан бүтээлч үйл ажиллагаанд суурилна. Оюутан төлөвлөсний дагуу үйл ажиллагаа хэрэгжүүлэх, түүнийгээ эргэцүүлэх, алдаа болон бэрхшээлтэй асуудлаа олох, дахин сайжруулах гэсэн үе шаттайгаар ажиллана.

Хүснэгт 1. Үр дүнгийн хамаарал

Дадлагын үйл ажиллагаа	Дадлагаар эзэмших мэдлэг, ур чадвар
Дадлагын хугацаанд ЕБС-ийн () нэг ангийг сонгон авч сэтгэл зүйн үүднээс ажиглан судлах	CLO [1.1, 2.2, 2.3, 3.1, 3.2]
Хүүхдийн хөгжил төлөвшлийн тодорхой асуудлыг сэтгэл зүйн үүднээс судалж, эргэцүүлэл дүгнэлт хийсэн байх	CLO [2.2, 3.1, 3.2]
Сурагчийн хичээл дээрх үйл ажиллагааг ажиглах, суралцах хэв маяг болон суралцах арга барилыг ажиглалт, асуулга, даалгавар,	CLO [1.1, 2.2, 3.1, 3.2]

сорилын гүйцэтгэлээр судлах	
Багшийн үйл ажиллагаа, түүний сурган хүмүүжүүлэх ур чадвар, эв дүй, хичээлийн цаг ашиглалтад тулгарч буй асуудлыг тодорхойлох, шийдвэрлэх боломжит хувилбарыг дэвшүүлэх	CLO [2.1, 2.3, 3.1, 3.2]

Хүснэгт 2. Дадлагын төлөвлөгөө

Нийт цаг: 64 цаг

7 хоног	Сэдэв	Практик
1-2	Дадлагын бэлтгэл	4
3-4	Дадлагаар хийх үйл ажиллагаатай танилцах	4
5-13	Дадлагын үндсэн үйл ажиллагаа(сурагч, анги, багшийн үйл ажиллагааг судлах)	48
14-16	Дадлагын тайлан	8
Нийт цаг		64

Үнэлгээ:

№	Үнэлгээний хэлбэр	Эзлэх хувь	Багтаамж
1	Ирц, оролцоо	10%	- Тогтсон хугацаанд ЕБС-ийн багш, суралцагч, эцэг эхээс судалгааны мэдээлэл цуглуулах, хамтран ажиллах -5%, - ЕБС болон МУБИС-ийн зөвлөх профессорын зөвлөгөөнд хамрагдах, дэмжлэг авах -5%
2	Дадлагын дэвтрийн хөтлөлт, дадлагын сан	50%	- Дадлагын дэвтрийн хөтлөлт (10%) - Дадлагын сан бүрдүүлэлт (25%) ✓ Дадлагын төлөвлөгөө гаргаж, түүнийг хэрэгжүүлсэн байдал ✓ Гүйцэтгэсэн судалгааны тайлан, бусад баримт бичгийн бүрдүүлэлт (дадлагын дэвтэр болон бүтээлийн сан бүрдүүлэлт) ✓ Гүйцэтгэсэн ажлаа цаг тухайд нь ЕБС болон МУБИС-д тайлагнасан байдал - Өөрийн үнэлгээ (15%)
3	Эцсийн үнэлгээ	40%	- ЕБС-ийн багшийн үнэлгээ (10%) - МУБИС-ийн багшийн үнэлгээ (10%) - Тайлан хамгаалалтын комиссын үнэлгээ (20%)

ЗӨВ ДУУДАХ, ЗӨВ БИЧИХ ЗҮЙ (TML310) ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА

Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага (CLO):

1. Мэдлэг

- 1.1. Хэлний авианы онцлог, авиа, авиалбарын ялгаа, өгүүлэх ба сонсгол зүйн шинж, авиа-үсгийн үүрэг, авианы өөрчлөлт, хувьслыг мэдэх, эгшиг ба гийгүүлэгч авианы хэлэхүйн онцлогийг харьцуулах [PLO 1.1.6, 1.2.1, 2.2.5, 2.5.3, 3.2.1]
- 1.2. Утга зохиолын хэлний зөв бичих хэм хэмжээ, зөв дуудах хэм хэмжээг мэдэх, кирилл бичгийн зөв бичих дүрмийг уялдаа холбоонд нь интеграцчилан ойлгох [PLO 1.1.6, 1.2.1, 2.2.5, 2.5.3, 3.2.1]

2. Чадвар

- 2.1. Авиа, авиалбарыг ялгах, авиа үсгийн үүрэг, эгшиг ба гийгүүлэгч авиалбарын хэл, хэлэхүйн онцлогийг тодорхойлох, эгшиг ба гийгүүлэгч авианы нэр, дуудлагыг ялган, зөв дуудахдаа өгүүлэх эрхтний оролцоог тайлбарлах [PLO 1.1.6, 1.2.1, 2.2.5, 3.2.1]
- 2.2. Зөв дуудах ба зөв бичих хэм хэмжээний дагуу үгийг зөв дуудах, зөв бичих, үгийн дуудлага ба зөв бичлэгийг ялгах, кирилл бичгийн зөв бичих дүрэмд үүсэх уялдаа холбоог тайлбарлах, эх бичвэрт зөв бичих зүйн шинжилгээ хийх, зөв, буруу бичсэн үгийг ялгах, тохирох дүрмээр нотлох зэргээр зөв бичих чадвараа сайжруулах [PLO 1.1.6, 1.2.1, 2.2.5, 3.2.1]

3. Хандлага

- 3.1. Утга зохиолын хэлний зөв дуудах, зөв бичих хэм хэмжээнд суралцах, өөрийн эзэмшсэн чадвар дадлаар дамжуулан, бага ангийн сурагчдын зөв дуудах, зөв бичих чадварыг хөгжүүлэх хүсэлтэй болох [PLO 1.1.6, 1.2.1, 3.2.1]
- 3.2. Зөв дуудах, зөв бичих зүйн хэм хэмжээг зөрчсөн аливаа тохиолдолд шүүмжлэлтэй хандах, түүнийг засан сайжруулахад анхаарах, улмаар багшлах үйлээ хэл шинжлэлийн онолын үндэслэлтэй явуулах эрмэлзэлтэй болох. [PLO 1.1.6, 1.2.1, 2.2.5, 2.5.3, 3.2.1]

Үнэлгээний жин, хэлбэр:

Ирц, оролцоо: 10%

Бие даалтууд: 60%

Явцын сорил: 30%

Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр, код:	Зөв дуудах, зөв бичих зүй (TML310)
Улирал:	I дамжааны хаврын улирал
Хичээлийн задаргаа:	0:4:0:0(2) семинар
Заах багш:	Н.Даваасүрэн
Е-мэйл хаяг:	davaasuren.n@msue.edu.mn
Утас:	(976)-70112429
Ажлын өрөө:	5 – 201
Ажиллах цаг:	Даваа-Баасан, 8:40 am - 18:00 pm.
Үндсэн сурах бичиг:	

1. Даваасүрэн, Н. (2023). Зөв дуудах, зөв бичих зүй, УБ, Бит пресс

Нэмэлт унших материалууд:

1. БСШУСЯ (2019). Бага боловсролын сургалтын хөтөлбөр (сайжруулсан хоёр дахь хэвлэл) УБ
2. Бямбацэрэн, Г. (2020). Эх хэлний цагаан толгойд суралцахуйн онол, арга зүй, УБ
3. Даваасүрэн, Н. (2021). Чадварын үнэлгээний дэвтэр. УБ
4. Дамдинсүрэн, Ц., Осор, Б. (1983). Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь, УБ
5. Бямбацэрэн, Г., Хажидмаа, В., Болормаа, Г., Лхамноржмоо, Б. (2019). Монгол хэл -2, УБ
6. Цэндсүрэн, Ө., Бигэрмаа, Р., Жаргалсайхан., П., Болормаа, У. (2019). Монгол хэл -3, УБ
7. Одсүрэн, П., Даваасүрэн, Н., Гэрэлсайхан., Б., Дашдолгор., Ц. (2019). Монгол хэл -4, УБ
8. Олзвой, Л., Отгонцэцэг., Ш., Энхжаргал., М., Оюунцэцэг., Б. (2019). Монгол хэл -5, УБ
9. МУИС, МСХ (2018). Сурагчийн монгол хэлний тайлбар толь (бага анги), УБ
10. ХБҮЗ (2018) Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь, УБ
11. ХБҮЗ (2018) Сурагчийн тайлбар толь, УБ
12. Одсүрэн, П. (2020). Бага ангийн багш нарт (Монгол хэлний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөмж) УБ
13. Оюун, Ц. (2019). Зөв бичгийн дүрмийн тогтолцоот хураамж. УБ
14. МУБИС, ХНУС. (2020). Орчин цагийн монгол хэл. УБ, I дэвтэр
15. Санжаа, Ж. (2008). Орчин цагийн монгол хэлний авиа зүй, авиалбар зүй. УБ
16. Санжаа, Ж. (2011). Авиа – авиалбар – их авиалбар. УБ
17. Самбуудорж, Б. (2016). Монгол хэлний зөв дуудлагын толь, УБ

Цахим эх сурвалж

<https://medle.mn/> (Цахим сурах бичиг)
<http://toli.gov.mn/> (Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь)
<http://www.mier.mn/wp-content/uploads/2020/03/Baga-bolovsroliin-mongol-khel.pdf>
(бага боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамж Монгол хэл I-Ү анги)
<https://cdn.greensoft.mn/uploads/users/2649/files/Curriculum/EBS/Baga.pdf> (Бага боловсролын сургалтын хөтөлбөр (сайжруулсан хоёр дахь хэвлэл, 2019))

Хичээлийн залгамж, холбоо: Үгийн сан (T.ML302)

Хичээлийн товч тодорхойлолт: Уг хичээл нь багш, бага ангийн боловсрол хөтөлбөрийн мэргэжлийн заавал судлах хичээл болно.

Хичээлийн зорилго: Хэлний авианы хэл хэлэхүйн онцлогийг мэдэж, авиаг зөв дуудаж сурах, кирилл бичгийн зөв бичих дүрмийн уялдаа холбоонд нь тулгуурлан, зөв бичих дүрмийн мэдлэг, чадвараа сайжруулах, бага ангийн сурагчдад авиа үсэг, зөв бичих дүрэм таниулахад шаардагдах онолын асуудлуудыг гүнзгийрүүлэн судлахад оршино.

Агуулга: **Зөв дуудах зүй** (Хэлний авианы өгүүлэх ба сонсгол зүйн шинж, эгшиг ба гийгүүлэгч авиалбарын бүрэлдэхүүн, ялгаруулах шинж, хэлний авиаг зөв дуудах нь, зөв дуудах ёс, түүний хэм хэмжээ), **зөв бичих зүй** (зөв бичих зүй, түүний хэм хэмжээ, кирилл бичгийн зөв бичих дүрмийн тогтолцоо, тэдгээрийн хооронд үүсэх гадаад ба дотоод интеграц) зэрэг агуулгыг судална.

Хичээлийн сургалтын арга зүй: Хичээлийг оюутны бүтээлч оролцоонд тулгуурлан явуулахад анхаарч, идэвхтэй сургалтын аргууд, тайлбартай дасгалын арга, тонгоруу сургалтын арга, тоглоомын арга зэрэг оюутны оролцоо, бие даан суралцахуйг дэмжсэн арга зүйг чухалчилна.

Хүснэгт 1. Үр дүнгийн хамаарал

Хичээлийн төлөвлөлт	Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадварууд
Хэлний авиаг судлах нь	CLO [1.1, 1.2, 2.1, 2.2, 3.1, 3.2]
Эгшиг авиалбар, түүнийг зөв дуудах нь	CLO [1.1, 1.2, 2.1, 2.2, 3.1, 3.2]
Гийгүүлэгч авиалбар, түүнийг зөв дуудах нь	CLO [1.1, 1.2, 2.1, 2.2, 3.1, 3.2]
Зөв бичих зүй, зөв бичих дүрмийн тогтолцоо	CLO [1.1, 1.2, 2.1, 2.2, 3.1, 3.2]

Хүснэгт 2. Хичээлийн төлөвлөгөө

Нийт цаг: 64 цаг

7 хоног	Сэдэв	Семинар
1-2	Хэлний авиаг судлах нь	8
3-4	Эгшиг авиалбар, түүнийг зөв дуудах нь	10
5-6	Гийгүүлэгч авиалбар, түүнийг зөв дуудах нь	8
7-16	Зөв бичих зүй, зөв бичих дүрмийн тогтолцоо	38

Үнэлгээ:

№	Үнэлгээний хэлбэр	Эзлэх хувь	Агуулга
1	Ирц, оролцоо	10%	Оюутнууд танхимын сургалтад бүрэн хамрагдсан байх ба үүнийг 5 оноогоор үнэлнэ. Хичээлийн оролцоог семинарын сэдэвтэй холбоотой зайлшгүй гүйцэтгэх дасгал, даалгавруудыг хийсэн байдал, семинарын хичээлийн хэлэлцүүлэг удирдах, мэдээлэл хийсэн зэргийг харгалзан, 5 оноогоор үнэлнэ.
2	Бие даалтууд (60%)	20%	Хэлний авианд авиа зүйн задлал хийх
		30%	Бага боловсролын монгол хэлний сургалтын хөтөлбөр, сурах бичигт “Зөв бичих дүрэм, зөв бичих чадвар” агуулгын хүрээнд анализ хийх
		10%	Эх бичвэрт зөв бичих зүйн анализ хийх
3	Явцын сорил I, II	15%	1-12 дугаар семинарын агуулгаар I сорил (Түвшинчилсэн тест, даалгаврын хувийг тооцно)
		15%	12-32 лекцийн агуулгаар II сорил (Багшийн санал болгосон агуулгаас аль нэгийг сонгон гүйцэтгэнэ.)

ҮГИЙН САН (Т.МЛ302) ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА

Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага (CLO):

1. Мэдлэг

- 1.1. Үг ба үглэврийн ялгааг мэдэх, үгийн сангийн үндсэн нэгжүүдийг таних, утгыг ухаарах, гадаад ба дотоод талыг ялгах, мэдэх, үгийн сан- утга зүйн айг бүрдүүлэх утгуудын мөн чанарыг ойлгох [PLO 1.2.1, 2.2.5, 2.5.3, 3.2.1]
- 1.2. Хүний болоод газар усны нэрийн учир, бэлгэдлийг мэдэх, монголчуудын нэр цээрлэх ба эерүүлэх ёсны учир холбогдлыг ойлгох, хэлц үгийн утгыг тодорхойлох, өвөрмөц ба хэвшмэл хэлцийн ялгааг мэдэх, хэлц үгийг ангилах, бүлэглэх [PLO 1.1.6, 2.2.5, 2.5.3, 3.2.1]
- 1.3. Шинэ, хуучин үг, уугуул үг, харь хэлний үг, мэргэжлийн болоод нутгийн аялгууны үг зэрэг утга зүйн үзэгдлийг ялган таних, утга зохиолын хэлний нормд хязгаарласны учрыг мэдэх, үг хуучрах, шинээр бий болох зүй тогтлыг ухаарах, уугуул үг ба харь хэлний үгийн ялгааг ойлгох [PLO 1.1.6, 2.2.5, 2.5.3, 3.2.1]

2. Чадвар

- 2.1. Үг ба үглэврийг ялгах, үгийг үгийн сангийн үндсэн нэгжид хувиргах, үгийг үгийн сан –утга зүйн айгаар ангилах, харьцуулах, багцлан бүлэглэх, үгийн утгыг хам сэдвээс болон тайлбар толь бичиг ашиглан тайлбарлах, үгийг найруулгад оновчтой сонгон хэрэглэх [PLO 1.2.1, 2.2.5, 2.5.3, 3.2.1]
- 2.2. Хүний болон газар усны нэрийн учир, бэлгэдлийг хам сэдвээс болон толь бичиг ашиглан тайлбарлах, ерийн нэр ба цээрлэсэн үгийг ялгах, харьцуулах, ижил ба ялгаатай талыг тодруулах, бүлэглэх, найруулгад оновчтой хэрэглэх, хэлц үгийн утгыг хам сэдвээс болон толь бичиг ашиглан тайлбарлах, аливаа эх зохиохдоо хэлц үг ашиглах [PLO 1.1.6, 1.2.1, 2.5.3, 3.2.1]
- 2.3. Шинэ, хуучин үг, уугуул үг, харь хэлний үг, мэргэжлийн болоод нутгийн аялгууны үгийг ялгах, харьцуулах, утгыг хам сэдвээс болон толь бичиг ашиглан тайлбарлах [PLO 1.1.6, 1.2.1, 2.2.5, 3.2.1]

3. Хандлага

- 3.1. Үгийн баялгаа нэмэгдүүлэх, эх хэлээрээ ойлгомжтой, утга төгөлдөр ярьж, бичих соёлоо дээшлүүлэх хүсэлтэй болох [PLO 1.2.1, 2.5.3, 3.2.1]
- 3.2. Үгийн утгаар дамжуулан, бага ангийн сурагчдын үгийн санг баяжуулах, унших, бичих чадварыг сайжруулахад нэн чухал үүрэгтэй болохоо ухамсарласан байх [PLO 1.1.6, 1.2.1, 2.2.5, 2.5.3, 3.2.1]

Үнэлгээний жин, хэлбэр:

Ирц, оролцоо: 20%

Бие даалтууд: 50%

Явцын сорил: 30%

Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр, код:	Үгийн сан (Т.МЛ302)
Хичээлийн задаргаа:	1:2:0:0(3), (Лекц, семинар)
Заах багш:	Н.Даваасүрэн, М.Энхжаргал
Е-мэйл хаяг:	davaasuren.n@msue.edu.mn Enkhjargal.m@gmail.com
Утас:	(976)-70112429, 99164152, 88067377
Ажлын өрөө:	5-207
Ажиллах цаг:	Даваа-Баасан, 8:40 am - 18:00 pm.
Үндсэн сурах бичиг:	

1. Даваасүрэн, Н., Энхжаргал, М. (2022) Үгийн сан судлал, УБ, Удам соёл хэвлэлийг газар

Нэмэлт унших материалууд:

1. Бадамдорж, Б. (2001). Монгол хэлний утга судлал, (II дэвтэр) УБ
2. Бадамдорж, Б. (2015.) Монгол хэлний үгийн сангийн утга зүй, УБ, (1-100, 153-159 тал)
3. Бадамдорж, Б. (1997) ОЦМХ-ний утга судлалын үндэс, УБ
4. Базаррагчаа, М. (2020). Монгол үгийн гарлыг мөшгөх нь, 7 боть, УБ
5. Баянсан, Ж. (2016) Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ, УБ
6. Гантогтох, Г. (2002) Монгол хэлний нутгийн аялгуу, УБ,
7. Лувсанжав, Чой. (1970). Орос-монгол өвөрмөц хэллэгийн толь, УБ
8. МУБИС, МоСС, (2020). Орчин цагийн монгол хэл, II дэвтэр, УБ
9. МУИС, Монгол судлалын хүрээлэн (2020). Монгол хэл судлалын түүх, II боть, Монгол хэлний үгийн сан, найруулга судлал, УБ, (107-108 тал)
10. Монсудар (2013). Монгол хэлний хоршоо үгийн толь, УБ,
11. Монсудар (2013). Монгол хэлний өвөрмөц хэлцийн толь, УБ
12. Монсудар (2013). Монгол хэлний хэвшмэл хэлцийн толь, УБ
13. Монсудар (2013). Монгол хэлний хуучин үгийн толь, УБ
14. Монсудар (2013). Монгол хэлний шинэ үгийн толь, УБ
15. Монгол хэлний нутгийн аялгууны толь
16. Нансалмаа, Н. (2015). Үгийн сан судлал, УБ
17. Нарантуяа, Ш. (2015). Монгол хэлц үгийн тайлбар толь, УБ
18. Пагва, Т. (1976). Хэлний шинжлэлийн удиртгал, УБ,
19. Сэржээ, С. (1992). Монгол хүний нэр, УБ
20. Төмөрцэрэн, Ж. (1974). Монгол хэлний үгийн сангийн судлал, УБ, (27-31 тал)
21. Чоймаа, Ш., ба бус (2012). Монгол хүний нэрийн толь (Кирилл-монгол тайлбартай), УБ
22. Энхжаргал, С. (2019). Монгол хэлцийн тайлбар толь, УБ

Цахим эх сурвалж:

www.mongoltoli.mn
www.mier.mn
www.content.edu.mn

Хичээлийн залгамж, холбоо: Сургуулийн хэл зүй, Т.МЛ308

Хичээлийн товч тодорхойлолт: Уг хичээл нь багш, бага ангийн боловсрол хөтөлбөрийн мэргэжлийн заавал судлах хичээл болно.

Хичээлийн зорилго: Үгийн дотоод тал буюу утгыг нарийвчлан судалж, үгийн утгыг хам сэдвээс болон толь бичиг ашиглан тайлбарлах, үг ба хэлц үгэнд утгын хувиргал хийх зэрэг чадварт суралцан, улмаар бага ангийн сурагчдыг хэл зүй-үгийн сангийн чадвар эзэмшүүлэхэд шаардагдах онолын асуудлуудыг гүнзгийрүүлэн судлахад оршино.

Агуулга: Үг, үглэвэр, үг, ухагдахуун, үгийн сан- утга зүйн ай, хэлц үг, үгийн сангийн үүсвэр ба найруулга бүрэлдэхүүн зэрэг агуулгыг судална.

Хичээлийн сургалтын арга зүй: Хичээлийг оюутны бүтээлч оролцоонд тулгуурлан явуулахад анхаарч, идэвхтэй сургалтын аргууд, тайлбартай дасгалын арга, тонгоруу сургалтын арга, тоглоомын арга зэрэг оюутны оролцоо, бие даан суралцахуйг дэмжсэн арга зүйг чухалчилна.

Хүснэгт 1. Үр дүнгийн хамаарал

Хичээлийн төлөвлөлт	Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадварууд
Бүлэг 1. Үгийн утга, үгийн сан- утга зүйн ай	(CLO 1.1, 1.2, 2.1, 2.2, 3.1, 3.2)
Бүлэг 2. Хэлц судлал, нэр зүй, нэр цээрлэх ёс, эерүүлэх ёс	(CLO 1.3, 2.3, 3.1, 3.2)
Бүлэг 3. Үгийн сангийн найруулга ба үүсвэр бүрэлдэхүүн	(CLO 1.4, 2.4, 3.1, 3.2)

Хүснэгт 2. Хичээлийн төлөвлөгөө

7 хоног	Сэдэв	Лекц	Семинар
1-2	Үгийн утга ба үгийн сангийн үндсэн нэгж	2	4
3-8	Үгийн сан –утга зүйн ай	6	12
9-12	Хэлц судлал ба нэр зүй	4	8
13-16	Үгийн сангийн үүсвэр ба найруулга бүрэлдэхүүн	4	8
Нийт		16	32

Үнэлгээ:

№	Үнэлгээний хэлбэр	Эзлэх хувь	Багтаамж
1	Ирц, оролцоо	20%	Оюутнууд танхимын сургалтад бүрэн хамрагдсан байх ба үүнийг 5 оноогоор үнэлнэ. Хичээлийн оролцоог семинарын сэдэвтэй холбоотой зайлшгүй гүйцэтгэх дасгал, даалгавруудыг хийсэн байдал, семинарын хичээлийн хэлэлцүүлэг удирдах, мэдээлэл хийсэн зэргийг харгалзан, 5 оноогоор үнэлнэ.
2	Бие даалтууд	50%	Бие даалтыг 2 удаа гүйцэтгэнэ: - Бага боловсролын монгол хэлний сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж, сурах бичигт “Үг, түүний утга” агуулгын хүрээнд анализ хийх -30 оноо - Сонгосон үгэнд утга зүйн хувиргал хийх -30 оноо
3	Явцын сорил I, II	30%	- Үгийн сан- утга зүйн ай -15 оноо - Хэлц судлал, нэр зүй, нэр цээрлэх ба эерүүлэх ёс, үгийн сангийн үүсвэр ба найруулга бүрэлдэхүүн -15 оноо

СУРГУУЛИЙН ХЭЛ ЗҮЙ (Т.МЛ308) ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА

Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага (CLO):

1. Мэдлэг

- 1.1. Хэл зүй, түүний үндсэн ойлголт, үг өгүүлбэрийн утга, үүрэг, хэлбэрийн ангиллыг ойлгож мэдэх [PLO 1.2.1, 3.2.1]
- 1.2. Үг, өгүүлбэрт утгын болон бүтцийн хувиргал хийх аргуудыг таних, утга, бүтцийн хувиргалын ялгааг мэдэх [PLO 1.2.1, 3.2.1]
- 1.3. Үг, өгүүлбэрийн найруулгын түвшинг ялгах, зөв бичих, онож хэрэглэхийн мөн чанарыг ойлгох, ухаарах [PLO 1.2.1, 3.2.1]

2. Чадвар

- 2.1. Үг, өгүүлбэрийг утга, үүрэг, хэлбэрээр нь ангилах, хувиргах, жишээгээр батлан тайлбарлах [PLO 1.1.6, 1.2.1, 2.1.2, 3.2.1]
- 2.2. Үг, өгүүлбэрт бүтцийн бүрэн задлан ялгал хийх, тайлбарлах, загварчлалын дагуу хувиргал хийх, ярих бичигт хэрэглэх [PLO 1.2.1, 2.4.2, 3.2.1]
- 2.3. Хэлний нэгжүүдийг соёл, уламжлалт сэтгэлгээтэй холбон найруулах, эсээ бичих аргад суралцах [PLO 1.2.1, 1.2.2, 3.2.1]

3. Хандлага

- 3.1. Хэл шинжлэлийн онолын мэдлэг эзэмшин, багшлах үйл ажиллагааг онолын өндөр түвшинд үндэслэлтэй явуулах эрмэлзэл хандлагатай болох [PLO 1.2.1, 3.2.1]
- 3.2. Төрөлх хэлээрээ дамжуулан, хойч үеийнхний эх хэлний дархлааг хадгалахад нэн чухал үүрэгтэй гэдгээ ухаарч, бичгийн соёлоо дээшлүүлэх хүсэл эрмэлзэлтэй байх [PLO 1.2.1, 1.2.2, 3.2.1]

Үнэлгээний жин, хэлбэр:

Ирц, оролцоо: 20%

Бие даалтууд: 50%

Явцын сорил: 30%

Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр, код: Сургуулийн хэл зүй (Т.МЛ308)
Улирал: хаврын улирал
Хичээлийн задаргаа: 1:4:0:0 (5) (семинар)
Заах багш: П.Жаргалсайхан
Е-мэйл хаяг: jargalsaikhan.p msue.edu.mn
Утас: (976)-70112429
Ажлын өрөө: 5- 101, 315
Ажиллах цаг: Даваа-Баасан, 8:40am-18:00pm

Үндсэн сурах бичиг:

1. Батчулуун.Д., (2009) Хэл шинжлэлийн удиртгал Уб:
2. Бямбацэрэн. Г., Жаргалсайхан, П., (2019) Өгүүлбэр /онол дадлага /.
3. Бямбацэрэн. Г., Жаргалсайхан, П., (2019) Үг /онол дадлага /
4. Бямбацэрэн, Г.,(2013) Хэлний сургалт ба танин мэдэхүй.
5. Өнөрбаян.Ц., (2004)Орчин цагийн монгол хэлний үг зүй
6. Пүрэв-Очир ,Б., (2001) Орчин цагийн монгол хэлний өгүүлбэр зүй
7. Цэдэнбал,Ч., Бямбацэрэн,Г, (2010) Бага боловсролын монгол хэл, бичиг уран зохиолын онол, дидактик

Нэмэлт унших материалууд:

1. Барайшир.С., , (1989) ОЦМХ-ний өгүүлбэр зүй Уб,
2. Базаррагчаа.М., (2005) Монгол хэлний өгүүлбэр, Уб,
3. Дамдинсүрэн.Ц., (1969) Үсгийн дүрмийн толь
4. Мөнх-Амгалан.Ю., Кан Шин (2014) ОЦМХ-ний бүтээвэр судлал, Уб,
5. МУБИС, НХУС, (2020) ОЦМХ, I, II дэвтэр Уб.
6. МУИС, (2017) Нийтээр эзэмших монгол хэл, Уб,
7. Пагва.Т., (2016) Хэлний шинжлэлийн удиртгал, Уб,
8. Пүрэвжав.Б., (2001) Товчилсон үгийн толь, Уб
9. Төмөртоого.Д., (2014) Монгол хэлний үгийн бүтцийн толь, Уб,

Цахим ном, сурах бичиг:

- www.e-nom.mn
- <http://mongolmedleg.org/>
- www.muzo.mn/
- [http://ulgerch.blogspot.com/ Цахим үлгэр](http://ulgerch.blogspot.com/)
- www.econtent.edu.mn
- <https://econtent.edu.mn/lessons/EBS/2rangi/mon/3358>
- <https://econtent.edu.mn/lessons/EBS/4rangi/mon/3828>

Залгамж холбоо:

Хичээлийн товч тодорхойлолт:

Бага боловсролын багшийн мэргэжлийн түвшинд монгол хэлний боловсролын агуулгын хүрээнд эзэмшвэл зохих үг, өгүүлбэр судлалын ойлголтыг судалж эзэмших, гүнзгийрүүлэх, судалгаа хийх, бага ангид заах арга зүйн боловсруулалт хийх , хэлний шинжлэх ухааны үндсийг таньж, зааж сургах түвшинд эзэмшсэн байна.

Хичээлийн зорилго:

Орчин цагийн монгол хэлний хэл зүйн үндсэн ойлголтуудын нэг болох үг, өгүүлбэрийн утга, бүтэц, хувиргал, соёл айг эзэмшихдээ алхам алхмаар агуулга, арга зүйг өргөжүүлэн судалж, дөрвөн айн түвшинд цогц мэдлэг, чадвартай болсон байхад оршино.

Агуулга:

Орчин цагийн монгол хэлний бүтэц, зохион байгуулалт, үг, өгүүлбэрийн утга, бүтэц, хэрэглээг найруулгын бүх түвшинд задлах, хувиргал хийх, улмаар бага боловсролын цөм хөтөлбөрийн агуулгын хүрээнд нийцүүлэн жишиг даалгавар боловсруулан, түүнийгээ заах арга зүйн боловсруулалт хийхэд суралцана.

Хичээлийн сургалтын арга зүй: Идэвхтэй сургалтын интерактив ба чадваржуулах когнитив, конструктив онолын баримтлалаар сургалтыг хөтөлнө.

Хүснэгт 1. Үр дүнгийн хамаарал

Хичээлийн төлөвлөлт	Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадварууд
Үг судлал	CLO [1.1, 1.2, 1.3, 2.1, 2.2, 3.1, 3.2]
Өгүүлбэр судлал	CLO [1.1, 1.2, 1.3, 2.1, 2.2, 3.1, 3.2]

Хүснэгт 2. Хичээлийн төлөвлөгөө

Нийт цаг: 80 цаг

7 хоног	Сэдэв	Лекц	Семинар
1-2	Хэл зүй түүний үндсэн ойлголт	2	8
3-4	Үгийн бүтэц ай	2	8
5-6	Үгийн хувиргал, соёл ай	2	8
7-8	Өгүүлбэрийн утга ай	2	8
9-10	Өгүүлбэрийн бүтэц ай	2	8
11-12	Монгол хэлний өгүүлбэрийн гишүүд	2	8
13-14	Өгүүлбэрийн хэв шинж	2	8
15-16	Өгүүлбэрийн хувиргал, соёл ай	2	8
Нийт цаг		16	64

Үнэлгээ:

№	Үнэлгээний хэлбэр	Эзлэх хувь	Багтаамж
1	Ирц, оролцоо	20%	Лекц, семинарын хичээлд суусан ирц, семинарын сэдэвтэй холбоотой гүйцэтгэх ёстой дасгал даалгаврыг хийсэн байдал болон идэвх, оролцоог 20%-иар тооцно.
2	Бие даалтууд	50%	Бие даалтыг 2 удаа гүйцэтгэнэ: • Үгийг утга, бүтэц, хувиргал, соёл талаас задлал хийх - 25% • Өгүүлбэрийг утга, бүтэц, хувиргал, соёл талаас задлал хийх -25%
3	Явцын сорил I, II	30%	Бүлэг сэдвийн агуулгаар үнэлүүлэх явцын сорилыг 30%-иар тооцно. • Үгийн утга, бүтэц, хувиргал, соёл ай -10 оноо • Өгүүлбэрийн утга, хувиргал ай -10 оноо • Өгүүлбэрийн бүтэц, соёл ай -10 оноо

ҮНДЭСНИЙ БИЧИГ, СОЁЛ (Т.МЛ309) ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА

Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага (CLO):

1. Мэдлэг

- 1.1. Монгол бичгийн үсэг зүй, цагаан толгойн бүрэлдэхүүн болон үсэг бичих дэгийг судалж, зүй тогтлыг таньж мэдэх [PLO1.2.1, 3.2.2]
- 1.2. Монгол бичгийн зөв бичих зүйн онцлог, нэрийн ялгал болон үйлийн хувиллын зөв бичих дүрмийн тогтолцоог шинжлэн судлах, харьцуулах [PLO1.2.1, 3.2.2]

2. Чадвар

- 2.1. Монгол бичгийн үсэг бичих дэгийн дагуу эх бичвэрийг хичээнгүй, зөв бичих, бичих дэгийн мөн чанар, холбоо хамаарлыг тодорхойлох, тайлбарлах [PLO1.2.1, 1.2.2, 3.2.2]
- 2.2. Монгол аман өв соёл, эртний уран зохиолыг монгол бичгээр ойлгож унших, уншсанаа тайлбарлах, шинэ үгийн толь хөтлөх, нүдлэн тогтоох [PLO1.2.1, 1.2.2, 3.2.2]
- 2.3. Үндэсний бичиг, соёл, уламжлалт сэтгэлгээтэй холбоотой эрэл хайгуул, судалгаа хийх, МХТ болон бусад эх сурвалж ашиглан, мэдээлэл цуглуулах, боловсруулалт хийх, хэлэлцүүлэх [PLO PLO1.2.1, 1.2.2, 2.4.5, 3.2.2]

3. Хандлага

- 3.1. Үндэсний бичиг, соёлоо дээдлэх, түгээх, сурталчлах өөрийн гэсэн арга барил эзэмших, бие даан гүнзгийрүүлэн судлах хүсэл эрмэлзэлтэй болох [PLO1.2.1, 1.2.2, 2.2.1, 3.2.2]

Үнэлгээний жин, хэлбэр:

Ирц, оролцоо: 20%

Бие даалтууд: 50%

Явцын сорил: 30%

Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр, код:	Үндэсний бичиг соёл, Т.МЛ309
Улирал:	I дамжааны хаврын улирал
Хичээлийн задаргаа:	семинар: 0:2:0:0 (2)
Заах багш:	С.Гандэлгэр Т.МЛ13, Б.Булган Т.МЛ20
Е-мэйл хаяг:	gandelger.s@msue.edu.mn , bulgan@msue.edu.mn
Утас:	(976)-77774664
Ажлын өрөө:	5-р байр 207 тоот
Ажиллах цаг:	Даваа-Баасан, 8:40 am - 18:00 pm.

Үндсэн сурах бичиг:

1. Гандэлгэр, С, Мөнхжаргал, Х. (2020). Хүмүүн бичгээ дээдлэн сурах судар оршвой. Улаанбаатар: Удам соёл.

Нэмэлт унших материалууд:

1. Дамдинжав, Л, Надмид, Ж. (1983). Уйгаржин монгол бичгийн унших бичиг. I, II.
2. Улаанбаатар.
3. Цог-Очир, А. (2014). Монгол бичиг. Улаанбаатар: Битпресс.
4. Цэдэнбал, Ч. (2018). Хичээнгүй бичиг. Улаанбаатар: Адмон.
5. Надмид, Ж. (1990). Монгол бичгийн зөв бичих толь бичиг. Улаанбаатар: Эрдэм
6. Чулуунбор, Ш. (2002). Монгол бичиг заах аргын зарим асуудал. Улаанбаатар:
7. УБИС-ийн хэвлэх газар.
8. Осор, Б., Алтангэрэл, Б. (1991). Монгол бичиг. Улаанбаатар: Армийн хэвлэх үйлдвэр
9. Чоймаа, Ш., Найданжав, П. (1990). Монгол бичиг. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх газар.

Хичээлийн залгамж, холбоо:

Хичээлийн товч тодорхойлолт:

Үндэсний бичгийн үсэг зүй, цагаан толгойн бүрэлдэхүүн болон үсэг бичих дэг, зөв бичих дүрмийн тогтолцоо, түүний зүй тогтол, холбоо хамаарлын тухай мэдлэг эзэмшүүлж, монгол бичгийн үсэг бичих дэгийн дагуу эх бичвэрийг хичээнгүй зөв, цэвэр сайхан бичих, алдаагүй, зөв, ойлгож унших, уншсанаа тайлбарлах, шинэ үгийн толь хөтлөх зэрэг ур чадварт түшиглэн, гүнзгийрүүлэн судалж, үндэсний бичиг, өв соёлоороо бахархах, эх оронч үзэл, хандлага төлөвшүүлнэ.

Хичээлийн зорилго:

Оюутан бүр үндэсний бичиг, соёлоо дээдлэх, бахархах үзлийг өөртөө төлөвшүүлэн, монголчуудын уугуул мэдлэг, ойлголт, гүн ухаан, уламжлал, соёл, сэтгэлгээтэй холбоотой эрэл хайгуул, судалгаа хийх, үр дүнг хэлэлцүүлэх, үндэсний бичиг, соёлоо гүнзгийрүүлэн сурах, бие даан судлах арга ухаантай болоход оршино.

Агуулга:

Үндэсний бичгийн цагаан толгойн бүрэлдэхүүн болон үсэг бичих дэг, монгол бичгийн зөв бичих зүйн онцлог, нэрийн ялгал болон үйлийн хувиллын зөв бичих дүрмийн тогтолцоо, нэр ба үйл үндсүүдээс үг бүтээх дагаврын зөв бичихүй зэргийг судалсаар монгол бичгийн үсэг бичих дэгийн дагуу хичээнгүй зөв, цэвэр сайхан бичих онцлог, холбоо хамаарал, алдаагүй, зөв, ойлгож унших ухаан, гадаад үг тэмдэглэдэг галиг үсгийн зөв бичихүй, үндэсний бичиг, соёл, уламжлалт сэтгэлгээ, үндэсний бичиг, соёлоо дээдлэх, түгээх, сурталчлах арга барилтай болоход өөрийгөө бэлтгэж эхэлнэ.

Хүснэгт 1. Үр дүнгийн хамаарал

Хичээлийн төлөвлөлт	Хичээлээр эзэмших мэдлэг, чадвар, хандлага
Монгол бичгийн үсэг зүй, цагаан толгойн бүрэлдэхүүн болон эгшиг, гийгүүлэгч үсэг бичих дэг	CLO[1.1, 2.1
Монгол бичгийн зөв бичих зүйн онцлог, нэрийн ялгал болон үйлийн хувиллын зөв бичих дүрмийн тогтолцоо	CLO [1.2, 2.1
Монгол бичгийн үсэг бичих дэгийн дагуу эх бичвэрийг хичээнгүй зөв, цэвэр сайхан бичих, бичлэгийн янз бүрийн тиг бүхий эхийг алдаагүй, зөв, ойлгож унших, уншсанаа тайлбарлах	CLO [1.2, 2.1, 2.2, 2.3
Үндэсний бичиг, соёлоо эрхэмлэн дээдлэх, гүнзгийрүүлэн сурах, судлах арга барил, хүсэл эрмэлзэлтэй болох	CLO[2.2, 2.3 3.1

Хүснэгт 2. Хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө

7 хоног	Сэдэв	Семинар
1-6	Үндэсний бичгийн цагаан толгойн бүрэлдэхүүн тогтолцоо	12
7-16	Нэр ба үйлийн хувиллын зөв бичих зүй	20
Нийт		32

Үнэлгээ:

№	Үнэлгээний хэлбэр	Эзлэх хувь	Багтаамж
1	Ирц, оролцоо	20%	Семинарын хичээлд суусан ирцийг бүртгэж, 50%-иар тооцно. Хичээлийн явцад хийх дасгал даалгаврын гүйцэтгэлээр 10 оноо цуглуулах ба семинарын хичээлийн тэмдэглэл хөтөлсөн байдлыг харгалзан, 50%-иар тооцно.
2	Явцын сорил	30%	- Явцын сорил I. Семинарын хичээлийн 1-9 дүгээр сэдвийн хүрээнд, - Явцын сорил II. Семинарын хичээлийн 10-16 дугаар сэдвийн хүрээнд боловсруулсан 6 түвшний тест, сорилын авбал зохих онооноос хувийг тооцно. Үнэлгээний даалгаврын санд I түвшний тест 10%, II түвшний тест 10%, III түвшний тест 25%, IV түвшний тест 25%, V түвшний тест 15%, VI түвшний тест 15%-ийг эзэлсэн байна.
3	Бие даалт	50%	Бие даалтыг багаар хийж гүйцэтгэнэ. Багшийн санал болгох бие даалтын сэдвүүдээс нэг сэдэв сонгож, эрэл хайгуул, судалгаа хийнэ. Эрэл хайгуул, судалгааны явцад цуглуулсан мэдээлэлдээ тулгуурлан, контент бүтээж танилцуулах ба монголчуудын уугуул ойлголт, мэдлэг, гүн ухаан, уламжлал, өв, соёлын талаарх агуулгыг багтаан, МХТ болон платформ, аппликейшнийг оновчтой сонгож, ашигласан байна. Мөн багийн гишүүн бүр боловсруулалт хийсэн эх бичвэрээ монгол бичгээр хичээнгүй бичих ба эх бичвэр дэх үгсийг нүдлэн тогтоосон байна.

АМАН ЗОХИОЛ (Т.МЛ304) ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА

Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага (CLO):

1. Мэдлэг

- 1.1. Аман зохиолын төрөл зүйлийг таньж мэдэх, сурах, судлах ач холбогдлыг ухаарч мэдэх [PLO 1.1.5, 1.2.2, 3.2.5]
- 1.2. Хүүхдийн аман зохиолын төрөл зүйл, ялгарах онцлогийг тодорхойлох [PLO 1.1.5, 1.2.2, 3.2.5]

2. Чадвар

- 2.1. Монгол аман зохиолын төрөл зүйлийг хэлбэр, агуулгын талаас нь ангилах, зураглал хийх [PLO 1.1.5, 3.2.5]
- 2.2. Аман зохиолд шинээр боловсруулалт хийх, сэдэв утга, агуулга хэлбэр, дүрслэлийг задлан шинжлэх, дүгнэх, тайлбарлах [PLO 1.1.5, 2.1.2, 3.2.5]
- 2.3. Хүүхдийн аман зохиолыг сурагчдын нас сэтгэхүйн онцлогт тохируулан сонгож хэрэглэх, хичээл сургалтад хэрэглэх, баяжуулах [PLO 1.2.1, 3.2.5]

3. Хандлага

- 3.1 Монгол ардын аман зохиолоор бахархах, түүнд шингэсэн үндэсний өв соёлыг хадгалах, түгээн дэлгэрүүлэх хүсэл эрмэлзэлтэй болох [PLO 1.2.2, 3.2.2, 3.2.6]

Үнэлгээний жин, хэлбэр:

Ирц, оролцоо: 20%

Бие даалтууд: 50%

Явцын сорил: 30%

Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр, код:

Аман зохиол, Т.МЛ 304

Улирал:

IV дамжааны хаврын улирал

Хичээлийн задаргаа:

0:2:0:0(2), **семинар**

Заах багш:

Б.Нанжид, А.Амардалай

Е-мэйл хаяг:

nanjid@msue.edu.mn, Amardalai@msue.edu.mn

Утас:

(976)-70112429, 89114882

Ажлын өрөө:

МУБИС V байр 207 тоот

Ажиллах цаг:

Даваа-Баасан, 8:40 am - 18:00 pm.

Үндсэн сурах бичиг:

1. Нанжид, Б. Амардалай, А. (2022), Монгол ардын аман зохиол. Улаанбаатар: Соёмбо принтинг.
2. Сампилдэндэв, Х. Гаадамба, Ш. (1978), Монгол ардын аман зохиол. Улаанбаатар: УХГ.
3. Цэрэнсодном, Д. (2011), Монгол ардын аман зохиолын тайлбарт дээж бичиг. Улаанбаатар: Соёмбо принтинг.

Нэмэлт унших материалууд:

1. Дулам, С. (2007). Аман зохиолын онол. Улаанбаатар: Битпресс.
2. Сампилдэндэв, Х. (1980). Хүүхдийн аман зохиолын учир. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
3. <https://catalog.msue.edu.mn/>
4. <https://esan.mn/>

Хичээлийн залгамж, холбоо:

Хичээлийн товч тодорхойлолт: Монгол үндэстний аман зохиол, өв соёл, уламжлалт зан үйлийг судлах, суралцах.

Хичээлийн зорилго: Монгол ардын аман зохиолоор дамжуулан үндэстнийхээ үнэт зүйл, өв уламжлалтай танилцах, хэрэглэх, нийгэм соёлын шинэ нөхцөлд үндэстнийхээ оюуны соёл, сэтгэлгээний онцлогийг хадгалах, бага боловсролын заах арга зүйтэй холбон хэрэглэх.

Агуулга: Аман зохиолын онол туурвил зүй, хүүхдийн аман зохиол, аман зохиолын бусад төрөл зүйлүүд, аман билгийн дээж бүтээлүүдийг ЕБС-ийн бага ангийн сурагчдын танин мэдэх үйлийн онцлог, суралцагчийн нас сэтгэхүйн, хэл яриа, оюун ухааны онцлогт тохируулан сонгож, сэдвүүдийг суралцагчийн мэдлэг бүтээх үйл ажиллагааны загвар онолын үзэл баримтлалтай нягт холбон судална.

Хичээлийн сургалтын арга зүй: Суралцагч төвтэй, гүйцэтгэлд суурилсан (performance-based approach) арга зүйг голлон ашиглаж оюутнуудад ардын аман зохиолын талаар суралцах, бүтээлчээр оролцох соёл, түүхийн ач холбогдлыг илүү гүнзгий ойлгож, үнэлэх, багаар ажиллах боломжийг бүрдүүлнэ.

Хүснэгт 1. Үр дүнгийн хамаарал

Хичээлийн төлөвлөлт	Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадварууд
Аман зохиолын жижиг төрөл зүйлс	CLO [1.1; 1.2; 2.2; 2.3; 3.1]
Аман зохиолын том төрөл зүйлс	CLO [1.1; 1.2; 2.1; 2.2; 3.1]

Хүснэгт 2. Хичээлийн төлөвлөгөө

7 хоног	Сэдэв	Семинар
1-8	Монгол аман зохиолын жижиг төрөл зүйлс	16
9-16	Монгол аман зохиолын том төрөл зүйлс	16
Нийт цаг		32

Үнэлгээ:

№	Үнэлгээний хэлбэр	Эзлэх хувь	Багтаамж
1	Ирц, оролцоо	20%	Семинарын хичээлд суусан ирц, семинарын сэдэвтэй холбоотой гүйцэтгэх ёстой дасгал даалгаврыг хийсэн байдал болон идэвх, оролцоог 20%-иар тооцно.
2	Бие даалтууд	50%	Бие даалтыг 2 удаа гүйцэтгэнэ: 1. Сэдвүүдээс сонгож бие даасан судалгаа хийх. Үнэлгээний багтаамж 25% Багш ба оюутан үнэлгээний рубрик ашиглан судалгааны ажлын гүйцэтгэлийг үнэлнэ. 2. Монгол ардын аман зохиолын баялаг сан хөмрөгөөс сонгон авсан сэдвээр дижитал боловсруулалт хийх – 25% Жишээлбэл, оюутан үлгэр, домог, оньсого гэх мэт аман зохиолын төрлүүдийг орчин үеийн нөхцөлд тохируулан дахин бүтээж багш тухайн бүтээл нь орчин үеийн соёлын үнэт зүйл, итгэл үнэмшлийг тусгасан эсэхийг үнэлж дүгнэх юм.
3	Явцын сорил I, II	30%	1. VIII долоо хоногт - Оюутны эзэмшсэн мэдлэгийг 100 онооны нөхөх, сонгох тестээр үнэлнэ. Үнэлгээний багтаамж 10% 2. XVI долоо хоногт - Ойлголтыг тодруулахын тулд ярилцлага ба ам шалгалт. Багш оюутны судалсан сэдвүүдээс сонгуулан харилцан ярилцах. Үнэлгээний багтаамж – 20%

ХҮҮХДИЙН УРАН ЗОХИОЛ (Т.МL405) ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА

Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага (CLO):

1. Мэдлэг

- 1.1. Монголын эртний уран зохиолын дурсгалуудаас, хүүхдийн уншлагад холбогдох зохиол бүтээлүүдийг судлах [PLO 1.1.6, 1.2.1]
- 1.2. Монголын орчин үеийн хүүхдийн уран зохиолын судлал, төрөл зүйл түүний онцлогийг таньж мэдэх [PLO 1.1.6, 1.2.1]

2. Чадвар

- 2.1. Монголын эртний уран зохиолын хүүхдийн уншлагад хамаарах зохиол бүтээлийн хэл найруулга, дүр дүрслэлийг задлан шинжлэх, тайлбарлах [PLO 1.1.6, 3.2.5]
- 2.2. Монголын орчин үеийн хүүхдийн уран зохиолыг нийгэм түүх, гол төлөөлөгч, гол бүтээлд нь тулгуурлан үечлэн онцлог яглааг тайлбарлах [PLO 1.1.6, 3.2.5]
- 2.3. Орчуулгын хүүхдийн уран зохиолыг, монголын хүүхдийн уран зохиолтой хэл найруулга, дүр дүрслэл, агуулгын талаар харьцуулах, тодорхойлох, тайлбарлах [PLO 1.1.3, 1.1.6, 3.2.5]

3. Хандлага

- 3.1. Хүүхдийн уран зохиолоор дамжуулан эх хэлний уран найруулга, үндэсний сэтгэлгээний онцлогийг мэдрэх, түгээх эрмэлзэлтэй болох [PLO 1.1.6, 3.2.5]
- 3.2. Эх зохиолыг сонгохдоо, судлаач-уншигчийн үүднээс хандах [PLO 1.2.2, 3.2.5]

Үнэлгээний жин, хэлбэр:

Ирц, оролцоо: 20%

Бие даалтууд: 50%

Явцын сорил: 30%

Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр, код:	Хүүхдийн уран зохиол T.ML405
Улирал:	III курсийн намрын улиралд
Хичээлийн задаргаа:	1:2:0:0(3), (Лекц,семинар)
Заах багш:	А.Амардалай, Б.Нанжид
Е_мэйл хаяг:	amardalai@msue.edu.mn , b.nanjid27@yahoo.com
Утас:	(976)-70112429, 88067869, 89114882
Ажлын өрөө:	5 - 207
Ажиллах цаг:	Даваа–Баасан, 9:00 am – 18:00 pm.

Үндсэн сурах бичиг:

1. Оюунбадрах, Д. (2007, 2010, 2012). *Монголын хүүхдийн уран зохиол*. Уб., Бэмби сан.
2. Галбаатар Д. (2016) Монголын хүүхдийн уран зохиолын тайлбар толь. Уб., МУИС.

Нэмэлт унших материалууд:

1. Батжаргал, Д. (2011). “Хүүхдийн яруу найргийн уран чадварын зарим асуудал” .Уб., МУИС хэвлэх үйлдвэр.
2. Гаадамба, Ш. (1961). *Хүүхдийн зохиолын хэлний учир*. Уб., Улаанбаатар хэвлэх үйлдвэр.
5. Д, Хүү. (2007). *Дэлхийн хүүхдийн уран зохиол*. Уб: Битпресс.
6. Дашдондог, Ж. (2011). *Дэлхийн хүүхдийн яруу найраг*. Уб: Битпресс.
7. Дашдондог, Ж. (2012). *Дэлхийн хүүхдийн шилдэг Өгүүллүүд*. Уб: Битпресс.
8. Оюунбадрах, Д. (2007). *Монголын хүүхдийн уран зохиолын ном зүй (1920-1940)*. Уб.
9. Оюунбадрах, Д. (1987). *Монголын хүүхдийн уран зохиол*. Уб: Улаанбаатар хэвлэх үйлдвэр.
10. Өлзийбаяр, Д. (1987). *Хүүхэд Зохиолч уран бүтээл*. Уб: Улаанбаатар хэвлэх үйлдвэр
11. *Хүүхдийн уран зохиолын дээж бичиг*. (2004). Уб.
12. *Сундуй*. О нар, (2020), *Хүүхдийн уран зохиолын унших бичиг*” Уб., Тоонот принт

Хичээлийн өмнөх холбоо: Аман зохиол, T.ML304

Хичээлийн товч тодорхойлолт:

Монголын хүүхдийн уран зохиолын баялаг өв санг эрт эдүгээгийн бичгийн бичгийн дурсгалаас судлах төдийгүй түүний онол, түүх шүүмжийн талаас бага боловсролын түвшинд хэрхэн ухаарч заах арга барилыг судална.

Хичээлийн зорилго:

- 3.2. “Тоо тоолол, арга зүй”-н мэдлэгээ бататган, түүнтэй холбоотой мэдээлэл цуглуулах, бодлого асуудалд харьцуулалт хийх, судлан шинжлэх хүсэл эрмэлзлэл хандлагатай болох [PLO 1.1.6, 2.1.1, 2.4.5, 2.4.7, 3.1.3, 3.2.2]

Үнэлгээний жин, хэлбэр:

Ирц, оролцоо: 20%

Бие даалтууд: 50%

Явцын сорил: 30%

Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр, код:	Тоо тоолол, арга зүй Т.МА402
Улирал:	II дамжааны хаврын улирал
Хичээлийн задаргаа:	1:4:0:0(3) (лекц, семинар)
Заах багш:	Д.Энхцэцэг, Д.Амартүвшин, А.Гантуул
Е-мэйл хаяг:	Enkhtsetseg@msue.edu.mn Amartuvshin@msue.edu.mn Gantuul@msue.edu.mn
Утас:	99165432, 95018488, 88025377
Ажлын өрөө:	5 – 305
Ажиллах цаг:	Даваа-Баасан, 8:40 am - 18:00 pm.
Үндсэн сурах бичиг:	

1. Балдулмаа,Б., Нямжав,Ц., Энхцэцэг,Д., Мягмарсүрэн,Ө., (2010). Бага боловсролын математикийн онол, дидактик, Уб
2. Амартүвшин,Д., Магсар,Р., (2016). Бага боловсролын математикийн багшлахуй ба суралцахуй, Уб

Нэмэлт унших материалууд:

1. Амартүвшин,Д., Алимаа,С., (2019). Математик I, Уб
2. Амартүвшин,Д., Алимаа,С., Багшийн ном I, (2014). Уб
3. Ариунтунгалаг,Б., Хишигжаргал,Д., (2019). Математик II, Уб
4. Ариунтунгалаг,Б., Хишигжаргал,Д., (2014). Багшийн ном II, Уб
5. Эрдэнэчимэг,Б., Энхцэцэг,Д., (2019). Математик III, Уб
6. Эрдэнэчимэг,Б., Энхцэцэг,Д., (2014). Багшийн ном III, Уб
7. Гантуул,А., (2019). Математик IV, Уб
8. Гантуул,А., (2014).Багшийн ном IV, Уб
9. Түвшинжаргал,Б., Батболд,Г., (2019).Математик V, Уб
10. Түвшинжаргал,Б., Батболд,Г., (2014). Багшийн ном V, Уб
11. Бага боловсролын цөм хөтөлбөр., (2014), Уб
12. Бага боловсролын сайжруулсан хөтөлбөр., (2019), Уб
13. Дамдинсүрэн,Б., Шагдар,Д., (1997). Бага ангийн математикийн сургалтын сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх ухааны үндэс, Уб
14. Доёд.У.,(1991). Арифметикийн өгүүлбэртэй бодлогыг тогтолцооны аргаар бодох нь, Уб
15. Магсар,Р.,Амартүвшин,Д., (2014). Бага боловсролын багшийн заавал бодох 500 бодлого, Уб
16. Норов,С.,(2014). Бага боловсролын математикийн онолын мэдлэг шалгах сэдвүүд,Уб

Хичээлийн залгамж, холбоо: Геометр ба хэмжигдэхүүн, арга зүй Т.МА403

Хичээлийн товч тодорхойлолт: “Тоо тоолол, арга зүй” хичээлээр ЕБС-ийн I-V ангийн математикийн хичээлийн ТОО ТООЛОЛ агуулгын хүрээнд дугаарлал, арифметикийн 4 үйлдэл, үйлдлийн чанарууд, тэдгээрийг амьдрал ахуйд хэрэглэх агуулгыг хэрхэн таниулахыг судална.

Хичээлийн зорилго: Бага боловсролын математикийн хичээлийн ТОО ТООЛОЛ агуулгыг заах онолын мэдлэг чадварт суралцахад оршино.

Агуулга:

Арга зүйн хувьд: Оюутнуудын тоо тооллын сэтгэлгээг хөгжүүлэх, жиших, харьцуулах, харгалзуулах, хийсвэрлэх, элементарчлах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, системчлэх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулах чадвартай болгох,

Агуулгын хувьд: Дунд сургууль, их, дээд сургуулийн суралцагч, оюутнууд математикийг судлахдаа тоо тооллын үндсэн ухагдахуун, өгүүлбэр, баталгааны тодорхой системийг зайлшгүй эзэмшдэг. Энэхүү системийг эзэмшиж, бага ангийн сурагчдыг сургахад болон тэднийг математикийн хичээлээр хөгжүүлэх нь тоо тооллын ухагдахууны логик бүтцийг судлахад оршино.

Хичээлийн сургалтын арга зүй: Танин мэдэхүйн ерөнхий аргуудад тулгуурласан сургалтын аргууд

- Асуудал дэвшүүлэн шийдвэрлэх арга
- Бүтээлч сэтгэлгээний аргууд
- ДТСБЧ-ыг хөгжүүлэхэд чиглэсэн аргууд (HOTS)
- Цахим технологид суурилсан аргууд
- Элементарчлах, дидактик нэгжийг томсгох аргууд
- Тонгоруу сургалтын арга зүй
- Нэгжийг томсгох арга зүй
- Тогтолцоо шинжилгээ, судалгааны аргууд
- Хамтарч асуудлыг шийдэх буюу багаар ажиллах зэрэг аргуудыг хэрэглэнэ.

Хүснэгт 1. Үр дүнгийн хамаарал

Хичээлийн төлөвлөлт	Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадварууд
10,100,1000, олон оронтой тооны дугаарлал, нэмэх-хасах-үржих-хуваах үйлдэл таниулах агуулгыг судлах	CLO (1.1, 1.2, 1.3, 2.1, 2.2, 3.1, 3.2)
Энгийн бутархай, түүний үйлдэл таниулах агуулгыг судлах, Аравтын бутархай, түүний үйлдэл таниулах арга зүй	CLO (1.1, 1.2, 1.3, 2.1, 2.2, 3.1, 3.2)
Эерэг сөрөг тоо, харьцаа, пропорц, процент агуулгыг судлах	CLO (1.1, 1.2, 1.3, 2.1, 2.2, 3.1, 3.2)

Хүснэгт 2. Хичээлийн төлөвлөгөө

Нийт цаг: 80 цаг

7 хоног	Сэдэв	Лекц	Семинар
1-2	Математикийн сургалтын цөм хөтөлбөр дэх тоон дугаарлалын нэгж агуулгын залгамж холбоог судлах ба тоон дугаарлал таниулах арга зүй	2	8
3-4	Нэмэх, хасах үйлдэл таниулах арга зүй	2	8
5-6	Үржүүлэх, хуваах үйлдэл таниулах арга зүй	2	8
7-8	Энгийн бутархай таниулах арга зүй	2	8
9-10	Аравтын бутархай таниулах арга зүй	2	8
11-12	Харьцаа, тэнцүү харьцаа, масштабыг таниулах арга зүй	2	8
13-14	Процент таниулах, арга зүй	2	8
15-16	Пропорциональ хамаарлын бодлогуудыг бодох арга зүй	2	8
Нийт цаг		16	64

Үнэлгээ:

№	Үнэлгээний хэлбэр	Эзлэх хувь	Багтаамж
1	Ирц, оролцоо	20%	Ирц-10%, Идэвх оролцоо 10% -иар үнэлнэ.
2	Бие даалтууд	50%	Бие даалтыг 3 удаа гүйцэтгэнэ: • Хичээлийн хэрэглэгдэхүүн боловсруулах (10%) • Ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулах (рубрик) (20%) • Мини хичээл зохион байгуулж хэлэлцүүлэг хийж, дүгнэлт бичих (20%)
4	Явцын сорил I, II, III	30%	• I-V ангийн математикийн сурах бичиг дэх 10,100,1000, олон оронтой тооны дугаарлал, нэмэх-хасах-үржих-хуваах үйлдэл таниулах агуулгыг судлах (10%) • II-V ангийн математикийн сурах бичиг дэх энгийн бутархай, түүний үйлдэл таниулах агуулгыг судлах (10%) • III-V ангийн математикийн сурах бичиг дэх эерэг сөрөг тоо, аравтын бутархай, харьцаа, пропорц, процент агуулгыг судлах (10%)

ГЕОМЕТР БА ХЭМЖИГДЭХҮҮН, АРГА ЗҮЙ (Т.МА403) ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА

Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага (CLO):

1. Мэдлэг

- 1.1. Хэмжээг хэмжих стандарт ба стандарт бус нэгжүүдийг төрлөөр нь ангилж ялгах, тогтоох [PLO 1.1.4, 1.1.5]
- 1.2. Хэрчим, тахир шугам, цацраг, шулуун, өнцөг, тэгш өнцөгт, гурвалжин, тойрог, дугуй, куб, параллелепипед мэт хялбар дүрсүүдийг ялган таних тус бүрийн тодорхойлолтыг гаргах [PLO 1.1.4, 1.1.5]
- 1.3. Өгсөн дүрсүүдийг тэгш хэмтэйгээр хувиргах, параллелиар шилжүүлэх, тодорхой төв, чиглэлтэйгээр эргүүлэх [PLO 1.1.4, 1.1.5]

2. Чадвар

- 2.1. Хэмжих нэгж хоорондын харилцан шилжилтийг ихээс бага нэгж рүү багаас их нэгж рүү гэх мэт алдаагүй шилжүүлж тооцоолох, нэртэй тооны үйлдлүүдийг гүйцэтгэн хялбарчлах [PLO 2.4.1, 2.4.7]
- 2.2. Хялбар дүрсийн хэмжээг (урт, талбай, эзлэхүүн, өнцгийн хэмжээ) холбогдох нэр томъёо, зураг, тэмдэглэгээгээр оновчтой илэрхийлэх, тайлбарлах, тооцоолох [PLO 2.4.1, 2.4.7]
- 2.3. Тэгш хэм, параллель зөөлт, эргүүлэлтийн чанар болон хувиргалтуудыг ашиглан бодлого бодох, тэгш хэм, параллель зөөлт, эргүүлэлтийн чанаруудыг ашиглан зураг дизиан гаргах, бүтээлүүд хийх [PLO 2.4.1, 2.4.7]

3. Хандлага

- 3.1. Хэмжилт тооцооны үндсэн дээр дүгнэлт хийх, мэдээллийг үнэн болохыг нотлох, эдийн засгийн хувьд эерэг үзүүлэлттэй байх шийдвэрийг гаргах [PLO 3.1.3, 3.2.]
- 3.2. Амьдрал ахуйн тодорхой асуудлуудыг геометрээр загварчлах [PLO 3.1.3, 3.2.3]

Үнэлгээний жин, хэлбэр:

Ирц, оролцоо: 20%

Бие даалтууд: 50%

Явцын сорил: 30%

Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр, код: Геометр ба хэмжигдэхүүн, арга зүй Т.МА403

Улирал: 3 дамжааны хаврын улирал

Хичээлийн задаргаа: 1:2:0(3) (лекц, семинар)

Заах багш:

Багшийн нэр

Е-мэйл хаяг

Д.Энхцэцэг

enkhtsetseg@msue.edu.mn

Д.Амартүвшин

amartuvshind@msue.edu.mn

А.Гантуул

gantuu@msue.edu.mn

Б.Хадбаатар

khadbaatar.b@msue.edu.mn

Ажлын өрөө:

5 - 306, 308

Ажиллах цаг:

Даваа–Баасан, 9:00 am – 18:00 pm.

Үндсэн сурах бичиг:

1. Балдулмаа, Б. (2013). Бага боловсролын математикийн онол, дидактик. Уб.
2. Батболд, Г. (2014). Бага боловсролын онол, дидактикийн асуудалд”. Уб.
3. Магсар, Р. (2012). Бага боловсролын математикийн онол.
4. Магсар, Р. (2013). Бага боловсролын математикийн онолын бодлогын хураамж. . Уб.
5. Норов, С. (2014). Сэтгэхүй хөгжүүлэх бодлого бодох аргууд. Уб.
6. Энхцэцэг, Д. (2006). Бага боловсролын математик, магадлал статистик. . Уб.

Нэмэлт унших материалууд:

1. Бага боловсролын сургалтын “Цөм хөтөлбөр” . (2014). Уб.
2. Адьяасүрэн. В. (1998). Арифметикийн бодлогууд. Уб.
3. Баатар, Ж. (2006). Асуудал шийдвэрлэх цогц чадамж төлөвшүүлэхэд холбогдох зөвлөмж. . Улаанбаатар: МУБИС хэвлэх тасаг.
4. Дамдинсүрэн.Б нар, б. б. (1997). Бага ангийн математикийн сургалтын сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх ухааны үндэс. Уб.
5. Доёд.У., Д. (1991). Арифметикийн өгүүлбэртэй бодлогыг тогтолцооны аргаар бодох нь.
6. Магсар, Р. А. (2014). Бага боловсролын багшийн заавал бодох 500 бодлого. Улаанбаатар.
7. Норов, С. (2014). Бага боловсролын математикийн онолын мэдлэг шалгах сэдвүүд. Улаанбаатар.
8. Норов, С. (2014). Сэтгэхүй хөгжүүлэх бодлого бодох аргууд. Уб.
9. Энхцэцэг, Д., & Хадбаатар, Б. (2020). Геометр ба хэмжигдэхүүн таниулах арга зүй. Улаанбаатар: Адмон .

Хичээлийн залгамж холбоо: Өгөгдөлтэй ажиллах арга зүй, Т.МА404

Хичээлийн товч тодорхойлолт:

“Геометр ба хэмжигдэхүүн, арга зүй” хичээл нь намар 1:2:0:0:(3) хэлбэрээр орж I-V ангийн агуулгын хүрээнд хялбар дүрс, дүрсийн хэмжээ, хөдөлгөөн, хэмжигдэхүүн зэрэг агуулгыг хэрхэн таниулахыг судална.

Хичээлийн зорилго:

“Геометр ба хэмжигдэхүүн, арга зүй” хичээлийг боловсролын хөгжлийн чиг хандлага, МУБИС-ийн бодлого, зорилготой уялдуулан төлөвлөн зохион

байгуулж, оюутнуудыг мэдлэг бүтээх түүнийгээ чадвар болгон хэрэглэхэд нь дэмжлэг үзүүлэхэд оршино.

Арга зүйн хувьд:

Сургалтын үйл ажиллагааг асуудал дэвшүүлэн шийдвэрлэх, цахим технологид суурилсан тонгоруу сургалтын, элементарчлах, дидактик нэгжийг томсгох, хоршин суралцах зэрэг танин мэдэхүйн ерөнхий аргуудад тулгуурлан зохион байгуулна.

Агуулга:

-2019 онд шинэчлэгдэн батлагдсан бага боловсролын математикийн сургалтын хөтөлбөр геометр хэмжигдэхүүн бүхий агуулгыг заан таниулах арга зүй, ахисан түвшний, олимпиадын, TIMSS шалгалтын агуулга бүхий даалгаврууд

Хүснэгт 1. Хичээлийн төлөвлөлт

Хичээлийн төлөвлөлт	Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадварууд
Геометрийн матерталыг таниулах	CLO [1.1.4], [1.1.5],[2.4.1], [2.4.7],[3.1.3], [3.2.3]
Хэмжигдэхүүн, түүнийг таниулах арга зүй -24 цаг	CLO [1.1.4], [1.1.5],[2.4.1], [2.4.7],[3.1.3], [3.2.3]

Хүснэгт 2. Хичээлийн төлөвлөгөө

Нийт цаг: 48 цаг

7 хоног	Сэдэв	Лекц	Семинар
1-2	Бага боловсролын матетатикийн сургалтын хөтөлбөр болон сурах бичигт дэх агуулга /геометр ба хэмжигдэхүүн/	2	4
3-4	-Цэг, хэрчим, задгай ба битүү тахир шугам -Дүрс ба биетүүд -Тойрог ба дугуй -Өнцөг, олон өнцөгтүүд, ангилал болон чанар -Дүрсийн тэгш хэм	2	4
5-6	Геометрийн хялбар байгуулалтуудыг гүйцэтгэх нь	2	4
7-8	-Юмсын байршил ба хөдөлгөөн /план зураг, аяллын маршрут, газрын зурагтай ажиллах/ -Дүрсийн шилжилт ба хөдөлгөөн	2	4
9-10	-Уртын хэмжигдэхүүнийг таниулах, дүрсийн периметр болон биетийн ирмэгийн уртыг олох -Си ба си системийн бус нэгжүүд	2	4
11-12	Дүрсийн талбай, биетийн гадаргуугийн талбайг таниулах арга зүй	2	4
13-14	Эзлэхүүн ба багтаамж, масс, цаг хугацааг таниулах арга зүй	2	4
15-16	Геометр, хэмжигдэхүүний агуулга бүхий нээлттэй бодлого	2	4
Нийт цаг		16	32

Үнэлгээ:

№	Үнэлгээний хэлбэр	Эзлэх хувь	Багтаамж
1	Ирц, оролцоо	20%	Ирц-10 оноо, Идэвх оролцоо 10 оноо
2	Бие даалт	50%	VIII долоо хоногт нэг удаагийн бие даалт
4	Явцын сорил I, II	30%	I сорил (15 оноо) - Геометрийн зарим хялбар дүрс, биет тэдний үндсэн чанарууд, хэмжээ ба зурж байгуулах арга II сорил (15 оноо) - Хэмжих нэгж хоорондын харилцан

			шилжилтийг алдаагүй тооцоолох
--	--	--	-------------------------------

ӨГӨГДӨЛТЭЙ АЖИЛЛАХ АРГ ЗҮЙ (Т.МА404) ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА

Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага (CLO):

1. Мэдлэг

- 1.1. Зүй тогтлыг илрүүлэн тооцох, Боломж, түүний тоог олох [PLO 1.1.4, 1.1.5]
- 1.2. Өгөгдөл цуглуулах, бүртгэх, ангилах, боловсруулах математик статистикийн онолын мэдлэгийг эзэмших [PLO 1.1.4, 1.1.5]
- 1.3. Ажиглалт, судалгаагаар өгөгдөл цуглуулж математик статистикийн Вариаци, вариацийн эгнээ, медиан, моод, далайц, арифметик дунджийг олоход программ ашиглаж сурах[PLO 1.1.4, 1.1.5]

2. Чадвар

- 2.1. Зүй тогтлыг илрүүлэн тооцох арга зүй Боломж, түүний тоог олох арга зүй (Үсэгт таавар, үг бүтээх таавар, юүлэлт ба жинлэлтийн бодлого бодох арга зүй..) эзэмших [PLO 2.4.1, 2.4.7]
- 2.2. Өгөгдөл цуглуулах, бүртгэх, боловсруулах Өгөгдөл болон мэдээллийг дүрсээр илэрхийлэх, өгөгдсөн шинжээр ангилах арга зүй (Пиктограм, Веннийн диаграмм, Каролийн диаграмм) Өгөгдлийн боловсруулалтыг дааграммаар илэрхийлэх. Диаграммийн төрлүүд (баганан, хэрчмэн, шугаман, дугуй диаграмм) эзэмших, статистикийн элементүүд (Вариаци, вариацийн эгнээ, медиан, моод, далайц, арифметик дундаж) [PLO 2.4.1, 2.4.7]
- 2.3. Аливаа үзэгдэл юмс, үйл явдал, өөрчлөлтийн учир шалтгаан, мөн чанар, холбоо хамаарал, үр дагавар, зүй тогтлыг илрүүлэхдээ ажиглалт, туршилтын үр дүнг бүртгэх, боловсруулах, статистик тооцоолол хийж задлан шинжлэн дүгнэлт гаргах [PLO 2.4.1, 2.4.7]

3. Хандлага

- 3.1. Тодорхойгүй байдал, санамсаргүй үйл явцад дасан зохицдог байх [PLO 3.1.3, 3.2.3]
- 3.2.Аливаа асуудлыг олон талаас нь нээлттэйгээр авч үзэх хандлагатай болох [PLO 3.1.3, 3.2.3]

Үнэлгээний жин, хэлбэр:

Ирц, оролцоо: 20%

Бие даалтууд: 50%

Явцын сорил: 30%

Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр, код: Өгөгдөлтэй ажиллах арга зүй, Т.МА404
Улирал: 3 дамжааны хаврын улирал
Хичээлийн задаргаа: 1:2:0:0 (3) (Лекц, Семинар)
Заах багш:

Багшийн нэр

Е-мэйл хаяг

Д.Энхцэцэг	enkhtsetseg@msue.edu.mn
Д.Амартүвшин	amartuvshind@msue.edu.mn
А.Гантуул	gantuuл@msue.edu.mn
Б.Хадбаатар	khadbaatar.b@msue.edu.mn
Д.Хишигжаргал	khishigjargal@msue.edu.mn
Ажлын өрөө:	5 – 305
Ажиллах цаг:	Даваа–Баасан, 9:00 am – 18:00 pm.

Үндсэн сурах бичиг:

1. Балдулмаа, Б. (2013). Бага боловсролын математикийн онол, дидактик. Уб.
2. Батболд, Г. (2014). Бага боловсролын онол, дидактикийн асуудалд”. Уб.
3. Магсар, Р. (2012). Бага боловсролын математикийн онол.
4. Магсар, Р. (2013). Бага боловсролын математикийн онолын бодлогын хураамж. . Уб.
5. Норов, С. (2014). Сэтгэхүй хөгжүүлэх бодлого бодох аргууд. Уб.
6. Энхцэцэг, Д. (2006). Бага боловсролын математик, магадлал статистик. . Уб.

Нэмэлт унших материалууд:

1. Albert, L. T. (2011). “Mathematics for elementary teachers”.
2. Норов, С. (2014). Бага боловсролын математикийн онолын мэдлэг шалгах сэдвүүд. Улаанбаатар.
3. Нямжав, Ц. (2010). Математикийн логикийн элементүүд. Уб.
4. Нямжав, Ц. (2010). Олонлогийн онолын элементүүд. Уб.
5. Пышкало, А. (1986). Теоритические основы начального курса математики. Москва.
6. Стойлова, Л. (2005). Третье издание. М.

Хичээлийн залгамж холбоо: Өгүүлбэртэй бодлого бодох арга зүй, Т.МА406

Хичээлийн товч тодорхойлолт:

Агуулга: Комбинаторикийн болон магадлал статистикийн үндсэн ойлголтууд, зүй тогтол, боломж, түүний тоог олох арга зүй, өгөгдөлтэй ажиллах арга зүй, статистик боловсруулалт хийх арга зүйд суралцаж улмаар бага боловсролын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх мэдлэг, чадвартай болно.

Хичээлийн зорилго:

Зүй тогтлыг илрүүлэн тооцох, Боломж, түүний тоог олох, Өгөгдөл болон мэдээллийг өгөгдсөн шинжээр ангилж Пиктограм, Веннийн диаграмм, Каролийн диаграмм дүрслэх, Өгөгдөл цуглуулах, бүртгэх, боловсруулах, боловсруулалтыг баганан, хэрчмэн, шугаман, дугуй диаграммаар илэрхийлэх, Статистикийн элементүүд болох Вариаци, вариацийн эгнээ, медиан, моод, далайц, арифметик дундаж олох онол, арга зүйн мэдлэгийг эзэмшихийн зэрэгцээ Бага боловсролын цөм хөтөлбөр, сурах бичигт өгөгдөлтэй ажиллах арга зүй хэрхэн тусгагдсаныг судлах, тухайн судлагдахууны хэрэглэгдэхүүн боловсруулах арга зүйд суралцах

Арга зүй:

Сургалтын үйл ажиллагааг асуудал дэвшүүлэн шийдвэрлэх, цахим технологид суурилсан тонгоруу сургалтын, элементарчлах, дидактик нэгжийг томсгох, хоршин суралцах зэрэг танин мэдэхүйн ерөнхий аргуудад тулгуурлан зохион байгуулна.

Агуулга:

2019 онд шинэчлэгдэн батлагдсан бага боловсролын математикийн сургалтын хөтөлбөр өгөгдөлтэй ажиллах бүхий агуулгыг заан таниулах арга зүй, ахисан түвшний, олимпиадын, TIMSS шалгалтын агуулга бүхий даалгаврууд

Хүснэгт 1. Хичээлийн төлөвлөлт

Хичээлийн төлөвлөлт	Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадварууд
Нэгж хичээл №1	CLO [1.1.4], [1.1.5],[2.4.1], [2.4.7],[3.1.3], [3.2.3]
Нэгж хичээл №2	CLO [1.1.4], [1.1.5],[2.4.1], [2.4.7],[3.1.3], [3.2.3]

Хүснэгт 2. Хичээлийн төлөвлөгөө

Нийт цаг: 48 цаг

7 хоног	Сэдэв	Лекц	Семинар
1-2	Бага боловсролын математикийн сургалтын хөтөлбөр болон сурах бичигт дэх агуулга /Өгөгдөлтэй ажиллах/	2	4
3-4	Юмсыг (өнгө, хэмжээ, хэлбэр) нэг, хоёр шинжээр нь хүснэгт, диаграмм хэрэглэн ангилах /Карролл, Эйлер-Венн/	2	4
5-6	Өгөгдөл, мэдээллийг цуглуулах, ангилах бүртгэх, дүрслэх, тайлбарлах, дүгнэлт гаргах	2	4
7-8	Боломж, түүний тоог олох арга зүй	2	4
9-10	Комбинаторикийн бодлогуудыг бодох арга, зүй	2	4
11-12	Нээлттэй бодлогууд -Нээлттэй бодлогын төрлүүд -Хаалттай бодлогыг нээлттэй бодлого болгох нь	2	4
13-14	-Ажиглалт, туршилтаар өгөгдлийг цуглуулах -Статистикийн элементүүд /Варианц, вариацийн эгнээ, медиан, моод, далайц, арифметик дундаж/	2	4
15-16	Бага ангийн олимпиадын бодлогуудыг бодох нь	2	4
Нийт цаг		16	32

Үнэлгээ:

№	Үнэлгээний хэлбэр	Эзлэх хувь	Багтаамж
1	Ирц, оролцоо	20%	Ирц 10%, идэвх оролцоо 10% -иар харгалзуулан үнэлнэ.
2	Бие даалтууд	50%	Бие даалтыг 2 удаа гүйцэтгэнэ: - Зүй тогтолыг олох, боломж тоолохтой холбоотой бодлогыг бодох (25%), - Судалгааны асуулга боловсруулах, мэдээлэл цуглуулах, боловсруулалт хийх, дүгнэлт гаргах (25%)
3	Явцын сорил I, II,	30%	- Явцын шалгалт C1- 15% Буцаалттай ба буцаалтгүй түүврийн тоог олох - Явцын шалгалт C2- 15%

			Математик статистик боловсруулалт хийх
--	--	--	--

ӨГҮҮЛБЭРТЭЙ БОДЛОГО БОДОХ АРГА ЗҮЙ (Т.МА406) ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА

Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага (CLO):

1. Мэдлэг

- 1.1.Математикийн өгүүлбэртэй бодлого, түүний бүтэц, ангилал, гүйцэтгэх үүргийг мэдэж, бодох ерөнхий арга барилыг эзэмших [PLO 3.2.2]
- 1.2.Өгүүлбэртэй бодлого бодоход суралцахыг дэмжих арга зүйг бусад хичээлийн арга зүйтэй харьцуулж, ялгах [PLO 2.4.5, 3.1.3]

2. Чадвар

- 2.1.Өгүүлбэртэй бодлогыг бодох чадвараа сайжруулах [PLO 3.2.2]
- 2.2.Өгүүлбэртэй бодлого бодоход суралцахыг үйл ажиллагаагаар дэмжих, мэдлэг бүтээгдэх үйл явцыг төлөвлөх, зохион байгуулах, үнэлэх [PLO 2.4.7]

3. Хандлага

- 3.1. Өгүүлбэртэй бодлого бодох, арга зүй хичээл дээр суралцагч өөрийн үйл ажиллагааг удирдан, зохицуулахад чиглүүлэн дэмжих хандлагатай болох [PLO 1.1.4]
- 3.2.Өгүүлбэртэй бодлого бодох, арга зүй хичээлээр суралцагчдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх [PLO 1.1.6]

Үнэлгээний жин, хэлбэр:

Ирц, оролцоо: 20%
Бие даалтууд: 50%
Явцын сорил: 30%

Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр, код: Өгүүлбэртэй бодлого, арга зүй Т.МА406
Улирал: 4 дамжааны намрын улирал
Хичээлийн задаргаа: 0:4:0(2) (Лекц: семинар: лаборатори: практик, бие даалт)
Заах багш: Д.Амартүвшин Т.MS05, Д.Хишигжаргал Т.MS11, А.Гантуул Т.MS12, Д.Энхцэцэг Т.MS01, Б.Хадбаатар Т.MS08

Е-мэйл хаяг: amartuvshind@msue.edu.mn, khishigjargald@msue.edu.mn,
gantuul@msue.edu.mn, enkhtsetseg@msue.edu.mn,
khadbaatar@msue.edu.mn,

Утас: (976)-70112429

Ажлын өрөө: 5 – 308, 306, 311

Ажиллах цаг: Даваа-Баасан, 8:00 am - 18:00 pm.

Үндсэн сурах бичиг:

1. Д.Амартүвшин, Р.Магсар, Б.Хадбаатар Өгүүлбэртэй бодлого, арга зүй 2022 он
2. Р.Магсар, Д.Амартүвшин(2016). Бага ангийн багшийн заавал бодох өгүүлбэртэй 500 бодлого (2 дахь хэвлэл). Уб. Соёмбо.

Нэмэлт унших материалууд:

1. Д.Амартүвшин (2016). Бага ангийн сурагчдын өгүүлбэртэй бодлого бодох ерөнхий арга барил төлөвшихийг дэмжих арга зүй. Уб. Арвай принтинг.

Хичээлийн өмнөх холбоо:

Хичээлийн товч тодорхойлолт:

Хичээлийн зорилго: Өгүүлбэртэй бодлого, арга зүй хичээлээр өгүүлбэртэй бодлого бодох болон сурлацагчдад өгүүлбэртэй бодлого бодуулах арга барилд суралцахыг дэмжсэн арга зүйгээр хичээл зохион байгуулах, асуудалд цогц хандах, өөрийгөө хянах, зохицуулах, бүтээлчээр сэтгэх хандлагатай болоход оршино.

Агуулга: Өгүүлбэртэй бодлого түүнийг бодох ерөнхий арга барил, өгүүлбэртэй бодлого бодох олон аргуудыг эзэмших, 1-5-р ангид өгүүлбэртэй бодлого бодоход суралцах арга зүй, ахуй амьдралын асуудлыг оновчтой шийдвэрлэх өгүүлбэртэй бодлогоор хичээлийг зохион байгуулах, суралцагчдыг хөгжүүлэх чадварт суралцаж, мэдлэгийг амьдралд хэрэглэх, өөрийгөө хянан зохицуулах хандлагатай болохыг хэрхэн чиглүүлэхийг судлах юм.

Хичээлийн сургалтын арга зүй:

- Танин мэдэхүйн зүй тогтолд нийцүүлэн төлөвлөх, зохион байгуулах, үнэлэх, суралцагчдын хөгжлийг дэмжихэд суралцахыг оюутны бүтээлч, бие даасан үйл ажиллагаа, дээд эрэмбийн сэтгэн бодох чадвар шаардсан, шинжлэх ухаанч арга барил, асуудал болон төсөлд суурилсан, цахим болон танхимийн сургалтын арга зүйг хэрэгжүүлнэ.
- Андрагог буюу оюутанд зориулсан арга зүй зэргийг хэрэгжүүлнэ.

Хүснэгт1. Үр дүнгийн хамаарал

Хичээлийн төлөвлөлт	Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар
Бүлэг сэдэв-1. Өгүүлбэртэй бодлого, түүнийг бодох ерөнхий арга барил, бодох аргууд	CLO 1.1, 2.1, 3.1, 3.2
Бүлэг сэдэв-2. Нийлмэл бодлого бодоход суралцахыг дэмжих арга зүй	CLO 1.2, 2.1, 3.1
Бүлэг сэдэв-3. Өгүүлбэртэй бодлого бодоход суралцахыг дэмжих идэвхтэй сургалтын аргууд	CLO 2.2, 3.2

Хүснэгт 2. Хичээлийн жишиг төлөвлөгөө

Нийт цаг: 64 цаг

7 хоног	Сэдэв	Семинар
1-4	Өгүүлбэртэй бодлого, түүнийг бодох ерөнхий арга барил, бодох аргууд	16
5-10	Нийлмэл бодлого бодоход суралцахыг дэмжих арга зүй	24
11-16	Өгүүлбэртэй бодлого бодоход суралцахыг дэмжих идэвхтэй сургалтын аргууд	24
Нийт цаг		64

Үнэлгээ:

№	Үнэлгээний хэлбэр	Эзлэх хувь	Багтаамж
1	Ирц, оролцоо	20%	Ирц 10%, идэвх оролцоо 10% -иар харгалзуулан үнэлнэ.
2	Бие даалтууд	50%	Бие даалтыг 2 удаа гүйцэтгэнэ: - Ажлын хуудас боловсруулах- 25% - Ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулж, турших- 25%
3	Явцын сорил I, II,	30%	- Өгүүлбэртэй бодлого бодох I сорил (15%) - Өгүүлбэртэй бодлого бодоход суралцахыг дэмжих арга зүй сэдэвт сорил (15%)

ХҮН БАЙГАЛЬ (Т.SC401) ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА

Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага (CLO):

1. Мэдлэг

- 1.1. Эх орны тухай танин мэдэхүйн ерөнхий ойлголт, уур амьсгал, цаг агаар, газарзүйн зураг, план зураг, масштаб, эх дэлхий, нар, сар, орчлон ертөнцийн тухай танин мэдэх, харьцуулах, шинжлэх ухааны үндэстэй тайлбарлах [PLO 1.3.1, 2.4.4, 2.5.3, 3.2.4]
- 1.2. Байгалийн юмс үзэгдлийг танин мэдэх, шинжлэн судлах, эргэцүүлэх [PLO 1.3.1, 2.4.4, 2.5.3, 3.2.4]
- 1.3. Амьд ба амьгүй байгаль түүний холбоо хамаарал, амьд бие түүний ангилал, үндсэн шинж, амьд бие ба амьдралын орчин, амьдралын эргэлтийг судалж танин мэдэх, нэгтгэн дүгнэх [PLO 1.3.1, 2.4.4, 2.5.3, 3.2.4]

2. Чадвар

- 2.1. Эх орны газар нутаг, уур амьсгал, цаг агаарыг дэлхийн бусад улс орнуудтай харьцуулах, газар зүйн зураг, план зураг дээр ажиллах, масштабын бодлого бодох, ангийн план зураг зурах [PLO 1.3.1, 2.4.7, 3.2.4]
- 2.2. Байгалийн юмс, үзэгдэлийн мөн чанар, учир шалтгаан, холбоо хамаарлыг судлах, загварчлах, туршилтын үр дүнг үнэлж, дүгнэх, шинэ туршлага бий болгох [PLO 1.3.1, 2.4.7, 3.2.4]
- 2.3. Амьд ба амьгүй байгалийн харилцан хамаарлыг ажиглалт, туршилтын аргаар шинжлэх, амьтан ургамлын идэш тэжээлийн хэлхээг ажиглах, тайлбарлах, асуудал дэвшүүлж, шийдвэрлэх. [PLO 1.3.1, 2.4.7, 3.2.4]

3. Хандлага

- 3.1. Эх орон, байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах хандлага төлөвшүүлэх, үзэл бодлоо хэлэлцүүлэх [PLO 1.1.6, 1.3.1, 3.2.4]
- 3.2. Байгалийн юмс, үзэгдэлд шинжлэх ухаанчаар хандах, эргэцүүлэх [PLO 1.1.6, 1.3.1, 3.2.4]

Үнэлгээний жин, хэлбэр:

Ирц, оролцоо: 20%

Бие даалтууд: 50%

Явцын сорил: 30%

Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр, код:	Хүн байгаль, Т.SC401
Улирал:	3 дамжааны намрын улирал
Хичээлийн задаргаа:	1:4:0:0(5) (лекц, семинар)
Заах багш:	Б. Баярчимэг, Ш.Дауренбек, С.Батхуяг
Е-мэйл хаяг:	Bayarchimeg.b@msue.edu.mn , Daurenbek@msue.edu.mn , Batkhuayag@msue.edu.mn
Утас:	(976)-70112429
Ажлын өрөө:	5 - 308, 5 - 312
Ажиллах цаг:	Даваа-Баасан, 8:40 am - 18:00 pm.

Үндсэн сурах бичиг:

1. Дауренбек, Ш., Баярчимэг, Б., Батхуяг, С. (2022). “Бага боловсролын байгалийн ухааны үндэс” Үсэг хоршоо
2. Баярчимэг, Б., Дамдинсүрэн, С., Дауренбек, Ш., Содов, Ц. (2014). Байгалийн ухаан. Улаанбаатар. Соёмбо ХХК

Нэмэлт унших материалууд:

1. Баярчимэг, Б., Дауренбек, Ш., Нэргүй Г., Дугуйцагаан, Ч., (2013). “Хүн ба байгаль хичээлийн хялбар туршилтууд”. Улаанбаатар.
2. Баярмаа, Г., Батчулуун, Е., Болорчимэг, Ө., ба бусад, (2020) “Хүн ба орчин I”. Улаанбаатар. Адмон ХХК
3. Батчулуун, Е., Баярмаа, Г., Болорчимэг, Ө., ба бусад, (2020) “Хүн ба орчин II”, Улаанбаатар. Адмон ХХК
4. Батчулуун, Е., Баярмаа, Г., Болорчимэг, Ө., ба бусад, (2020) “Хүн ба орчин III”, Улаанбаатар. Адмон ХХК
5. Алтанцэцэг, Д., Батчулуун, Е., Баярмаа, Г., ба бусад, (2020) “Хүн ба байгаль IV”, Улаанбаатар. Адмон ХХК
6. Алтанцэцэг, Д., Батчулуун, Е., Баярмаа, Г., ба бусад, (2020) “Хүн ба байгаль V”, Улаанбаатар. Адмон ХХК
7. Хишигбаяр Б., Энхтогтох А., (2019) “Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр”, Улаанбаатар. Адмон ХХК
8. Батчулуун, Е., (2013). “Дэлхий судлал”. Улаанбаатар.
9. Тэмүүлэн, (2013). “Биологи”. Улаанбаатар.
10. Алтангэрэл Н., ба бусад. (2013) “Физик-1, 2”. Улаанбаатар.
11. Доржсүрэн Б., ба бусад, (2012).”Физик соёмбо нэвтэрхий толь”. Улаанбаатар. Соёмбо ХХК
12. Баянтөр М., ба бусад, (2012). “Газарзүй соёмбо нэвтэрхий толь”. Улаанбаатар. Соёмбо ХХК
13. Суран Д., ба бусад. (2012). “Биологи соёмбо нэвтэрхий толь”. Улаанбаатар. Соёмбо ХХК
14. Мижиддорж Д., ба бусад. (2012). “Хими соёмбо нэвтэрхий толь”. Улаанбаатар. Соёмбо ХХК

Хичээлийн залгамж холбоо: Байгаль шижлэл, арга зүй, Т.SC402

Хичээлийн товч тодорхойлолт: Тухайн хичээл нь боловсролын системд гарч буй өөрчлөлт шинэчлэлт, цөм хөтөлбөрийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн бага боловсролын түвшинд заагддаг хүн ба орчин, хүн ба байгаль хичээлүүдийн агуулгыг шинжлэх ухааны түвшинд интеграци хэлбэрээр судална.

Хичээлийн зорилго: Бага боловсролын байгалийн ухаан хичээлийн онолын мэдлэг, чадвар холбогдох ажиглалт, туршилт хийх, шинжлэн судлах арга барил эзэмшинэ.

Арга зүй: Оюутны оролцоо, багийн ажиллагаанд тулгуурлан, шинжлэн судлах болон асуудал дэвшүүлж шийдвэрлэх байдлаар зохион байгуулна.

Хүснэгт 1. Үр дүнгийн хамаарал

Хичээлийн төлөвлөлт	Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар
Эх орон ба орчлон ертөнц	CLO 1.1, 2.1, 3.1
Байгалийн юмс үзэгдэл	CLO 1.2, 2.2, 3.2
Амьд ба амьгүй байгаль	CLO 1.3, 2.3

Хүснэгт 2. Хичээлийн төлөвлөгөө

Нийт цаг: 80 цаг

7 хоног	Сэдэв	Лекц	Семинар
1-2	Орчлон ертөнцийн тухай	2	8
3-4	Газар зүйн зураг	2	6
4-6	Хийн мандлын бүтэц	2	8
6	Бодисын төлөв (эргэх ба үл эргэх өөрчлөлт)	2	4
7-9	Энерги, энергийн хувирал, хэрэглээ	2	12
10-11	Цахилгаан ба соронзоны үзэгдэл, тэдгээрийн хэрэглээ	2	6
11-13	Амьд бие түүний ангилал	2	10
14-16	Амьд биеийн амьдралын эргэлт	2	10
Нийт цаг		16	64

Үнэлгээ:

№	Үнэлгээний хэлбэр	Эзлэх хувь	Багтаамж
1	Ирц, оролцоо	20%	Ирц 10%, идэвх оролцоо 10% -иар харгалзуулан үнэлнэ.
2	Бие даалтууд	50%	Бие даалтыг 2 удаа гүйцэтгэнэ: - Сонголт бүхий даалгавар - 25% - Хялбар туршилтын багаж бүтээх, туршилт тавих - 25%
3	Явцын сорил I, II	30%	- Орчлон ертөнц бүлэг сэдвийн агуулгаар I сорил (10%) - Байгалийн юмс үзэгдэл бүлэг сэдвийн агуулгаар II сорил (10%) - Амьд ба амьгүй байгаль бүлэг сэдвийн агуулгаар III сорил (10%)

БАЙГАЛЬ ШИНЖЛЭЛ, АРГАЗҮЙ (Т.SC402) ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА

Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага (CLO):

1. Мэдлэг

- 1.1. Бага боловсролын байгалийн ухааны сургалтын онцлог, мөн чанарыг ойлгох [PLO 1.3.1, 3.2.3]
- 1.2. Бага боловсролын байгалийн ухааны хичээл дээр мэдлэг бүтээх арга зүй судлах, эргэцүүлэх [PLO 2.1.2, 3.2.3]
- 1.3. Бага боловсролын байгалийн ухааны хичээлийн агуулга, суралцах үйл ажиллагаа, суралцагчдын онцлогийг мэдэж, суралцах үйлийг дэмжих [PLO 2.1.1, 3.2.3]
- 1.4. Бага боловсролын хүн ба орчин, хүн ба байгаль хичээлийн агуулга, арга зүйг эргэцүүлэх, шинжлэх [PLO 1.1.6, 2.5.3, 3.2.3]

2. Чадвар

- 2.1. Бага боловсролын байгалийн ухааны хичээлийн хөтөлбөр боловсруулж, шинжлэн дүгнэх [PLO 1.1.6, 2.5.3, 3.2.3]
- 2.2. Бага боловсролын байгалийн ухааны сургалтыг суралцахуй багшлахуй, боловсролын сэтгэл судлалын онолын үндэстэй зохион байгуулах, хэлэлцэх [PLO 2.5.1, 3.2.3]
- 2.3. Бага боловсролын байгалийн ухааны хичээлийн хэрэглэгдэхүүнийг суралцагчдын суралцах онцлогийг харгалзан бэлтгэх, боловсруулах [PLO 2.4.6, 2.5.4, 3.2.3]
- 2.4. Бага боловсролын байгалийн ухааны хичээлд олон хувилбарт үнэлгээний даалгавар боловсруулах чадвартай болох [PLO 2.5.2, 3.2.3]

3. Хандлага

- 3.1. Бага боловсролын байгалийн ухааны хичээлийг зохион байгуулахдаа бүтээлчээр хандах [PLO 1.1.6, 3.1.3, 3.2.3]
- 3.2. Өөрийн мэдлэг, чадвар, арга зүйгээ тасралтгүй дээшлүүлэх хэрэгцээг ухамсарлах [PLO 2.1.2, 3.2.3]

Үнэлгээний жин, хэлбэр:

Ирц, оролцоо: 20%

Бие даалтууд: 50%

Явцын сорил: 30%

Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр, код:	Байгаль шинжлэл (VI), Т.SC 402
Улирал:	3 дамжааны хаврын улирал
Хичээлийн задаргаа:	0:6:0:0(5) (семинар)
Заах багш:	Б. Баярчимэг, Ш.Дауренбек, С.Батхуяг
Е-мэйл хаяг:	Bayarchimeg.b@msue.edu.mn , Daurenbek@msue.edu.mn , Batkhuyag@msue.edu.mn
Утас:	(976)-70112429
Ажлын өрөө:	5 - 308, 5 - 310
Ажиллах цаг:	Даваа-Баасан, 8:40 am - 18:00 pm.

Үндсэн сурах бичиг:

1. Баярчимэг Б., Дамдинсүрэн С., Дауренбек Ш., Содов Ц., (2014). Байгалийн ухаан. Улаанбаатар: Содпресс ХХК
2. Баярчимэг Б., (2017). Бага боловсролын байгалийн ухааны сургалтын агуулга, аргазүй үнэлгээ. Улаанбаатар: Адмон ХХК
3. Дауренбек Ш., (2017), Бага боловсролын байгалийн ухааны үндэс. Улаанбаатар: Адмон ХХК
4. Дауренбек Ш., Баярчимэг Б., (2018). Хүн ба байгаль хичээлийн агуулга, арга зүй үнэлгээ. Улаанбаатар: Адмон ХХК
5. Дауренбек Ш., Баярчимэг Б., (2020). Шинжлэн судлах туршилтууд. Улаанбаатар: Адмон ХХК
6. Содов Ц., Батхуяг С., Баярчимэг Б., Дауренбек Ш., (2018). Байгалийн ухаанд сургах зүй. Улаанбаатар: Содпресс ХХК

Нэмэлт унших материалууд:

1. Баярмаа Г., Батчулуун Е., Болорчимэг Ө., ба бус, (2020) Хүн ба орчин I. Улаанбаатар:
2. Батчулуун Е., Баярмаа Г., Болорчимэг Ө., ба бус, (2020) Хүн ба орчин II, Улаанбаатар:
3. Батчулуун Е., Баярмаа Г., Болорчимэг Ө., ба бус, (2020) Хүн ба орчин III, Улаанбаатар.
4. Алтанцэцэг Д., Батчулуун Е., Баярмаа Г., ба бус, (2020) Хүн ба байгаль IV, Улаанбаатар.
5. Алтанцэцэг Д., Батчулуун Е., Баярмаа Г., ба бус, (2020) Хүн ба байгаль V, Улаанбаатар.
6. Эмхт. Насанбаяр Б., Хишигбаяр Б.,Энхтогтох А., (2020) Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр, Улаанбаатар.
7. Батчулуун Е., (2013). Дэлхий судлал. Улаанбаатар.
8. Тэмүүлэн., (2013).Биологи. Улаанбаатар.
9. Алтангэрэл Н., ба бус. (2013) Физик-1, 2. Улаанбаатар.
10. Доржсүрэн Б., ба бус, (2012).Физик соёмбо нэвтэрхий толь. Улаанбаатар.
11. Баянтөр М., ба бус, (2012). Газарзүй соёмбо нэвтэрхий толь.Улаанбаатар.
12. Суран Д., ба бус. (2012). Биологи соёмбо нэвтэрхий толь. Улаанбаатар.
13. Мижиддорж Д., ба бус. (2012). Хими соёмбо нэвтэрхий толь. Улаанбаатар.

Хичээлийн залгамж холбоо:

Хичээлийн товч тодорхойлолт: Бага боловсролын байгалийн ухааны сургалтын үндэс, эх орон ба орчлон ертөнц, байгалийн юмс үзэгдэл, амьд ба амьгүй байгаль сэдвийн агуулга, аргазүй, хэрэглэгдэхүүн, үнэлгээний талаар мэдлэг, чадвар, хандлага төлөвшүүлэх

Хичээлийн зорилго: Бага ангийн багшаар бэлтгэж буй оюутнуудын бага боловсролын байгалийн ухааны хичээлийн мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлж, байгаль шинжлэл хичээлийг заах аргазүйд суралцах, суралцагчийн танин мэдэх үйлийг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулах чадвартай бүтээгч, судлаач багш болгон хөгжүүлэхэд оршино.

Агуулга: Бага боловсролын байгалийн ухааны сургалтын үндэс, эх орон ба орчлон ертөнц, байгалийн юмс үзэгдэл, амьд ба амьгүй байгаль сэдвийн агуулга, аргазүй, хэрэглэгдэхүүн, үнэлгээ

Хичээлийн сургалтын арга зүй: Тухайн хичээл нь боловсролын системд гарч буй өөрчлөлт шинэчлэлт, сайжруулсан хөтөлбөрийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн бага боловсролын түвшинд заагддаг хүн ба орчин, хүн ба байгаль хичээлүүдийг заах аргазүй мэдлэг, чадвар эзэмшинэ.

- Шинжлэн судлах арга, багаж, тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүн зэргийг хэрхэн ашиглах, үзэл баримтлал, зарчим, хууль, зүй тогтол, үндсэн ухагдахууныг ойлгож, мэдлэгээ бүтээх, шинжлэн судлах арга барил эзэмших
- Баримт, нотолгоонд тулгуурлан мэдлэг, чадвараа үнэлэх, үр дүнг танилцуулах, тухайн агуулгыг судлахад тулгардаг нийтлэг ташаа ойлголт, түгээмэл алдааг илрүүлэх, тэдгээрийг залруулах аргуудыг эзэмших /сорил, туршилтын үр дүнгээр г.м/
- Байгалийн ухааны хичээлийг заах ойроос хол руу, ерөнхийгөөс хэсэг руу заах аргазүйд суралцаж, ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулж, түүнийг туршин заах арга зүйд суралцана.

Хүснэгт 1. Үр дүнгийн хамаарал

Хичээлийн төлөвлөлт	Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадварууд
Бага боловсролын байгалийн ухааны сургалтын үндэс	CLO 1.1., 1.3, 1.4, 3.1
Эх орон ба орчлон ертөнц бүлэг сэдвийн агуулга, аргазүй, хэрэглэгдэхүүн, үнэлгээ	CLO 1.3, 2.1, 2.2, 2.3, 2.4, 3.1, 3.2
Байгалийн юмс үзэгдэл бүлэг сэдвийн агуулга, аргазүй, хэрэглэгдэхүүн, үнэлгээ	CLO 1.3, 2.1, 2.2, 2.3, 2.4, 3.1, 3.2
Амьд ба амьгүй байгаль Байгалийн юмс үзэгдэл бүлэг сэдвийн агуулга, аргазүй, хэрэглэгдэхүүн, үнэлгээ	CLO 1.3, 2.1, 2.2, 2.3, 2.4, 3.1, 3.2

Хүснэгт 2. Хичээлийн төлөвлөгөө

Нийт цаг: 96 цаг

7 хоног	Сэдэв	Семинар
1-6	Бага боловсролын байгалийн ухааны сургалтын үндэс	34
6-10	Эх орон ба орчлон ертөнц бүлэг сэдвийн агуулга, аргазүй, хэрэглэгдэхүүн, үнэлгээ	22
10-14	Байгалийн юмс үзэгдэл бүлэг сэдвийн агуулга, аргазүй, хэрэглэгдэхүүн, үнэлгээ	24
14-16	Амьд ба амьгүй байгаль Байгалийн юмс үзэгдэл бүлэг сэдвийн агуулга, аргазүй, хэрэглэгдэхүүн, үнэлгээ	16
Нийт цаг		96

Үнэлгээ:

№	Үнэлгээний хэлбэр	Эзлэх хувь	Багтаамж
1	Ирц, оролцоо	20%	Ирц 10%, идэвх оролцоо 10% -иар харгалзуулан үнэлнэ.
2	Бие даалтууд	50%	Бие даалтыг 2 удаа гүйцэтгэнэ: - Ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулах - 25% - Mini хичээл бэлтгэх, заах - 25%
3	Явцын сорил	30%	- “Бага боловсролын байгалийн ухааны сургалтын үндэс” бүлэг сэдвийн агуулгаар I сорил (15 %) - II, III, IV бүлэг сэдвийн агуулгаар II сорил (15%) - Хичээлийн ирц, оролцоо, семинарын сэдэвтэй холбоотой зайлшгүй гүйцэтгэх дасгал, даалгавруудыг хийсэн байх

ЭРҮҮЛ МЭНД, АРГА ЗҮЙ (T.SC403) ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА

Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага (CLO):

1. Мэдлэг

- 1.1. Эрүүл ахуй ба орчин, хооллолт ба хөдөлгөөний тухай танин мэдэх, харьцуулах, шинжлэх ухааны үндэстэй тайлбарлах [PLO 1.1.6, 1.3.2, 3.2.4]
- 1.2. Сэтгэцийн, бэлгийн, нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар шинжлэн судлах, эргэцүүлэх [PLO 1.1.6, 1.3.2, 3.2.4]
- 1.3. Аюулгүй байдал, анхны тусламжийн талаар судалж танин мэдэх, тайлбарлах, аюулгүй байдлыг тодорхойлох [PLO 1.1.6, 1.3.2, 3.2.4, 3.4.3]

2. Чадвар

- 2.1. Эрүүл мэндээ хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх [PLO 1.3.2, 3.2.4, 3.4.3]
- 2.2. Эрүүл зан үйлийг хэвшүүлэх, аюулгүй байдлаа хангах, бусдад анхны тусламж үзүүлэх [PLO 1.3.2, 3.2.4]
- 2.3. Эрүүл мэндийн хичээлийг оновчтой зохион байгуулах, агуулгын хувьд хамгийн тохиромжтой арга зүйг сонгох [PLO 1.3.2, 3.2.4]

3. Хандлага

- 3.1. Эрүүл мэндээ хайрлан хамгаалах хандлага төлөвшүүлэх [PLO 1.3.2]
- 3.2. Эрүүл зан үйлийг эрхэмлэх [PLO 1.3.2]
- 3.3. Эрүүл аж төрөх зөв дадал, хэвшилтэй болох хандлага төлөвшүүлэх [PLO 3.2.4]

Үнэлгээний жин, хэлбэр:

Ирц, оролцоо: 20%

Бие даалтууд: 50%

Явцын сорил: 30%

Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр, код:	Эрүүл мэнд арга зүй (Т.SC403)
Улирал:	I дамжааны хаврын улирал
Хичээлийн задаргаа:	0:2:0:0(2). (семинар)
Заах багш:	Б. Баярчимэг, Ш.Дауренбек, С.Батхуяг
Е-мэйл хаяг:	Bayarchimeg.b@msue.edu.mn , Daurenбек@msue.edu.mn , Batkhuуag@msue.edu.mn
Утас:	(976)-70112429
Ажлын өрөө:	5 – 309, 310
Ажиллах цаг:	Даваа-Баасан, 8:40 am - 18:00 pm.
Үндсэн сурах бичиг:	

1. Алтанцэцэг Д., Мөнхжаргал Д., Энхмягмар Д., ба бус, (2020). Бага боловсролын эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж. Багшид зориулсан гарын авлага. IV-V анги. Улаанбаатар. <https://www.meds.gov.mn/post/67588>
2. Алтанцэцэг Д., Мөнгөнтулга Э., Байгалмаа Ч., ба бус, (2018).Бага боловсролын сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж. Эрүүл мэнд. Улаанбаатар.
3. Бага боловсролын сургалтын хөтөлбөр. Сайжруулсан хоёр дахь хэвлэлт. (2019). Эрүүл мэнд. Улаанбаатар. <https://cdn.greensoft.mn/uploads/users/2649/files/Curriculum/EBS/Baga.pdf>
4. Баярмаа Г., Байгалмаа Ч., Мөнгөнтулга Э., ба бус. (2009). Эрүүл мэндийн боловсрол. Сургалтын хөтөлбөр. Улаанбаатар.

Нэмэлт унших материалууд:

1. Баярмаа Г., Батчулуун Е., Болорчимэг Ө., ба бус, (2020). Хүн ба орчин I. Улаанбаатар.
2. Батчулуун Е., Баярмаа Г., Болорчимэг Ө., ба бус, (2020). Хүн ба орчин II, Улаанбаатар.
3. Батчулуун Е., Баярмаа Г., Болорчимэг Ө., ба бус, (2020). Хүн ба орчин III, Улаанбаатар.
4. Мөнгөнтулга Э., Болорцэцэг Д., Жаргал Б., Сонинхишиг Ц. (2020). Эрүүл мэнд IV, Улаанбаатар.
5. Алтанцэцэг Д., Гэрэлмаа С., Сонинхишиг Ц. (2020). Эрүүл мэнд V, Улаанбаатар.
6. Алтанцэцэг Д., Алтанчимэг Д., Байгалмаа Ч., Баяр О. (2005). Хүний бэлгийн амьдрал. Улаанбаатар.
7. Алтантулга Э. (2005, 2008). Анхны тусламж. Гарын авлага. Улаанбаатар.
8. Манай сургууль эрүүл мэндийг дэмждэг (2010). Хүүхдээс хүүхдэд итгэл. Дэлхийн зөн Олон улсын байгууллага. Улаанбаатар.
9. Дондог Э., Мөнгөнтулга Э. (2013). Халдварт өвчин. Улаанбаатар.
10. Хорт зуршлаас татгалзъя. (2010). Гарын авлага. Улаанбаатар.
11. Эрүүл мэнд. (2005). Дэлхийн эрүүл мэндийн байгууллага. Улаанбаатар.

Хичээлийн залгамж, холбоо:

Хичээлийн товч тодорхойлолт: Тухайн хичээл нь бага боловсролын эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн суралцагчдын идэвхтэй үйл ажиллагаа, оролцоонд тулгуурлан шинжлэх ухааны үндэслэлтэй хичээлийг зохион байгуулах арга зүй эзэмшүүлэх уян хатан тогтолцоо бүхий судлагдахуун.

Хичээлийн зорилго: Бага боловсролын түвшинд эрүүл мэнд хичээлийг суралцагчдын идэвхтэй үйл ажиллагаа, оролцоонд тулгуурлан шинжлэх ухаан, онолын үндэслэлтэй хичээлийг зохион байгуулах арга зүйд суралцана.

Агуулга: Бага боловсролын эрүүл мэндийн сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүй

Хичээлийн сургалтын арга зүй: Оюутны оролцоонд суурилсан, практик шинжтэй бөгөөд агуулгын хувьд хамгийн тохиромжтой байх бүтээлч арга зүйг сонгоно.

Хүснэгт 1. Үр дүнгийн хамаарал

Хичээлийн төлөвлөлт	Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадварууд
Эрүүл ахуй ба орчин, хооллолт ба хөдөлгөөн	CLO 1.1, 2.1, 2.3, 3.1, 3.2, 3.3
Сэтгэцийн, бэлгийн, нөхөн үржихүйн эрүүл мэнд	CLO 1.2, 2.1, 2.2, 2.3, 3.1, 3.2, 3.3
Аюулгүй байдал, анхны тусламж	CLO 1.3, 2.2, 2.3, 3.1, 3.3

Хүснэгт 2. Хичээлийн төлөвлөгөө

Нийт цаг: 32 цаг

7 хоног	Сэдэв	Семинар
1-2	Бага боловсролын эрүүл мэндийн сургалтын хөтөлбөр, сурах бичиг	4
3-4	Эрүүл мэндийн хичээлийн онцлог, сургалтын арга зүй	4
5-6	“Хувийн эрүүл ахуй ба орчны эрүүл мэнд” бүлэг сэдвийн онол, арга зүй	4
7-8	“Хооллолт ба хөдөлгөөн” бүлэг сэдвийн онол, арга зүй	4
9-10	“Сэтгэцийн эрүүл мэнд” бүлэг сэдвийн онол, арга зүй	4
11-12	“Бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэнд” бүлэг сэдвийн онол, арга зүй	4
13-14	“Хорт зуршил” бүлэг сэдвийн онол, арга зүй	4
15-16	“Аюулгүй байдал, анхны тусламж” бүлэг сэдвийн онол, арга зүй	4
Нийт цаг		32

Үнэлгээ:

№	Үнэлгээний хэлбэр	Эзлэх хувь	Багтаамж
1	Ирц, оролцоо	20%	Ирц 10%, идэвх оролцоо 10% -иар харгалзуулан үнэлнэ.
2	Бие даалтууд	50%	- Сонголт бүхий теле хичээл 50%
3	Явцын сорил	30%	- Эрүүл мэнд арга зүй хичээлийн агуулгаар 1 удаа сорил (30%)

ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ, АРГА ЗҮЙ (Т.SS401) ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА

Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага (CLO):

Мэдлэг

- 1.1 Иргэний болон ёс суртахуун, үнэт зүйлийн боловсролын онолын үндсийг судлах, тодорхойлох [PLO 3.2.4]
- 1.2 Монгол өв соёл, монголчуудын ёс суртахууны уламжлалт мэдлэг ухааныг тодорхойлох, таних, эрэмбэлэх, [PLO 1.2.2, 3.2.4]
- 1.3 Бага ангийн сурагчдад эзэмшүүлэх иргэний болон ёс суртахууны боловсролын онол, арга зүйн үндсийг нэрлэх, тайлбарлах [PLO 2.3.7, 3.2.4, 3.4.1]

Чадвар

- 2.1 Иргэний болон ёс суртахууны боловсролын онол, үзэл баримтлалыг харьцуулах, задлан шинжлэх, оюун дүгнэлт хийх [PLO, 3.2.4]
- 2.2 Иргэний болон ёс суртахууны боловсролын хичээлийн хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, хичээлийн судалгаа хийх, тайлагнах [PLO 3.1.2, 3.2.4, 3.4.2]
- 2.3 Бага ангийн сурагчдад ёс суртахуун, иргэний боловсролын гол зарчим үнэт зүйлийг хэрэгжүүлэх хүсэл эрмэлзлийг бий болгох арга ухаанд суралцах, тайлбарлах, оюун дүгнэлт хийх [PLO 3.2.4, 3.4.1, 3.4.3]

Хандлага

- 3.1 Ардчилсан нийгмийн үнэт зүйл, ёс суртахууны хэм хэмжээг баримтлах, суралцахууд суралцах, монгол өв соёл, зан заншил үнэт зүйлсийн баримжаа бүхий иргэн болж төлөвших, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах хүсэл эрмэлзэлтэй байх [PLO 3.2.4]
- 3.2 Бага ангийн сурагчдыг иргэний болон ёс суртахууны боловсролтой иргэн болж төлөвшихөд үлгэр дуурайл үзүүлэх, дэмжих, чиглүүлэх бүтээлч хандлагатай багш болох [PLO 3.2.4]

Үнэлгээний жин, хэлбэр:

Ирц, оролцоо: 20%

Би даалтууд: 50%

Явцын сорил: 30%

Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр, код: Иргэний боловсрол, арга зүй, Т.SS401
Улирал: IV дамжааны намрын улирал
Хичээлийн задаргаа, кредит: 2:1:0:0(3), 2
Заах багш: А. Оюунтунгалаг,
Ц. Дэлгэрсайхан,
Н. Үүрийнтуяа,
Л.Санчир

И-мэйл хаяг: oyuntungalaga@yahoo.com
delgersaikhan@msue.edu.mn
nuuriintuya@gmail.com
Lsanchira@gmail.com

Утас: (976)-70112429

Ажлын өрөө: 5-207 тоот өрөө

Ажиллах цаг: Даваа-Баасан, 08:40 am-18:00 pm

Үндсэн сурах бичиг:

1. А. Оюунтунгалаг, Г.Ариунцэцэг. (2019). Иргэний ёс зүйн боловсрол, заах арга зүй. Улаанбаатар.
2. О. Пүрэв. (2007, 2013). Монголын боловсрол, сургалтыг хүмүүншүүлэх онол, арга зүйн зарим асуудал. I, II боть. Улаанбаатар
3. Нээлттэй Нийгэм Форум (2011). ЕБС-ийн иргэний боловсролын сургалтад хийсэн үнэлгээ. Улаанбаатар

Нэмэлт унших материалууд:

1. Ү. Аварзэд. (2007). Монголын нүүдлийн соёл иргэншил бэлчээрийн мал аж ахуй. Улаанбаатар
2. Ч. Авдай. (2003). Монголын нүүдэлчдийн үндэсний уламжлалт технологи. Улаанбаатар
3. “Ардчиллын боловсрол” сургалтын хөтөлбөр.(2014). Улаанбаатар
4. С. Бадамхатан. (1990-1996). Монгол улсын угсаатны зүй, I-IV боть. Улаанбаатар.
5. Г. Батнасан.(1989). Монгол ардын хувцас. Улаанбаатар.
6. Д. Баттогтох. (2009). Үр хөвгүүнийг сургах ёсон. Улаанбаатар.
7. Б. Бямбасүрэн. (2004). Монгол төрийн ёс, ёслол, үндэсний хүндэтгэл. Улаанбаатар.
8. Г. Гонгоржав. (2008). Монголчуудын эрдэм ухааны уламжлал (3 дахь хэвлэл).Улаанбаатар.
9. Ц. Дэлгэрсайхан, И Гён Вон (2017). Бага боловсролын нийгмийн ухааны сургалтын агуулга, үнэлгээ. Улаанбаатар.
10. Зонхова. (2006). Бодь мөрийн зэрэг. Улаанбаатар.
11. Ш. Чоймаа. (2011). Монгол ёс заншил, уламжлалт ухаанаа заан сургагч нарт тус дэм. Улаанбаатар
12. Чоймаа, Ш. (2007). Сэтгэлийг ариусгахуй. Улаанбаатар
13. С. Түмэндэлгэр. (2018). Боловсрол дахь жендер гарын авлага. Улаанбаатар.
14. Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр. (2003). 4 дүгээр тал

Хичээлийн залгамж, холбоо: Т.SS403,

Хичээлийн товч тодорхойлолт: Монголын иргэний боловсролын уламжлалт болон орчин үеийн үзэл баримтлал, олон улсын чиг хандлага, Иргэний ёс зүйн боловсрол

хөтөлбөрийн хүрээнд “Монгол ёс, хүмүүжил” хичээлийн хөтөлбөрийн төлөвлөлт, агуулга, арга зүй, үнэлээг танин мэдэх, хичээл зохион байгуулах ур чадвар.

Хичээлийн зорилго: Бага сургуулийн сурагчдад иргэний мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлэх, хөгжүүлэхэд нь дэмжих, зөвлөн туслах, чиглүүлэх багшлахуйн чадамжид оюутан суралцана

Агуулга: Иргэний боловсролын уламжлалт болон орчин үеийн үзэл баримтлал, онол хандлага, танин мэдэх, Иргэний ёс зүйн боловсрол хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй “Монгол ёс, хүмүүжил” хичээлийн агуулга, арга зүй, үнэлгээний арга зүй

Хичээл сургалтын арга зүй: Энэхүү хөтөлбөр нь *лекц, семинар, бие даалтын ажил* гэсэн хэлбэрээр хэрэгжих ба сургалтын загвар (instruction design) нь оролцоот лекцийн хичээлийг дагасан семинар, хэлэлцүүлэг, оюутны бие даан суралцах үйл ажиллагаа зэргээс бүрдэнэ.

Хүснэгт 1. Үр дүнгийн хамаарал

№	Хичээлийн төлөвлөлт	Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадварууд [CLO]
1	Монголын иргэний боловсролын уламжлалт болон орчин үеийн үзэл баримтлал, олон улсын чиг хандлага	CLO 1.1, 1.2, 1.3, 2.1, 2.2, 2.3, 3.1
2	Иргэний ёс зүйн боловсрол хөтөлбөрийн хүрээнд “Монгол ёс, хүмүүжил” хичээлийн хөтөлбөрийн төлөвлөлт, агуулга, арга зүй	CLO 1.2, 1.3, 2.1, 2.3, 3.1, 3.2
3	Бага боловсролын Иргэний ёс зүйн боловсролын сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, үнэлгээ	CLO 1.3, 2.1, 2.2, 2.3, 3.1, 3.2

Хүснэгт 2. Хичээлийн төлөвлөгөө

Нийт цаг 64

7 хоног	Сэдэв	Лекц	Сем
1-4	Иргэний боловсролын уламжлалт болон орчин үеийн үзэл баримтлал, олон улсын чиг хандлага	4	8
5-12	Иргэний ёс зүйн боловсрол хөтөлбөрийн хүрээнд “Монгол ёс, хүмүүжил” хичээлийн хөтөлбөрийн төлөвлөлт, агуулга, арга зүй	8	16
13-16	Бага боловсролын Иргэний ёс зүйн боловсролын сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, үнэлгээ	4	8
Нийт		16	32

Үнэлгээ:

№	Үнэлгээний хэлбэр	Эзлэх хувь	Багтаамж
1	Ирц, оролцоо	20%	Лекц ба семинарын ирцийг 10%, семинарын хичээл дэх оюутны оролцоог 10% байхаар үнэлнэ.
2	Бие даалтууд	50%	Бие даалтыг 3 удаа гүйцэтгэнэ: - Хөтөлбөрийн II бүлэг сэдвийн хүрээнд багшийн санал болгосон бие даалтын чиглэлүүдээс сонгон, багаар хамтран гүйцэтгэнэ 20 оноо - Бага боловсролын иргэний боловсролын сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, үнэлгээ бүлгийн хүрээнд ганцаарчлан гүйцэтгэх бие даалтын ажлын сэдвээс сонгон, оюутан ганцаарчлан гүйцэтгэнэ 15 оноо

			Тодорхой асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн зөвлөн туслах ажлын хөтөлбөр боловсруулан турших 15 оноо Жич: Үнэлгээг хийхдээ өөрийн үнэлгээ, багшийн үнэлгээ, шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн үнэлгээ хийх зарчмаар үнэлгээний шалгуурыг боловсруулна.
3	Явцын сорил I, II	30%	- I сорил түвшинчилсэн даалгавар /модуль -1, 2 / - оноо - II сорил түвшинчилсэн даалгавар /модуль-3/- оноо Жич: Сорил -I , сорил-II хүрээнд түвшинчилсэн агуулгыг бэлтгэж, зохион байгуулахдаа нэгдмэл байдлаар нэг удаа авч болно.

ХҮН НИЙГЭМ (T.SS 402) ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА

Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага (CLO):

Мэдлэг

- 1.1 Нийгмийн ухааны онол болон үнэт зүйлийн ойлголтыг судлах, нэрлэх [PLO 3.2.4]
- 1.2 Бага ангид заах нийгмийн ухааны хичээлийн хөтөлбөрийн бүтэц, онцлогийг танин мэдэх, тодорхойлох [PLO 2.4.2, 3.2.4]
- 1.3 Бага ангийн сурагчдад нийгмийн ухааны боловсрол олгох онол, арга зүйн үндсийг жагсаах, нэгтгэн дүгнэх [PLO 2.3.7, 3.2.4, 3.4.1]

Чадвар

- 2.1 Бага боловсролын нийгмийн ухааны онол, үзэл баримтлалыг харьцуулах, тайлбарлах, шинжлэх [PLO 1.2.2, 3.2.4]
- 2.2 Нийгмийн ухааны хичээлийн хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, дүн шинжилгээ хийх [PLO 3.1.2, 3.2.4, 3.4.2]
- 2.3 Бага ангийн сурагчдын иргэнших, нийгэмших, дасан зохицох үйл явцыг дэмжихүйц хүсэл эрмэлзэлээ илэрхийлэх, хүний эрхийн боловсролыг тайлбарлах, асуудлыг эрэмбэлэх, шийдвэрлэх үндэслэл дэвшүүлэх, нотлон бичих [PLO 3.2.4, 3.4.1, 3.4.3]

Хандлага

- 2.1 Хүн төрөлхтний болон монголын түүх, соёл, өв уламжлалыг дээдлэж буйгаа илэрхийлэх, нийгмийн үнэт зүйлийг эрхэмлэн сахих шударга иргэн байхаа нотлон бичих, суралцахуйдаа суралцах, сайн сайхан нийгмийг бүтээлцэх хүсэл эрмэлзэлтэй байх [PLO 1.1.3, 3.2.4]
- 2.2 Багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах, өөрийн үзэл бодол, байр сууриа илэрхийлэх, бусадтай зөв боловсон харилцах, бусдыг ойлгох, хүлээн зөвшөөрөх, бие даан ажиллаж амьдрах эерэг хандлагатай болох [PLO 3.2.4]

Үнэлгээний жин, хэлбэр:

Ирц, оролцоо: 20%

Би даалтууд: 50%

Явцын сорил: 30%

Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр, код:	Хүн нийгэм, Т.SS402
Улирал:	IV дамжааны хаврын улирал
Хичээлийн задаргаа, кредит:	2:1:0:0(3), 2 кредит (лекц, семинар, бие даалт)
Заах багш:	А. Оюунтунгалаг, Ц. Дэлгэрсайхан, Н. Үүрийнтуяа, Л.Санчир
И-мэйл хаяг:	oyuntungalaga@yahoo.com , delgersaikhan@msue.edu.mn nuuriintuya@gmail.com Lsanchira@gmail.com
Утас:	(976)-70112429
Ажлын өрөө:	5-207 тоот өрөө
Ажиллах цаг:	Даваа-Баасан, 08:40 am-18:00 pm

Үндсэн сурах бичиг:

1. А. Оюунтунгалаг, Г.Ариунцэцэг. (2019). Иргэний ёс зүйн боловсрол, заах арга зүй. Улаанбаатар.
2. Ц.Дэлгэрсайхан, И Гён Вон. (2017). “Бага боловсролын нийгмийн ухааны сургалтын агуулга, үнэлгээ”. Улаанбаатар

Нэмэлт унших материалууд:

1. “Ардчиллын боловсрол” сургалтын хөтөлбөр.(2014). Улаанбаатар
2. Бага боловсролын сургалтын хөтөлбөр (2019). Улаанбаатар
3. Бага боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх /Суралцахуйн удирдамж/ (2019). Улаанбаатар
4. О. Пүрэв. (2019). “Монголын боловсрол, сургалтыг хүмүүншүүлэх онол, арга зүйн зарим асуудал”. Улаанбаатар
5. Ж. Өлзийсайхан.(2001). “Ардын сурган хүмүүжүүлэх зүйн зарим асуудал”. Улаанбаатар
6. Г.Эрдэнэ-Очир. (1998). “Ардын сурган хүмүүжүүлэх зүй”. Улаанбаатар
7. Х.Самдилдэндэв. (1995). “Монгол ардын сурган хүмүүжүүлэх зүйн туршлага ” Улаанбаатар
8. Зонхова. (2006). Бодь мөрийн зэрэг. Улаанбаатар
9. Ш. Чоймаа. (2011). Монгол ёс заншил, уламжлалт ухаанаа заан сургагч нарт тус дэм. Улаанбаатар
10. Ш. Чоймаа. (2007). Сэтгэлийг ариусгахуй. Улаанбаатар
11. Ш. Ичинхорлоо. (2012). Сургалтын онол, хэрэглээ/ерөнхий дидактикийн үндэс/. Улаанбаатар
12. НБХСХ, ТХБ төсөл. (2017). “Боловсрол дахь жендэр” гарын авлага. Улаанбаатар
13. НБХСХ, ШХА төсөл. (2017). “Бага, дунд боловсрол дахь жендэрийн асуудлууд”. Улаанбаатар
14. БСШУСЯ, АХБ төсөл. (2017). “Дээд боловсрол дахь жендэр”. Улаанбаатар
15. Монгол улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр
16. Нээлттэй нийгэм форум. (2011).“ЕБС-ийн Иргэний боловсролын сургалтад хийсэн үнэлгээ, мониторинг” судалгааны тайлан. Улаанбаатар

Хичээлийн залгамж, холбоо: Т.SS403, S.GS109

Хичээлийн товч тодорхойлолт: Хүн нийгэм хичээлийг судалснаар оюутан бага боловсролын суралцагчдыг хувь хүний болон хамт олон, бүлгийн (нийгмийн) хувьд

нийгмийн идэвхтэй, оролцоот, сонголтот иргэн болж хөгжих, төлөвших, нийгэм, түүхийн үйл явцыг сонирхох, ойлгох, түүнд оролцох, хэм хэмжээг баримтлан харилцах мэдлэг, чадвар, хандлагатай иргэн болж төлөвшүүлэхэд шаардагдах бага боловсролын нийгмийн ухааны боловсролын агуулга, арга зүйн мэдлэг, ур чадвар, хандлагатай болох.

Хичээлийн зорилго: Бага сургуулийн сурагчдад нийгмийн ухааны боловсролын мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлэх, хөгжүүлэхэд нь дэмжих, зөвлөн туслах, чиглүүлэх багшлахуйн чадамжид оюутан суралцана.

Агуулга: Нийгмийн ухааны боловсролын уламжлал болон орчин үеийн үзэл баримтлал, онол хандлага, танин мэдэх, Бага боловсролын нийгмийн ухааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй “Хүн орчин”, “Хүн нийгэм” хичээлийн агуулга, арга зүй, үнэлгээ, хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга зэрэг болно.

Хичээл сургалтын арга зүй: Энэхүү хөтөлбөр нь *лекц, семинар, бие даалтын ажил* гэсэн хэлбэрээр хэрэгжих ба сургалтын загвар (instruction design) нь оролцоот лекцийн хичээлийг дагасан семинар, хэлэлцүүлэг, оюутны бие даан суралцах үйл ажиллагаа зэргээс бүрдэнэ.

Хүснэгт 1. Үр дүнгийн хамаарал

№	Хичээлийн цөм агуулга	Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадварууд [CLO]
1	Бага боловсролын нийгмийн ухааны сургалтын үзэл баримтлал, агуулгын өөрчлөлт, шинэчлэлт	CLO 1.1, 1.3, 2.1
2	Бага боловсролын “Орчин ба орчин”, “Хүн ба нийгэм” хичээлийн хөтөлбөрийн төлөвлөлт, агуулга, арга зүй	CLO 1.2, 1.3, 2.1, 2.2, 2.3, 3.2
3	Бага боловсролын нийгмийн ухааны хичээлийн сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, үнэлгээ	CLO 1.1, 1.3, 3.1, 3.2

Хүснэгт 2. Хичээлийн төлөвлөгөө

7 хоног	Сэдэв	Лекц	Сем
1-4	Бага боловсролын нийгмийн ухааны сургалтын үзэл баримтлал, агуулгын өөрчлөлт, шинэчлэлт	4	8
5-11	Бага боловсролын “Орчин ба орчин”, “Хүн ба нийгэм” хичээлийн хөтөлбөрийн төлөвлөлт, агуулга, арга зүй	8	16
13-16	Бага боловсролын нийгмийн ухааны хичээлийн сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, үнэлгээ	4	8
Нийт		16	32

Үнэлгээ:

№	Үнэлгээний хэлбэр	Эзлэх хувь	Багтаамж
1	Ирц, оролцоо	20%	Нийт 64 цагийн танхимын хичээлд биечлэн суусан тохиолдолд ирцийг 20 оноогоор тооцно. Үүнд: лекц-10, семинар-10 оноо энэ зөвхөн ирцийн оноо 4-5 хүний бүрэлдэхүүнтэй багаар ЕБС-ийн Хүн нийгэм хичээлийн сэдвээс сонгон, ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулж, “мини хичээл” заан турших -10 оноо - Хичээлийн турш хэлэлцүүлэг, илтгэл, мэтгэлцээнд идэвхтэй оролцох- 10 оноо
2	Бие даалтууд	50%	Бие даалтыг 2 удаа гүйцэтгэнэ: Заавал унших ном, материалыг чиглүүлэх асуултуудын тусламжтайгаар бүтээлчээр унших, тэмдэглэл хөтлөн дараах даалгаваруудаас сонгон гүйцэтгэнэ: /ганцаарчлан

			гүйцэтгэх , 15 оноотой/ а. Илтгэл бичих хэлэлцүүлэх, б. эссэ бичиж танилцуулах, с. Тэмдэглэл хөтлөн эргэцүүлэмж бичих, зураглал хийж танилцуулах гэх мэт - Тодорхой асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн зөвлөн туслах ажлын хөтөлбөр боловсруулан турших /Багаар хамтран гүйцэтгэх, 15 оноотой /: а. Хүн ба нийгэм хичээлийг амжилттай зохион байгуулах шилдэг арга туршлагыг судлан үйл ажиллагааны төлөвлөлт хийж турших б. Хүн ба нийгэм хичээлийн сэдвийн хүрээнд төсөлт ажил зохион байгуулж турших с. Хичээлийн агуулгын хүрээнд нийгэмд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор компанит ажил зохион байгуулах аргачлал боловсруулан турших Жич: Үнэлгээг хийхдээ өөрийн үнэлгээ, багшийн үнэлгээ, шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн үнэлгээ хийх зарчмаар үнэлгээний шалгуурыг боловсруулна.
3	Явцын сорил I, II	30%	- I сорил түвшинчилсэн даалгавар /модуль -1, 2 / - 15 оноо - II сорил түвшинчилсэн даалгавар /модуль-3/- 15 оноо Жич: Сорил -I , сорил-II хүрээнд түвшинчилсэн агуулгыг бэлтгэж, зохион байгуулахдаа нэгдмэл байдлаар нэг удаа авч болно.

ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ ҮЙЛ АЖИЛЛАГАА АРГА ЗҮЙ (Т.РЕ417)

ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА

Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага (CLO):

1.Мэдлэг

- 1.1.ХГҮА-ны уламжлал, шинэчлэл, мөн чанар, түүний агуулга, арга, хэлбэрт гарч буй өөрчлөлт, сурагчдын дунд хичээлээс гадуур явуулах ажлын онцлог, ач холбогдлыг тайлбарлах [PLO 2.3.7, 2.3.5 3.1.3]
- 1.2.Олон улсын ХГҮА-ний төрлүүд агуулга, хэлбэр, хэрэгжүүлэх арга зүй, мөн чанарт харьцуулалт хийх [PLO 2.5.1, 2.4.4, 3.3.2]

2.Чадвар

- 2.1.ХГСА-н төрөл, сэдэв, чиглэл, зорилго, зорилт, зорилтуудын хүрээнд өгөх үндсэн агуулгуудтай хүүхдийг хөгжүүлэх чадварыг уялдуулан сонгож хэрэгжүүлэх [PLO 2.1.2, 2.2.6, 3.3.1]
- 2.2.Боловсролын шинэчлэлийн үзэл санаа, 21-р зууны Монгол сурагчийн компетенцийн нэгэн загварт дүн шинжилгээ хийж, сонгосон ХГҮА-гаа хувь хүн, сургууль, нийгмийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан төлөвлөх, зохион байгуулах [PLO 2.1.3, 2.2.3, 2.3.7, 2.5.3, 3.3.2]

3. Хандлага

- 3.1.Сурагч нэг бүрийг хамт олны үйл ажиллагааны явцад өөртөө итгэлтэй, өөрийгөө удирдах, хөгжүүлэх, бусдыг манлайлах чадвартай, хөгжилтэй, эвсэг, ажилсаг хамт олныг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулдаг бүтээлч, санаачилгатай, оролцоот иргэн болж төлөвших, хүүхдийг төлөвшүүлэх явцыг чин сэтгэлээсээ дэмждэг, сайжруулах арга замыг эрэлхийлэх [PLO 2.3.2, 3.1.3, 3.4.3]

Үнэлгээний жин, хэлбэр:

Ирц, оролцоо: 20%

Бие даалтууд: 50%

Явцын сорил: 30%

Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр, код:	ХГҮААЗ, Т.РЕ417
Улирал:	4 дамжааны хаврын улирал
Хичээлийн задаргаа:	0:2:0:0(2). (семинар)
Заах багш:	багшийн нэр, Н.Цогзолмаа
Е-мэйл хаяг:	tsogzolmaa.n@msue.edu.mn
Утас:	(976)-70112429
Ажлын өрөө:	5 – р байр 313
Ажиллах цаг:	Даваа-Баасан, 8:40 am - 18:00 pm.
Үндсэн сурах бичиг:	

1. Цогзолмаа.Н нар Сургалтыг дэмжих үйл ажиллагаа УБ. 2017
2. Цогзолмаа.Н. Хичээлээс гадуурх үйл ажиллагаа арга зүй,. УБ 2022,Мөнхийн үсэг

Нэмэлт унших материалууд:

1. Цогзолмаа. Н. Оюутан-багш төлөвших явцад хичээлээс гадуурх ажил нөлөөлөх нь” диссертаци. 2010. УБ.
2. Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр.(2014). Хичээлээс гадуурх үйл ажиллагаа. Улаанбаатар. Колорфул.
3. Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих бага боловсролын цөм хөтөлбөрийн хэрэгжилт-зөвлөн туслах үйлчилгээ, мониторингийн тайлан.(2015)
4. Бага насны хүүхдийн сэтгэл судлал.(2013)МУБИС.СӨБС. Улаанбаатар.BCI.
5. Japan Society for Educational Technology. 日本教育工 学会論文誌 36 (4>, 407–418. 2013. 教職志望学生のフレンドシップ参加経験と授業・教師・子どもイメージ及び教育実習前後の変容との関係. (Jpn. ノ、Educ TechnoL)

Хичээлийн залгамж, холбоо: Бага боловсролын нэгдмэл арга зүй –Т.РЕ202, Ерөнхий сэтгэл судлал-Е.GP202, Байгаль шинжлэл, арга зүй-Т.SC402, Эрүүл мэнд амьдрах ухаан-S.SS109, Бүтээлч сэтгэлгээ-S.SS112, Экологи, байгаль хамгаалал-S.SS106, Тэгш хамруулах боловсролын үндэс-Т.РЕ203, Технологи, арга зүй-Т.AR411, Дүрслэг урлаг-Т.AR410, Биеийн тамир, арга зүй-Т.РТ405, Хөгжим,арга зүй-Т.РЕ407 Хүүхэд хамгаалал-Е.CP321

Хичээлийн товч тодорхойлолт: Хичээлээр судалсан болон хичээлээс гадуур ахуй амьдралаас олж авсан мэдлэг, чадвар, хандлагаа хүний хөгжлийн зүй тогтолын дагуу бататган эзэмших боломж бөгөөд хүүхэд бүрийн авьяас чадвар, хүсэл сонирхол, хувь онцлогийг нь нээх, хөгжүүлэх замаар бие даан суралцах, амьдрах чадвартай, бүтээлч идэвх оролцоотой, эрүүл, амьдралын зөв дадал хэвшилтэй, өөртөө итгэлтэй, өөрийгөө удирдах, хөгжүүлэх, чадвартай иргэн болж төлөвшихөд энэхүү хичээл чиглэгдэнэ.

Хичээлийн зорилго: Хичээлээс гадуурх үйл ажиллагаа нь суралцагчийн хэрэгцээ сонирхол, онцлог байдалд тулгуурлан түүний хөгжил, төлөвшил, нийгэмшихүйг дэмжсэн байх ба хүн болох арга ухаан, бие даан өөрийгөө авч явах мэдлэг, чадвар, дадалтай болгоход оюутан-багш төлөвшүүлэхэд оршино.

Агуулга: ХГҮААЗ хичээлийн гол агуулга нь хичээлээр үзэж судалсан болон хичээлээр үзэж судлаагүй багшийн ажлын байранд өдөр тутмын хэрэглээ болдог “зүйл”-үүд, мөн бусад судлагдахуунуудыг баяжуулах дэлгэрүүлэх түүнийг бодит болгох туршиж судалж үзэх агуулгыг багтааж байдаг.

Хичээлийн сургалтын арга зүй: Хичээлээс гадуурх ажил нь хичээлийг бодвол илүү нээлттэй, уян хатан, хүүхэд бүрийн хэрэгцээ сонирхол, өөрийн санаачилгад тулгуурласан арга зүйг сонгодог учраас орчин үеийн ямар ч инноваци бүхий технологи хэрэглэх боломжтой.

Хүснэгт 1. Үр дүнгийн хамаарал

Хичээлийн төлөвлөлт	Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадварууд
Хичээлээс гадуурх үйл ажиллагаа явагдаж ирсэн уламжлал, түүх, өнөөгийн байдал, мөн чанар	[CLO 1.1,1.2,]
ХГҮА-г төлөвлөлт	[CLO 2.1, 2.2, 3.1]
Хичээлээс(танхим) гадуурх үйл ажиллагаа зохион байгуулалт	[CLO 1.1,1.2, 2.1, 2.2, 3.1]

Хүснэгт 2. Хичээлийн төлөвлөгөө

Нийт цаг: 32 цаг

7 хоног	Сэдэв	Семинар
1-2	Хичээлээс гадуурх үйл ажиллагаа түүний уламжлал шинэчлэл	4
3-4	Хичээлээс гадуурх үйл ажиллагааны мөн чанар/ ХГҮА яагаад чухал бэ?/	4
5-6	Хичээлээс гадуурх үйл ажиллагааны арга зүйн асуудал	4
7-8	Хичээлээс гадуурх үйл ажиллагаа бусад судлагдахуун болон бусад...-тай холбогдох нь	4
9-10	Олон нийтийн оролцоот ажил	4
11-13	“...” сэдэвт ажлаа зохион байгуулах, хийж гүйцэтгэх	6
14-16	“...” сэдэвт үйл ажиллагаа тайлагнах, хамгаалх, үр дүнгээ тооцуулах	6
Нийт цаг		32

Үнэлгээ:

№	Үнэлгээний хэлбэр	Эзлэх хувь	Багтаамж
1	Ирц, оролцоо	20%	Ирц 10%, идэвх оролцоо 10% -иар харгалзуулан үнэлнэ.
2	Бие даалтууд	50%	- Бага боловсролын цөм хөтөлбөрийн хичээлээс гадуурх үйл ажиллагаатай танилцсан байдал
3	Явцын сорил	30%	- Явцын гүйцэтгэл, сорил-15% - Өөрийн бүтээлд суурилсан үнэлгээ-15%

ДҮРСЛЭХ УРЛАГ АРГА ЗҮЙ (Т.AR410) ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА

Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

Хичээлээр эзэмших мэдлэг, чадвар, хандлага (CLO):

1. Мэдлэг

- 1.1.Дүрслэх урлагийн онол, урлагийн чиг хандлага, нэр томъёог өөрийн орны болон олон улсын зураачдын уран зураг, хүүхдийн зурсан зургийн бүтээлийн жишээнээс ялган таньж ойлгох [PLO 1.1.1, 2.1.1, 3.2.5]
- 1.2.Дүрслэх урлагийн зохиомж, өнгө будгийн шинж чанар, уламжлалт зураг, зурж будах аргуудыг өөрийн бодол төсөөллөөр тайлбарлах [PLO 1.1.1, 3.2.5]

2. Чадвар

- 2.1.Дүрслэх урлагийн төрөл зүйлийн ялгаатай байдлыг оношлох, дүн шинжилгээ хийж хүүхдийн зурсан зураг бүтээлийн жишээгээр үзүүлэх [PLO 1.1.1, 2.1.1, 2.4.1, 3.2.5]
- 2.2.Дүрслэх урлагийн бүтээлийн ялгаатай байдал онцлогийг тооцож, суралцахуй болоод багшлахуйд хэрэгжүүлэх боломж арга замыг эрэлхийлж, өөрийн бодол төсөөллөөр харьцуулан тодорхойлох, баяжуулах, дүрслэн харуулах [PLO 2.1.1, 2.4.1, 3.2.5]
- 2.3.Бага боловсролын дүрслэх урлагийн сургалтын арга зүй, хэрэглэгдэхүүн, зохиомжлох, зурж будах аргуудыг оновчтой сонгож, ашиглах [PLO 1.1.1, 2.1.1, 2.4.1, 3.2.5]
- 2.4.Монголын уламжлалт зураг дүрслэл, хээ угалз, дагнаас, өнгийн нэршил, бэлгэдлийг тайлбарлах, зураг дүрслэлдээ ашиглах, онцлог ялгааг баяжуулах [PLO 1.1.1, 2.1.1, 2.4.1, 3.2.5]

3. Хандлага

- 3.1.Өөрийн зураг дүрслэл, өнгийн мэдрэмж, идэвх санаачилга, бүтээлчээр суралцах хандлагад ахиц гаргах [PLO 2.1.1, 2.4.1, 3.2.5]
- 3.2.Хүүхдийн дүрслэн урлах үйлийг хөгжүүлэх шинэ арга зүйг боловсруулах арга замыг эрэлхийлэх [PLO 2.1.1, 2.4.1, 3.2.5]

Үнэлгээний жин, хэлбэр:

Ирц, оролцоо: 20%

Бие даалтууд: 50%

Явцын сорил: 30%

Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр, код:	ДҮРСЛЭХ УРЛАГ АРГА ЗҮЙ, Т.АR410
Судлах улирал:	Намар, хавар
Кредит:	3 <i>кредит</i>
Хичээлийн задаргаа:	1:2:0:2 (5) (лекц, семинар, практик)
Заах багш:	Н.Хүдэрчулуун
Мэйл хаяг:	khuderchuluu@msue.edu.mn
Утас:	(+976) 96675004
Ажлын өрөө:	МУБИС 5-р байр 112 тоот
Ажиллах цаг:	Даваа-Баасан, 8:40 am - 18:00 pm.

Үндсэн сурах бичиг:

1. Баярмагнай З. Нар (2018) Дүрслэх урлаг арга зүй. Улаанбаатар

Нэмэлт унших материалууд:

1. Цэдэн-Иш Д. (2017) Дүрслэх урлаг сургалтын онол арга зүй. Улаанбаатар
2. Эрдэнэцог Ц. нар (2015) Дүрслэн урлахуйн үндэс. Улаанбаатар
3. Цэдэн-Иш Д. (2011) Дүрслэх урлагийн багшийн ном. Улаанбаатар
4. Батчулуун С. нар (2010) Дүрслэх Урлагийн боловсрол. Улаанбаатар
5. Эрдэнэцог Ц. (2006) ХХ зууны монголын уран зургийн өнгө зохицол. Улаанбаатар
6. Энхдаваа Д. (2002) Зохиомж. Улаанбаатар

Хичээлийн залгамж, холбоо:

Хичээлийн товч тодорхойлолт: Дүрслэх урлагийн онолын үндсэн ойлголттой болох, урлан бүтээх, сэтгэн бодох, бүтээлч хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн зураг дүрслэл, ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн агуулга бүхий урлахуйн ухааны хичээл.

Хичээлийн зорилго: “Дүрслэх урлаг арга зүй” хичээлээр дүрслэх урлагийн төрөл ангилал, урсгал чиглэл, зохиомжийн тухай урлаг гоо зүйн ойлголтыг судлахын зэрэгцээ зургийн хавтгайд цэг, толбо, зураас, хэлбэр дүрс, өнгө гэрэл сүүдэр, хөдөлгөөнийг зохиомжлон зурж дүрслэх арга барилд суралцаж тэдгээрийн уялдаа холбоог зохистой хослуулах, нэгдмэл санааг илэрхийлэх, зурж дүрслэх аргуудыг эзэмшин хэрэглээ болгоход оршино.

Агуулга: Дүрслэх урлагийн сургалтын хөгжлийн тойм, зохиомжийн төрөл, арга хэрэгсэл, урлан бүтээх үйл, үндэсний урлал

Арга зүй: Оюутан нэг бүрийн бүтээл, бие даалт хийх явцдаа эрэл хайгуул хийх, харилцан бие биеэсээ суралцах, таамаглал дэвшүүлэх, дүгнэлт анализ хийж багштайгаа эргэх холбоотой ажиллах зарчмаар суралцахууд суралцана.

Хүснэгт 1. Үр дүнгийн хамаарал

№	Хичээлийн төлөвлөлт	Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадварууд
1	Бага боловсролын дүрслэх урлагийн сургалтын агуулга, арга зүй	CLO:1.1, 2.1, 2.2, 2.3, 3.1, 3.2
2	Зохиомжийн төрөл арга, хэрэгсэл	CLO:1.2, 2.3, 3.1, 3.2
3	Урлан бүтээх үйл	CLO:1.2, 2.2, 2.3, 3.1, 3.2
4	Үндэсний урлал	CLO:1.2, 2.1, 2.4, 3.1, 3.2

Хүснэгт 2. Хичээлийн төлөвлөгөө

Нийт цаг: 80 цаг

7 хоног	Сэдэв	Лекц	Семинар	Практик
1-12	Бага боловсролын дүрслэх урлагийн	4	26	2

	сургалтын агуулга, арга зүй			
2-8	Зохиомжийн төрөл арга, хэрэгсэл	8	0	14
9-16	Урлан бүтээх үйл	0	6	8
7-16	Үндэсний урлал	4	0	8
Нийт цаг		16	32	32

Үнэлгээ:

№	Үнэлгээний хэлбэр	Эзлэх хувь	Багтаамж
1	Ирц, оролцоо	20%	1. Семинарын хичээлд суусан ирцийг бүртгэж, ирцийг 10%-аар тооцно. 2. Семинарын сэдэвтэй холбоотой даалгаврын гүйцэтгэсэн байдал, тэмдэглэл хөтөлсөн байдлыг харгалзан 10%-аар тооцно.
2	Бие даалтууд	50%	- Дүрслэх урлагийн бүтээл тайлбарлах /Уран зураг, унших/ 16% - Хавтгай болон биет дүрсийн зохиомж 17% - Сэдвийн хүрээнд зурж дүрслэх 17%
3	Явцын сорил	30%	Хичээлийн агуулгаар үзүүлэн тараах материал боловсруулах (Практик хичээлийн дасгал даалгварын гүйцэтгэлээр 30%)

ТЕХНОЛОГИ, АРГА ЗҮЙ (Т.AR411) ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА

Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага (CLO):

1. Мэдлэг

- 1.1 Технологийн хичээлийн агуулга, онол арга зүйн үндэс ухагдахууныг тайлбарладаг, хүүхдийн хөгжлийг дэмжих дасгал даалгавар, бүтээлч ажлуудтай танилцаж, шинэлэг санаа дэвшүүлэх зохиомжийн хэрэгслүүдийг нэрлэдэг, ялган таних [PLO 3.2.5, 3.3.2]
- 1.2 Материалын шинж чанар, түүнийг боловсруулах арга ажиллагаатай танилцаж, тэдгээрийг хэлбэржүүлэх, зохиомжлох, боловсруулах аргуудыг сонгон урлах арга ажиллагаа, жишээн дээр тайлбарлах, тодруулах. Урлах арга ажиллагааны үе шат, тавигдах шаардлага, зарчмыг тодорхойлох [PLO 1.1.5, 3.2.5]
- 1.3 Урлан бүтээх төрөл бүрийн арга техник, технологийн үйл ажиллагааны үе шат, онцлогт тохируулан зохиомжлох мэдлэгээ бүтээлдээ ашиглах, шинэлэг арга ажиллагаа, санал дэвшүүлэх [PLO 3.2.5]

2. Чадвар

- 2.1 Технологийн хичээлийн хөтөлбөрийг зохион бүтээх болон бүтээлч сэтгэлгээний аргуудыг сэдэв сонгон боловсруулах, жижиг эдлэлийн загвар зохиох, шинэ хувилбараар зохиомжлох, загварчлах, хүүхдийг хөгжүүлэх дасгал даалгавар, боловсруулж хэрэгжүүлэх [PLO 3.3.2, 2.5.4]
- 2.2 Аливаа бүтээл, эдлэл хийхдээ багаж хэрэгсэл, материалын шинж чанар, загвар зохиомжийг харгалзан зөв сонгох [PLO 2.5.4]
- 2.3 Цаас картон болон бусад материалын бат бөх чанарыг сайжруулах арга ажиллагааг гүйцэтгэх, хэлбэр дүрсийг өөрчлөх, загварчлах арга замуудыг туршин зохин бүтээх, асуудлыг шийдвэрлэх [PLO 3.2.5]
- 2.4 Урлан бүтээхдээ зохиомжийн арга хэрэгслүүдийг ашиглан өнгө зохицол, хэлбэр дүрс, хэмжээ харьцааг зөв шийдэж, технологийн дагуу цэвэр үзэмжтэй гүйцэтгэх [PLO 3.2.5, 1.1.2]

3. Хандлага

- 3.1 Цаг үе, өөрчлөлтийг соргоогоор мэдэрч, шинэ санаа, шинэлэг арга технологийг дэмжих, бүтээлч шинжээ хөгжүүлэх хандлага төлөвших [PLO 1.1.1]
- 3.2 Бүтээх урлах хүсэл эрэмэлзэлтэй, өв соёл, урлагийн үнэт зүйлийг эрхэмлэх [PLO 3.2.5]

Үнэлгээний жин, хэлбэр:

Ирц, оролцоо: 10%

Бие даалтууд: 50%

Явцын сорил: 40%

Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр, код: Технологи арга зүй, Т.АR411

Улирал: III дамжааны намар, хавар

Хичээлийн задаргаа: 1:2:0:2(5) (лекц, семинар, практик)

Заах багш: А.Нэргүй, Б.Жаргал

Е-мэйл хаяг: nergui.a@msue.edu.mn, jargal.b@msue.edu.mn

Утас: (976)- 99250546, (976)-99001941

Ажлын өрөө: 5-216, 5-206

Ажиллах цаг: Даваа–Баасан, 9:00 am – 18:00 pm.

ULMS хаяг: <http://203.212.28.101/index.aspx>

Үндсэн сурах бичиг:

1. Баярмагнай, З., нар (2021) *Бага боловсролын технологи арга зүй*. Улаанбаатар хот. **Нэмэлт судлах материалууд:**

1. Алтанцэцэг, П. (2000) *Идэвхтэй сургалтын 50 арга*. Улаанбаатар.
2. Батчулуун, С., нар (2013.) *Дүрслэх урлагийн боловсрол*. Улаанбаатар
3. Батхуяг, С. (2020.) *Боловсролын философи орчин үеийн үзэл санаа*. Улаанбаатар
4. Баярмагнай, З., нар (2018). *Бага боловсролын дүрслэх урлаг сургалтын онол арга зүй*. Улаанбаатар.
5. Баярмагнай, З., (2013). *Суралцагчдын зохиомжлох үйлийн баримжааг хөгжүүлэх арга зүй*. Улаанбаатар
6. Боловсролын хүрээлэн (2019) *Бага боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамж*. Дүрслэх урлаг технологи I-V анги
7. Жаргал, Б. (2016) *Зүймэл даавуун урлал*. Улаанбаатар.
8. Ичинхорлоо, Ш. (2013) *Сургалтын онол, хэрэглээ*. Ерөнхий дидактикийн үндэс\ Улаанбаатар
9. Ичинхорлоо, Ш. (2014) *Сургалтын арга*. Улаанбаатар.
10. Ичинхорлоо, Ш. (2014) *Хүүхдийн хөгжил*. Улаанбаатар
11. Ичинхорлоо, Ш. (2018) *Боловсролын социологийн удиртгал*. Улаанбаатар.
12. Маями, Ш., Нэргүй, А., (2012) *Бага ангийн дүрслэх урлаг, технологи*. Улаанбаатар.
13. Мөнхбаяр, Д., нар. (2003). *Зураг төсөл-5*. Улаанбаатар.
14. Мэндээ, Г. (2001) *Бүтээлч сэтгэлгээ*. Улаанбаатар.
15. Наранхүү, С. (1989). *Техникийн загвар зохион бүтээх*. Улаанбаатар
16. Нэргүй, А. (2016) *Цаас нугалах урлал*. Улаанбаатар
17. Нэргүй, А., Жаргал, Б (2012) *Цаасны ертөнцөөр аялахуй*. Улаанбаатар
18. Норжинхорлоо, Н. (2000) *Уран хатгамал*. Улаанбаатар
19. Өнөрмаа, О. (1997) *Уран хатгамал*. Улаанбаатар
20. Удвал, Г. (2013) *Цаасаар урлахуй*. Улаанбаатар
21. Хөхөө, Д (2007) Багшийн ном. *Технологийн бага боловсрол*, Улаанбаатар
22. Хөхөө, Д. (1999) *Бага ангид шавь төвтэй сургалтыг хэрэгжүүлэх онол, арга зүй*. Улаанбаатар.
23. Чулуунаа, Г., нар. (2015). *Багшийн ном. Дизайн технологи -YI-YII*. Улаанбаатар
24. Цэдэн-Иш, Д., нар (2021) *Дүрслэх урлаг, Технологийн сурах бичиг I-5 анги*. Улаанбаатар.
25. Цэрэнханд, М. (1994) *Уран хатгамал*. Улаанбаатар
26. Эни Кокс. (2010) *Вышивка шелковыми лентами*. Журнал
27. Gardner, H. (1989) *To Open Minds*. American Education. New York; Basic Books

Хичээлийн залгамж холбоо:

Хичээлийн товч тодорхойлолт: Бага боловсролын технологи арга зүйн үндсийг судалж, бүтээлч сэтгэлгээ, урлан бүтээх арга барилыг хөгжүүлэхэд шаардагдах мэдлэг, чадварыг эзэмших, хандлага төлөвших зорилгод чиглэсэн онол арга зүйн хичээл.

Хичээлийн зорилго: Бага боловсролын технологи заах арга зүйн хичээлийн сургалтын хөтөлбөрийг төлөвлөх, боловсруулах, үнэлэх, сайжруулах, хүүхдийн хөгжлийг сургалтаар дэмжих, урлан бүтээх үйл ажиллагааны зөв арга барил эзэмшиж улмаар багшлахуйд хэрэгжүүлэх мэдлэг, ур чадвар, хандлага төлөвшихөд оршино.

Агуулга: Бага боловсролын технологийн сургалтын онол, арга зүйн ухагдахуунд тулгуурлаж, материал багаж хэрэгслийг зориулалтын дагуу сонгон хэрэглэж, урлан бүтээх технологи арга ажиллагааны талаарх агуулга багтсан болно.

Хичээлийн сургалтын арга зүй: Товч мэдээлэл, ярилцлага, бүтээлч эрэлхийллийн арга, кейс анализ, зураглал (мэдлэг, чадвараа үнэлэх, үр дүнг танилцуулах), бүтээлч даалгаврууд (суралцагчид хамтарч ажиллах, суралцах үйл ажиллагаагаа өөрсдөө төлөвлөх, зохион байгуулах, асуудал шийдвэрлэх), урлан бүтээх практик үйл ажиллагаа (зохиох-бүтээх-хэрэглэх гэсэн тогтолцоонд авч үзэх) зэрэг сургалтын арга зүйг ашиглана.

Хүснэгт 1. Үр дүнгийн хамаарал

Хичээлийн төлөвлөлт	Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадварууд
Бүлэг сэдэв-1 Бага боловсролын технологийн сургалтын агуулга, онол, арга зүй	CLO [1.1, 2.1]
Бүлэг сэдэв-2 Боловсруулах технологи, хэрэгжүүлэх арга зүй	CLO [1.2, 2.2, 2.3, 3.1]
Бүлэг сэдэв-3 Урлан бүтээх технологи, хэрэгжүүлэх арга зүй	CLO [1.3, 2.4, 3.2]

Хүснэгт 2. Хичээлийн төлөвлөгөө

Нийт цаг: 80 цаг

7 хоног	Сэдэв	Лекц	Семинар	Практик
1-2	Бага боловсролын технологийн хичээлийн хөтөлбөр хэрэгжүүлэх арга зүй	2	6	6
3-4	Сургалтын аргуудыг технологийн хичээлд сонгон хэрэглэх	2	4	4
5-6	Хүүхдийн хөгжлийг технологийн хичээлээр дэмжих арга зүй	2	4	4
7-8	Материалын шинж чанар , багаж хэрэгсэлийг сонгох, хэрэглэх	2	4	4
9-10	Цаасан материалын үүсэл хөгжил, хэрэглээ	2	4	4
11-12	Гар оёдлын төрлүүд, хэрэглээ	2	4	4
13-14	Бүтээх урлах технологи-1	2	4	4
15-16	Бүтээх урлах технологи-2	2	2	2
Нийт цаг		16	32	32

Үнэлгээ:

№	Үнэлгээний хэлбэр	Эзлэх хувь	Багтаамж
1	Ирц, оролцоо	10%	Лекц болон семинарын хичээлд суусан ирцийг бүртгэж, ирцийг 5%-аар тооцно. Хичээлд оролцсон идэвх,

			оролцоо, явцын болон бие даасан дасгал, даалгавруудыг тогтмол хийсэн гүйцэтгэл, семинарын хичээлд бүтээлч байдлаар оролцсон хандлага зэргийг 5%-аар тооцно.
2	Бие даалтууд	50%	Бие даалтыг 3 удаа гүйцэтгэнэ:50%
3	Явцын сорил	40%	1. Семинарын явцад гүйцэтгэсэн ажлууд-15% 2. Практик хичээлийн явцад гүйцэтгэсэн ажлууд 15% 3. Онолын мэдлэг шалгах тест-10%

ХӨГЖИМ, АРГА ЗҮЙ (Т.РЕ407) ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА

Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага (CLO):

1.Мэдлэг

- 1.1.Боловсролын онол, арга зүйн мэдлэгээ багшлахуйн үйл ажиллагаанд хэрэглэх, сургалтын шинэ арга зүйг турших [PLO 2.3.2, 2.3.4]
- 1.2.Ноотны анхан шатны мэдлэгийг хэрэглэх, нэр томьёог таниулах [PLO 2.3.2, 2.3.6]

2.Чадвар

- 2.1.Ноотны хэмнэл, хэмжээ, хөгжмийн илэрхийллийг бүтээлд ашиглах [PLO 2.3.6, 2.4.2]
- 2.2.Бага ангийн сурагчдын заавал сурах дуу, бүжиг, жүжигчилсэн тоглолт, яруу уран хэллэгийг заан сургах, хичээлээс гадуурх үйл ажиллагаа, урлаг, уран сайхны бүтээлч даалгаврыг зохион байгуулах [PLO 2.3.3, 2.4.2, 3.3.1, 3.2.5]
- 2.1.Даралтат болон энгийн хөгжмийн зэмсгээр хүүхдийн дуу тоглох [PLO 2.3.6, 2.4.2]
- 2.3.Хичээлээ төлөвлөх, сургалтын аргыг оновчтой сонгон хэрэглэх, үр дүнг боловсруулах, сайжруулах, сайн туршлагыг нэвтрүүлэх [PLO 2.3.3, 2.4.2, 3.3.1, 3.2.5]

3.Хандлага

- 3.1.Бие даан давтах өөрийгөө хөгжүүлэх, тасралтгүй суралцах чадвартай, хариуцлагаа ухамсарладаг, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг мөрддөг, нөхцөл байдалд зохицон ажилладаг байх [PLO1.2.2, 2.1.3, 2.2.5]
- 3.2.Асуудал дэвшүүлэх, шийдвэрлэх арга замыг боловсруулах, хэрэгжүүлэх, дүгнэлт гаргах
- 3.3.Нийгэм, хүмүүнлэгийн ухааны мэдлэг эзэмшиж, соёлын үзэгдэл, үйл явцад оролцох, үнэлэх [PLO 2.1.3, 2.2.5]

Үнэлгээ

Ирц оролцоо: 10%

Бие даалт: 50%

Эцсийн үнэлгээ: 40%

Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр, код:	Хөгжим, арга зүй, Т.РЕ407
Улирал:	IV дамжааны хаврын улирал
Хичээлийн задаргаа:	0:2:0:2(3) семинар: (практик)
Заах багш:	Л. Баяраа, О.Шинэбаяр
Е-мэйл хаяг:	bayaraa.l@msue.edu.mn , bayaraa.l@msue.edu.mn
Утас:	(976)-99281315
Ажлын өрөө:	5-р байр 219
Ажиллах цаг:	Даваа-Баасан, 8:40 am - 18:00 pm.

Үндсэн сурах бичиг:

1. Ш.Баттоогоо. (2019). *Хөгжмийн онол*. УБ: Amia.
2. Батболд, С. (1998). *Бага ангийн багшдаа баярлалаа*. Улаанбаатар.
3. Батболд, С. (2021). *Монголын хүүхдийн дууны шилдэг түүвэр*. Улаанбаатар: Номтой.
4. Г. Ганцэцэг, Д. А. (2013). *Хөгжмийн боловсролд*. Улаанбаатар: адмон.
5. Жанцанноров, Н. (1998). *Хөгжмийн нэр томъёоны тайлбар толь*. Улаанбаатар .
6. Ч. Оюунбилэг.нар.,(2011). *Хөгжим I-V*. Улаанбаатар.
7. Ч.Батсүх. (2017). *Хүүхдийн хөгжмийн боловсролд*. Улаанбаатар.
8. Hoffer, C. (2016). *Introduction to Music Education” level 1-6*. chicago.
9. Campbell, P. S. (2006). *Music in childhood*.

Нэмэлт унших материалууд:

1. Бага боловсролын цөм хөтөлбөр УБ., 2019
2. Бага боловсролын хөгжмийн сургалтыг хэрэгжүүлэх зөвлөмж 2014
3. Ч. Оюунбилэг “Хөгжмийн сургалтын арга зүй” I-V гарын авлага
4. Б.Цэвээнсүрэн “Төгөлдөр хуур хөгжмөөр тоглох арга зүй”
5. John Thompson “Modern course for the piano”

Хичээлийн залгамж, холбоо: Хүүхдийн дуу хөгжимдөх арга зүй, Т.РЕ411

Хичээлийн товч тодорхойлолт: Бага ангийн сурагчдад хөгжмийн онолын мэдэгдэхүүнийг бататган хөгжим сонсох, хөгжимт хөдөлгөөн, дуу заах үйлийг тэдний нас сэтгэхүйн онцлогт тохируулан зохион байгуулах мэдлэг чадварыг олгох арга зүйн хичээл.

Хичээлийн зорилго: Хөгжмийн онолын анхны мэдэгдэхүүнийг судалж, даралтат болон энгийн хөгжмийн зэмсгээр хүүхдэд зориулсан дууг хөгжимдөж сурах, бага ангийн сурагчдын гоо зүй, уран сайхны мэдрэмжийг хөгжүүлэх арга барилд суралцах

Агуулга: Сургуулийн бага насны хүүхдийн хөгжмийн боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сургалтын орчныг зохион байгуулах агуулга, арга зүйн мэдлэг, ур чадвар, хандлага төлөвшүүлэхэд чиглэнэ.

Хичээлийн сургалтын арга зүй:

Хичээлийг оюутны оролцоо төвтэй, сургалтын явцад суралцагчдын бүтээлч үйл ажиллагааг сэдэлжүүлэх, дэмжих, дуулах хөгжимдөх ур чадварыг нэмэгдүүлэх зэрэг оюутан нэг бүрийг хөгжих боломж, сэтгэл зүйн таатай орчныг бүрдүүлэх. Хичээлийн үндсэн арга зүй нь 7-11 хүртэлх насны сурагчдын хөгжмийн боловсролын үндсэн чадварыг хөгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаанд тулгуурлана.

Хүснэгт 1. Үр дүнгийн хамаарал

Хичээлийн төлөвлөлт	Хичээлээр эзэмших мэдлэг,
---------------------	---------------------------

	ур чадварууд
Хөгжмийн онолын мэдэгдэхүүнийг олгох арга зүйд суралцах	[CLO 1.1, 1.2]
Бага ангийн сурагчдад хөгжим сонсгох үйл ажиллагаа, хөгжимт хөдөлгөөн, дуу заах аргачлалыг судлах	[CLO 2.1., 2.2., 2.3, 2.4, 3.1, 3.2]
Даралтат болон энгийн хөгжмийн зэмсгээр тоглох ур чадварыг дэмжих, хөгжүүлэх	[CLO 2.1., 2.2., 2.3, 2.4,3.3]

Хүснэгт 2. Хичээлийн төлөвлөгөө

Нийт цаг: 64 цаг

7 хоног	Сэдэв	Семинар	Практик
1-7	Хөгжмийн онолын мэдэгдэхүүнийг олгох арга зүйд суралцах	14	14
8-13	Бага ангийн сурагчдад хөгжим сонсгох үйл ажиллагаа, хөгжимт хөдөлгөөн, дуу заах	12	12
14-16	Даралтат болон энгийн хөгжмийн зэмсгээр тоглох ур чадварыг дэмжих, хөгжүүлэх	6	6
Нийт цаг		32	32

Үнэлгээ:

№	Үнэлгээний хэлбэр	Эзлэх хувь	Багтаамж
1	Ирц, оролцоо	10%	Семинар болон практикийн хичээлд суусан ирцийг бүртгэж, ирцийг 5%-аар тооцно. Семинарын сэдэвтэй холбоотой гүйцэтгэх дасгал даалгаврыг хийсэн байдал болон тэмдэглэл хөтөлсөн байдлыг 5%-аар тооцно .
2	Бие даалтууд	30%	Бие даалтыг 2 удаа гүйцэтгэнэ: - Хөгжийн онолын дасгал, бичиж боловсруулах даалгаврууд -15% - Ноот хараад хөгжмөөр тоглох чадвар-15%
3	Явцын үнэлгээ	45%	1. 1-6-р семинарын агуулгаар 4 хүүхдийн дуу тоглоно -15% 2. 7-13-р семинарын агуулгаар 1-5-р ангийн хөгжмийн ээлжит хичээлийн төлөвлөлтөд анализ хийнэ. Тус бүр 3 оноо - 15% 3. 14-16 семинар, 10 практикийн агуулгаар даралтат болон энгийн хөгжмийн зэмсгээр (аль нэгээр) Жижиг хэлбэрийн аялгууг ноотоор тоглоно -15%
4	Эцсийн үнэлгээ	15%	Хүүхдийн дууны 3 бүтээлийг хөгжмийн илэрхийллийн бүрэн гүйцэтгэлтэйгээр тоглох уран чадварыг үнэлэн дүгнэнэ - 15%

БИЕИЙН ТАМИР, АРГА ЗҮЙ (Т.РТ405) ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА

Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага (CLO):

1. Мэдлэг

- 1.1.Биеийн тамирын шинжлэх ухааны үндсэн ухагдахуунуудын утга учир, мөн чанарыг ухаарч ойлгон, тайлбарлах [PLO1.3.2, 3.2.6]
- 1.2.Биеийн тамир, спортын үр нөлөө, нийгмийн амьдралд гүйцэтгэх үүргийг тодорхойлох, дүгнэх, спортын төрлүүдийг ангилах, жишээ баримтаар батлах [PLO1.3.2,3.1.1]
- 1.3.Монголын биеийн тамир, спортын хөгжлийг тоймлох, дүн шинжилгээ хийх, тайлбарлах, [PLO 3.2.6]

2. Чадвар

- 2.1.Сургуулийн бага насны хүүхдийн бие бялдрын өсөлт, хөгжлийг хэмжих, үнэлэх, биеийн галбирыг ажиглах, тэмдэглэл хөтлөх, тодорхойлох [PLO 1.2.1, 3.2.6]
- 2.2.Сургуулийн бага насны хүүхдийн бие бялдрын өсөлт, хөгжлийн үзүүлэлтийг харьцуулах, онцлог, ялгааг тодорхойлох, мэдээлэл харилцааны технологи ашиглан, илтгэл бэлтгэх [PLO2.1.3, 2.2.3, 3.3.2, 3.2.6]
- 2.3.Сургуулийн бага насны хүүхдийн бие бялдрын өсөлт, хөгжилт болон хүүхдийн биеийн галбир алдагдах шалтгааныг илрүүлэх, хэлэлцэх [PLO 1.3.2, 2.5.4,3.2.6, 3.4.2]
- 2.4.Сургуулийн бага насны хүүхдийн бие махбодыг чийрэгжүүлэхэд нар , ус, агаар зэрэг байгалийн хүчин зүйлсийг зохистой ашиглах, бусдад зөвлөгөө өгөх, зөвлөмж боловсруулах [PLO 2.1.3, 2.4.1, 2.5.4]

3. Хандлага

- 3.1.Биеийн тамираар хичээллэх үед мөрдөх эрүүл ахуйн шаардлагыг ойлгох, баримтлах, хувийн ба нийгмийн эрүүл ахуйн хэм хэмжээг мөрдөх, тайлбарлах, бусдад зөвлөгөө өгөх [PLO1.3.2, 3.2.6, 3.4.2,]

Үнэлгээний жин, хэлбэр:

Ирц, оролцоо: 20%

Бие даалтууд: 50%

Явцын сорил: 30%

Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр, код:	БИЕИЙН ТАМИР, АРГА ЗҮЙ, Т.РТ405
Улирал:	3 дамжааны хаврын улирал
Хичээлийн задаргаа:	0:2:0:2(3). (семинар, практик)
Заах багш:	Д.Пүрэвдорж
Е-мэйл хаяг:	puujee@msue.edu.mn
Утас:	(976)-70112429
Ажлын өрөө:	5 – 311
Ажиллах цаг:	Даваа-Баасан, 8:40 am - 18:00 pm.

Үндсэн сурах бичиг:

1. Алтанцэцэг, Л. (2009). Бие бялдрын хүмүүжлийн онол, арга зүй. Улаанбаатар.
2. Уртнасан, Л. (2015). Биеийн тамирын сургалтын арга зүй. Улаанбаатар: МУБИС-ийн хэвлэх цех.

Нэмж унших материалууд:

1. Б, Гунгаа. (2001). Бие бялдрын чанарыг хөгжүүлэх онол, арга зүйн үндэс. Улаанбаатар.
2. Баярлах, Д. (2009). Биеийн ерөнхий хөгжлийн дасгалууд. Улаанбаатар.
3. Га, Цэрэндорж. (1985). Биеийн тамир спортын байгууллагын бүтэц, зохион байгуулалт. Улаанбаатар.
4. Уртнасан, Л. (2010, 2011). Бие бялдрын хүмүүжлийн онолын үндсүүд. Хөтөлбөрийн хөтөч 1,2. Улаанбаатар.
5. Лхагвасүрэн, Г. (1995). Бие бялдрын хүмүүжлийн онол, заах арга. Улаанбаатар.
6. Стаббс, Р. (2014). Спорт ном. Улаанбаатар
7. Тунгалаг. Ж., (2009). Идэвхтэй хөдөлгөөн идэвхтэй амьдрал. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК.
8. Уранчимэг. С., (2015). Биеийн тамир. Улаанбаатар

Хичээлийн залгамж, холбоо: Бие бялдар-хөдөлгөөний ур чадвар, Т.РТ406

Хичээлийн товч тодорхойлолт: Сургуулийн бага ангийн хүүхдийн сэтгэл хөдлөл, нийгэмшихүй, танин мэдэхүйн онцлогт тохируулан, тэдний бие бялдрыг хөгжүүлэхэд биеийн тамирын төрөл бүрийн дасгалыг ашиглах, байгалийн болон эрүүл ахуйн хүчин зүйлсээр хүүхдийг чийрэгжүүлэх арга зүйн үндсэн мэдлэг, чадвар эзэмшинэ.

Хичээлийн зорилго: Сургуулийн бага ангийн хүүхдийн сэтгэл хөдлөл, нийгэмшихүй, танин мэдэхүйн онцлогт тохируулан, тэдний бие бялдрыг хөгжүүлэхэд биеийн тамирын төрөл бүрийн дасгалыг ашиглах, байгалийн болон эрүүл ахуйн хүчин зүйлсээр хүүхдийг чийрэгжүүлэх арга зүйн үндсэн мэдлэг, чадвар эзэмшинэ.

Агуулга: Биеийн тамирын онолын хичээлээр биеийн тамирын онол, арга зүйн шинжлэх ухааны үндсэн ойлголт, мэдлэг, Монгол улсын биеийн тамир, спортын хөгжлийн өнөөгийн байдалтай уялдуулан, сургуулийн бага насны хүүхдийн бие бялдрын хөгжлийг дэмжих, тасралтгүй хөгжүүлэх, чийрэгжүүлэх арга, хэрэглүүр, тэдгээрийн үр нөлөөг судална.

Хичээлийн сургалтын арга зүй: Оюутны суралцах үйл ажиллагааг интерактив арга буюу оюутан бүрийн оролцоо, бүтээлч үйл ажиллагаанд суурилж, биеэр мэдрэх, өөрөө гардан хийх, эрэл хайгуул, судалгаа хийх, үр дүнг боловсруулах, өөр нөхцөлд хэрэглэх, илтгэх, тайлагнах гэсэн үе шаттайгаар зохион байгуулна.

Хүснэгт 1. Үр дүнгийн хамаарал

Хичээлийн төлөвлөлт	Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадварууд
Биеийн тамирын үндсэн ухагдахуун ба биеийн тамир, спортын хөгжил	CLO [1,1 1,2 1,3]
Хүүхдийн бие бялдрын хөгжил	CLO [2,1 2,2 2,3]
Хүүхдийн бие бялдрын хөгжлийг дэмжих арга зүй	CLO [3,1 3,2 3,3]

Хүснэгт 2. Хичээлийн төлөвлөгөө

Нийт цаг: 64 цаг

7 хоног	Сэдэв	Семинар	Практик
1-6	Биеийн тамирын үндсэн ухагдахуун ба биеийн тамир спортын хөгжил	12	8
7-12	Хүүхдийн бие бялдрын хөгжил	8	12
13-16	Хүүхдийн бие бялдрын хөгжлийг дэмжих арга зүй	12	12
Нийт цаг		32	32

Үнэлгээ:

№	Үнэлгээний хэлбэр	Эзлэх хувь	Багтаамж
1	Ирц, оролцоо	20%	Семинарын ирц оролцоог харгалзана.
2	Бие даалт	50%	2 бие даалтын ажил хийнэ.
4	Явцын сорил	30%	- Семинарын хичээлийн дасгал, даалгаварын гүйцэтгэлээр үнэлнэ. - Зарим сэдвээр тестийн гүйцэтгэлийн хувиар үнэлнэ. - Семинарын хичээл бүр дээр өмнөх мэдлэгээ ашиглах чадварыг үнэлнэ.

СУРГУУЛИЙН БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН СЭТГЭЛ СУДЛАЛ (Т.РЕ201)

ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА

Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага (CLO):

1. Мэдлэг

- 1.1. Сургуулийн бага насны хүүхдийн сургуульд дасан зохицох чадварын бүрдлийг нэрлэх, суралцагчдын ялгаатай байдлыг таньж тодорхойлох [PLO 1.1.6, 2.1.1, 3.1.1, 3.1.2]
- 1.2. Сургуулийн бага насны хүүхдийн сэтгэл зүйн хөгжлийн зүй тогтлыг онолын үүднээс тайлбарлах [PLO 2.1.2; 3.1.1]

2. Чадвар

- 2.1. Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох чадварыг судлах арга зүйг төлөвлөх [PLO 2.5.2]
- 2.2. Сургуулийн бага насны хүүхдийн сэтгэцийн танин мэдэхүйн хөгжилд дүгнэлт хийх [PLO 2.3.5]
- 2.3. Сургуулийн бага насны хүүхдийн үе тэнгийнхэн, насанд хүрэгсдэд хандах хандлага, харилцах чадварыг үнэлэх [PLO 2.2.4, 2.3.5, 3.3.1]
- 2.4. Сургуулийн бага насны хүүхдийн зан үйлийн соёлын төлөвшлийн шалгуур боловсруулах [PLO 1.1.3]

3. Хандлага

- 3.1. Сургуулийн бага насны хүүхдийн сэтгэцийн хөгжил нь нөлөөллийн цогц тогтолцоонд хөгждөг гэдгийг чухалчилж, шинжлэх ухааны үндэслэлтэй хандах [PLO 2.1.3, 3.3.1]
- 3.2. Сургуулийн бага насны хүүхдийн хөгжлийн онцлогийг оношилж судлах, судлаачийн ёс зүйг мөрдөх, биелүүлэх [PLO 2.5.2, 2.2.6, 3.3.1]

Үнэлгээний жин, хэлбэр:

Ирц, оролцоо: 10%

Бие даалтууд: 50%

Явцын сорил I, II: 20%

Эцсийн шалгалт : 20%

Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр, код:	Сургуулийн бага насны хүүхдийн хөгжлийн сэтгэл судлал, Т.РЕ201
Улирал:	III дамжааны хаврын улирал
Хичээлийн задаргаа:	1:4:0:0 (5) (лекц, семинар)
Заах багш:	Б.Мягмаржав, Г.Бямбатогтох, Г.Энхжаргал, Ч.Нямсүрэн, Т.Энхмаа
И-мэйл хаяг:	yarus2020@yahoo.com , byambatogtokh@msue.edu.mn , eegji2015@gmail.com , nyamsurenchuluundorj@gmail.com
Утас:	(976)-70112429
Ажлын өрөө:	5-208
Ажиллах цаг:	Даваа–Баасан, 9:00 am – 18:00 pm.

Үндсэн сурах бичиг:

1. Үндсэн сурах бичиг боловсруулагдаж байгаа.
2. Child Development and Education. Teresa M.McDevitt, Jeanne Ellis

Нэмэлт унших материалууд:

1. Цэвээнлхазал Я., (2013). Хүүхдийн хөгжлийн сэтгэл судлал I,II, Улаанбаатар.
2. Оюунцэцэг Б., Бямбатогтох Г. (2009). Хүүхдийн хөгжлийн сэтгэл судлалын зарим асуудал. Улаанбаатар.
3. Санжжав Д., (2013). Хүүхдийн нас зүй, сурган хүмүүжүүлэх сэтгэл судлал. Улаанбаатар.
4. Оюунцэцэг Б., Энхмаа Т. (2016) Сургуулийн бага насны хүүхдийг судлах арга зүй. Улаанбаатар
5. Оюунцэцэг Б., Бямбатогтох Г., Энхмаа Б. (2017). Бага ангийн сурагчдын суралцах чадварын сэтгэл зүйн үндэс. Улаанбаатар.
6. Мягмар О. (2009). Судлаач багшийн гарын авлага, Улаанбаатар.
7. Грейс Крайг. (2000). Психология развития, Мастера психология, 7-ое международное издание. Питер.
8. Давыдов В. В. (1989). Психология младшего школьника. Москва

Хичээлийн залгамж холбоо: Сэтгэл заслын арга, зөвлөгөө, Т.РЕ408

Хичээлийн товч тодорхойлолт: СБНХ-ийн сэтгэцийн хөгжлийн зүй тогтол, нөхцөл, хөдөлгөгч хүчний талаар ерөнхий ойлголттой болж, СБНХ-ийн сургуульд дасан зохицох чадвар, танин мэдэхүй, бие хүний хөгжлийн онцлогтой танилцана.

Хичээлийн зорилго: Оюутнуудад сургуулийн бага насны хүүхдийн танин мэдэхүй, нийгэмшихүйн, сургуульд дасан зохицох чадварын талаарх мэдлэгийн үндсэн дээр сурагчдыг дэмжих нийгэм-сэтгэл зүйн чадвар төлөвшүүлэхэд оршино.

Агуулга: Сургуулийн өмнөх ба сургуулийн бага насны хүүхдийн хөгжлийн залгамж холбоо, бага ангийн сурагчдын сургуульд дасан зохицох чадвар; 6-11 насны хүүхдийн сэтгэцийн танин мэдэхүй-нийгэмшихүйн хөгжил, түүнд тулгамддаг асуудлын хүрээг судална.

Хичээлийн сургалтын арга зүй: Асуудал дэвшүүлсэн лекц, хэлэлцүүлэгт- семинар; асуудал шийдвэрлэх дүрийн тоглолт, ЕБС-д ажиглалт хийсэн үр дүнгийн тайлант хэлэлцүүлэг, кэйс хэлэлцүүлэг, оюуны зураглал гаргах, хүүхэд судалж тайлан бичих аргад тулгуурлан багийн болон ганцаарчилсан хэлбэрээр явагдана.

Хүснэгт 1. Үр дүнгийн хамаарал

Хичээлийн төлөвлөлт	Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадварууд
I. Сургуулийн бага насны хүүхдийн хөгжлийг	CLO 1.1, 2.1, 2.2, 3.1, 3.3

судлах арга зүйн үндэс	
II. Сургуулийн бага насны хүүхдийн сургуульд дасан зохицох үйл явц	CLO 1.2, 2.3, 3.1, 3.2, 3.3
III. Сургуулийн бага насны хүүхдийн сэтгэл зүй	CLO 1.3, 2.3, 2.4, 2.5, 2.6, 3.1, 3.2, 3.3

Хүснэгт 2. Хичээлийн төлөвлөгөө

Нийт цаг: 80 цаг

7 хоног	Сэдэв	Лекц	Семинар
1-2	СБНХСС-ын үндэс, судалгааны арга зүй	2	10
3-4	Сургуулийн бага насны хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын сэтгэл зүйн үндэс	2	6
5-6	Сургуульд дасан зохицох үйл явц	2	6
7-8	Сургуулийн орчинд дасан зохицоход бие бялдрын нөлөөлөл /хөдөлгөөний хэрэгцээ/	2	4
9-10	СБНХ-ийн сэтгэцийн хөгжлийн зүй тогтол /Танин мэдэхүйн хөгжил/	2	14
11-12	Сургуулийн бага насны хүүхдийн нийгэмшихүйн болон зан төлөвийн хөгжил	2	8
13-14	Сургуулийн бага насны хүүхдийн харилцаа, хандлага	2	8
15-16	Сургуулийн бага насны хүүхдийн сэтгэлийн хөдлөл, зоригийн хөгжил	2	8
Нийт цаг		16	64

Үнэлгээ:

№	Үнэлгээний хэлбэр	Эзлэх хувь	Багтаамж
1	Ирц, оролцоо	10%	Нийт 16 цагийн лекц, 64 цагийн семинарын хичээлд суусан ирцийн мэдээллийг бүртгэж, 10%-иар тооцно.
2	Бие даалт	50%	Нийт 3 удаагийн бие даалтын ажил гүйцэтгэнэ: - Сургуулийн бага насны хүүхдийг үйлийн явцад судлах төлөвлөгөө гаргах 15% - Боловсруулсан төлөвлөгөөний дагуу үйлийн судалгаа хийх 25% - Кэйс боловсруулах /дараах чиглэлээс сонгож бие даалт хийж гүйцэтгэх 10%
3	Явцын сорил	20%	- I-IV лекцийн агуулгаар явцын эхний сорил I (мэдлэг, чадвар, хандлагыг шалгах сорил, тест, дасгал, даалгавар) 10% - V-VIII лекцийн агуулгаар II сорил (мэдлэг, чадвар, хандлагыг шалгах сорил, тест, дасгал, даалгавар) мөн 10% байхаар тооцно
4	Эцсийн үнэлгээ	20	I-VIII лекц, 64 цагийн семинар, бие даан гүйцэтгэх даалгаврын агуулгаар Блүмийн таксономын 6 түвшнөөр сорил боловсруулж үнэлнэ. Эцсийн сорилын эзлэх хувь 20% байна.

БАГА БОЛОВСРОЛЫН НЭГДМЭЛ АРГА ЗҮЙ (Т.РЕ202) ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА

Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага (CLO):

1. Мэдлэг

- 1.1. Бага боловсролын нэгдмэл арга зүйн онцлог, мөн чанарыг судалж мэдэх [PLO 3.1.3]
- 1.2. Нэгдмэл арга зүйн нэгэн хувилбар болох STEAM арга зүйгээр мэдлэг бүтээх үйл ажилагааг онцлогийг тодорхойлох танин мэдэхүйн зүй тогтолд тулгуурлан оновчтой төлөвлөх, зохион байгуулах, [PLO 2.2.5, 3.1.1]

2. Чадвар

- 2.1. Бага боловсролын нэгдмэл хичээлийг төлөвлөх, хөтөлбөр боловсруулах [PLO 2.1.3]
- 2.2. Бага боловсролын нэгдмэл арга зүйгээр сурах арга барилыг дэмжих [PLO 3.1.3]
- 2.3. Бага боловсролын нэгдмэл арга зүйг хэрэгжүүлэх хэрэглэгдэхүүнийг оновчтой сонгох, бэлдэх [PLO 3.1.1]

3. Хандлага

- 3.1. Бага боловсролын нэгдмэл хичээл дээр суралцагч өөрийн үйл ажиллагааг удирдан, зохицуулахад чиглүүлэн дэмжих, дээд эрэмбийн сэтгэн бодох чадварын хөгжлийг эрхэмлэх [PLO 1.1.4, 1.1.6]

Үнэлгээний жин, хэлбэр:

Ирц, оролцоо: 20%

Бие даалтууд: 50%

Явцын сорил: 30%

Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр, код: ББ-ын нэгдмэл арга зүй Т.РЕ202
Улирал: 4 дамжааны хаврын улирал
Хичээлийн задаргаа: 1:4:0:0(5) (лекц, семинар)
Заах багш: Д.Амартүвшин, С.Батхуяг, Д.Хишигжаргал
Е-мэйл хаяг: amartuvshind@msue.edu.mn, batkhuyag@msue.edu.mn,
khishigjargald@msue.edu.mn
Утас: (976)-70112429
Ажлын өрөө: 5 – 308, 306, 312
Ажиллах цаг: Даваа-Баасан, 8:00 am - 18:00 pm.
Үндсэн сурах бичиг:

1. Б.Алтанзагас, Д.Амартүвшин, С.Батхуяг(2023). *Бага боловсролын нэгдмэл арга зүй (3 дахь хэвлэл)*. Уб. Адмон.

Нэмэлт унших материалууд:

1. Paul Eggen,P & Kauchak Don, (2010). Educational psychology. New York : Pearson.
2. МУБИС-ийн БС бичил төсөл., (2016). Нэгдмэл агуулга, түүний арга зүй. Уб.
3. Felder & Rebecca., (2016). Teaching and Learning STEM: A Practical Guide. USA: Jossey-Bass.
4. МУБИС. (2017). STEAM нэгдмэл арга зүй төслийн гарын авлага. Хэвлэх цех.

Хичээлийн залгамж холбоо:

Хичээлийн товч тодорхойлолт: Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл баримтлалын хүрээнд STEAM арга зүй, кодчлолын эхний алхамд суралцах боломжийг олгож, бодит хэрэглэгдэхүүний багцуудыг ашиглаж, өөрсдөө STEAM үйл ажиллагаанд оролцсоноор 1-5-р ангид STEAM арга зүйгээр хичээл зохион байгуулж, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх итгэл үнэмшилтэй, бүтээлч хандлагатай багш нар бэлтгэгдэх юм.

Хичээлийн зорилго: Бага боловсролын нэгдмэл арга зүй(STEAM)-г судлан түүгээр хичээл төлөвлөх, зохион байгуулах чадварт суралцах, асуудалд цогц хандах, өөрийгөө хянах, зохицуулах, бүтээлчээр сэтгэх хандлагатай болоход оршино.

Агуулга: Бага боловсролын нэгдмэл арга зүй(STEAM), түүний онцлог, хэрэглэгдэхүүнийг төлөвлөх, зохион байгуулах, заах арга зүйн онолыг судалж, НАЗ-гээр хичээлийг зохион байгуулах, сурагчдыг хөгжүүлэх чадварт суралцаж, мэдлэгийг амьдралд хэрэглэх, өөрийгөө хянан зохицуулах хандлагатай болоход оршино.

Хичээлийн сургалтын арга зүй: Бага боловсролын хичээлийг нэгдмэл арга зүй(STEAM) заахдаа танин мэдэхүйн зүй тогтолд нийцүүлэн төлөвлөх, зохион байгуулах, үнэлэх, суралцагчдын хөгжлийг дэмжихэд суралцахыг оюутны бүтээлч, бие даасан үйл ажиллагаа, дээд эрэмбийн сэтгэн бодох чадвар шаардсан, шинжлэх ухаанч арга барил, асуудал болон төсөлд суурилсан, нэгдмэл, насанд хүрэгчдэд зориулсан арга зүй зэргийг хэрэгжүүлнэ.

Хүснэгт 1. Үр дүнгийн хамаарал

Хичээлийн төлөвлөлт	Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадварууд
Бүлэг сэдэв 1. Бага боловсролын нэгдмэл арга зүйн сургалтын онолын үндэс	CLO 1.1, 1.2, 2.1, 2.2, 3.1,
Бүлэг сэдэв 2. Бага боловсролын нэгдмэл арга зүйгээр сургалтыг зохион байгуулах	CLO 2.1, 2.2, 2.3, 3.1,

Хүснэгт 2. Хичээлийн төлөвлөгөө

Нийт цаг: 80 цаг

7 хоног	Сэдэв	Лекц	Семинар
1-2	Боловсролын сэтгэл судлалын асуудлууд ба нэгдмэл арга зүй, түүний уламжлал, шинэчлэл	2	8
3-4	Нэгдмэл арга зүйн (STEAM)сургалтын онолын үндэслэл	2	8
5-6	STEAM боловсрол ба ТХБ	2	8
7-8	Нэгдмэл арга зүйн төлөвлөлт: Шинжлэх ухаанч эрэл хайлт	2	8
9-10	Нэгдмэл арга зүйгээр зохион байгуулах хичээлийн хөтөлбөр ба зааварчилгаа, түүнийг боловсруулах нь	2	8
11-12	НАЗ-гээр зохион байгуулах хичээл дээр анхаарах зүйл	2	8
13-14	Хүүхэд бүрийн хөгжлийг нэгдмэл арга зүйгээр дэмжих, асуудал шийдвэрлэхүйд суралцахыг дэмжих нь	2	8
15-16	Кодын цагаан толгой	2	8
Нийт цаг		16	64

Үнэлгээ:

№	Үнэлгээний хэлбэр	Эзлэх хувь	Багтаамж
1	Ирц, оролцоо	20%	Лекц ба семинарын ирцийг 10%, семинарын хичээл дэх оюутны оролцоог 10% байхаар үнэлнэ.
2	Бие даалтууд	50%	Бие даалтыг 2 удаа гүйцэтгэнэ: - Ажлын хуудас боловсруулах- 25% - Ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулж турших- 25%
3	Явцын сорил I, II	30%	- Заавар ашиглах чадвар I сорил (15%) - Нэгдмэл арга зүй сэдэвт сорил (15%)

ТУРШИН ЗААХ ДАДЛАГА (Т.ТР275) ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА

Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

Дадлагаар эзэмших мэдлэг, чадвар, хандлага (CLO):

1. Мэдлэг

- 1.1.Тухайн хичээлээр хүүхэд бүрийг хөгжүүлэх арга зүйг мэдэх, онцлогийг тодорхойлох [PLO 1.1.6; 3.1.2; 3.2.1; 3.2.2; 3.2.3; 3.2.4; 3.2.5]
- 1.2.Хүүхэд бүрийн сурч, танин мэдэх онцлогийг ажиглах, ялгах, илрүүлэх арга, зарчмыг ойлгох [PLO 1.1.1; 1.1.3; 1.3.2; 3.1.1; 3.1.3; 3.3.1]
- 1.3.Хүүхдийн суралцах, хөгжих үйл ажиллагааны төрөл, хэлбэрийг мэдэх, жагсаах, зориулалтыг нь тодорхойлох [PLO 3.1.3; 3.2.6]
- 1.4.Хичээлийн үе шат, бүтцийг тодорхойлох, хичээлд бэлтгэх, төлөвлөх үйл ажиллагааны дэс дарааллыг ялгах [PLO 1.1.6; 2.4.3]
- 1.5.Тухайн хичээлд хэрэглэж болох хэрэглэгдэхүүнийг тодруулах, шаардлагын дагуу боловсруулах, сайжруулах хэрэгцээг ойлгох [PLO 1.1.4; 2.4.6]

2. Чадвар

- 2.1.Тухайн хичээлээр хүүхэд бүрийг хөгжүүлэх арга зүйг төлөвлөх, боловсруулах, турших, сайжруулах [PLO 2.3.2; 2.3.3; 2.5.1; 2.5.2; 2.5.4; 3.2.1; 3.2.2; 3.2.3; 3.2.4; 3.2.5]
- 2.2.Хүүхдийн амжилт, ахиц дэвшлийг дэмжих, үнэлэх [PLO 1.1.2; 1.1.3; 1.1.5; 2.1.1; 2.4.7]
- 2.3.Хүүхдийн суралцах, хөгжих үйл ажиллагааг чиглүүлэх, зөвлөх [PLO 2.1.3; 3.1.1; 3.1.3; 3.3.1]
- 2.4.Хичээл төлөвлөх, тодорхой зорилго бүхий ажиглалт хийх, хэлэлцэх, хөтөлбөр, хэрэглэгдэхүүнийг сайжруулах [PLO 1.1.4; 2.1.2; 2.3.4; 2.4.3; 2.4.4; 2.4.5; 2.4.6; 2.5.2; 2.5.3; 3.1.2]

3. Хандлага

- 3.1. Багшлах ажилдаа чин сэтгэлээсээ ажил хэрэгч, хариуцлагатай, тууштай хандах итгэл үнэмшилтэй болох [PLO 2.2.1]
- 3.2. Багш бүр өөрийн онцлогт нийцсэн багшлах арга зүйтэй байх, тасралтгүй хөгжи хэрэгцээ шаардлагыг ойлгох [PLO 2.2.6; 3.5.1; 3.2.1; 3.2.2; 3.2.3; 3.2.4; 3.2.5]
- 3.3. Сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагаа бүрийг хүүхэд хөгжүүлэх зорилготой уялдуулахыг эрмэлзэх [PLO 2.2.3; 2.2.6]
- 3.4. Бие даан өөрийгөө хөгжүүлэх бүтээлч санаачилгатай байх, өөрийн өвөрмөц онцлог бүхий арга барилтай болохыг эрмэлзэх [PLO 1.1.1]
- 3.5. Төлөвлөсөн шинэлэг арга барилаа зоригтой турших [PLO 2.2.5]
- 3.6. Багшлах үр чадварт анализ хийж эргэцүүлэх [PLO 2.4.8]

Үнэлгээний жин, хэлбэр:

Ирц, оролцоо: 40%

Дадлагын дэвтэр хөтлөлт: 10%

Өөрийн үнэлгээ: 15%

Бүтээлийн сан: 25%

Тайлан үзэсгэлэн: 10%

Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр, код:	Туршин заах дадлага, Т.ТР275
Улирал:	III дамжааны хаврын улирал
Хичээлийн задаргаа:	0:0:0:10(8), (практик)
Заах багш:	Бүх дидактикийн багш нар
Е-мэйл хаяг:	
Утас:	(976)-70112429
Ажлын өрөө:	
Ажиллах цаг:	Даваа-Баасан, 8:40 am - 18:00 pm.

Үндсэн сурах бичиг:

1. МУБИС. (2016). Багш мэргэжлийн дадлагын дэвтэр I, II. Улаанбаатар.
2. МУБИС. (2019). Багшлах мэргэжлийн дадлагын дэвтэр I, II (Шинэчилэн засварласан II дахь хэвлэл ed.). Улаанбаатар.

Нэмэлт унших материалууд:

1. Мэргэжлийн дидактикийн бүх сурах бичгүүд

Хичээлийн залгамж, холбоо: Багшлах дадлага, Т.ТР285

Хичээлийн товч тодорхойлолт: Оюутан-багш нь тухайн мэргэжлийн хичээлийг хамтран төлөвлөх, зохион байгуулах, хичээлийн ажиглалт, тэмдэглэл хөтлөх, хэлэлцэх, багшийн арга зүйгээс суралцах, сайжруулах практик сургалт байна.

Хичээлийн зорилго: Оюутан-багш, сургууль, багшийн үйл ажиллагаатай танилцан, багшийн чиглүүлгээр хичээлээ төлөвлөх, зааж турших, үнэлж эргэцүүлэхэд суралцаж, дараагийн шатны дадлага хийхэд шаардлагатай чадвар эзэмшинэ.

Агуулга: Мэргэжлийн хичээлийн онол, арга зүйтэй уялдуулж, сургалтын хөтөлбөр боловсруулан, хичээл зохион байгуулж, хэлэлцэн сайжруулж, багшлах ур чадварт суралцана.

Хичээлийн сургалтын арга зүй: Практик сургалт

Хүснэгт 1. Үр дүнгийн хамаарал

Үйл ажиллагааны төлөвлөлт	Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадварууд
Хичээлийн хөтөлбөр боловсруулах, зохион байгуулах, дүн шинжилгээ хийх, сайжруулах	CLO [1.1, 1.4, 1.5, 2.1, 2.2, 2.4, 3.1, 3.3, 3.4]
Мэргэжлийн хичээлийн онол, арга зүйг уялдуулж, багшлах арга зүйгээ дээшлүүлэх	CLO [1.1, 1.2, 2.1, 2.4, 3.1, 3.2, 3.4]
Мэргэжлийн хичээлд ашиглах аргын сан бүрдүүлэх	CLO [1.4, 2.1, 2.4, 3.2, 3.4]
Судалгаат хичээлийн ажиглах, хэлэлцүүлэгт оролцож, хичээлийн судалгаанд суралцах	CLO [1.4, 2.4, 3.2, 3.6]
Тухайн шинжлэх ухааны болон боловсрол судлал, багшлах арга зүйн нэр томъёоны тайлбар толь хөтлөх	CLO [1.5, 3.4]
Суралцагчийн оношилгоо хийх, явцын болон эцсийн үнэлгээ хийх, эргэцүүлэх, дүгнэх	CLO [1.2, 1.3, 2.1, 2.2, 2.3, 3.3]
Ангийн ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх, зохион байгуулах, үр дүнг тооцох	CLO [1.3, 2.3, 3.3]
Тухайн хичээлээр дамжуулан суралцагчийн авьяас чадварыг хөгжүүлэх үйлийг төлөвлөх, хэрэгжүүлэх, дүгнэлт хийх	CLO [1.1, 1.2, 1.3, 2.1, 2.3, 3.3]
Сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагааг	CLO [1.3, 1.4, 2.1, 2.3, 3.3]

төлөвлөх, зохион байгуулах, үр дүнг тооцох	
Сургалтад МХТ ашиглах	CLO [1.5, 2.4, 3.4]

Хүснэгт 2. Хичээлийн төлөвлөгөө

Нийт цаг: 96 цаг

7 хоног	Үйл ажиллагаа	Практик
I	Мэргэжлийн хичээлийн онол, арга зүйг уялдуулж хичээлийг төлөвлөх, заах, дүгнэлт гаргах, сайжруулах	24
	Ангийн ажлын төлөвлөгөө боловсруулж, зохион байгуулах, үр дүнг тооцох	6
II	Мэргэжлийн хичээлд ашиглах аргыг туршиж, сан бүрдүүлэх	12
	Тухайн хичээлээр дамжуулан суралцагчийн авьяас чадварыг хөгжүүлэх үйлийг төлөвлөх, хэрэгжүүлэх, дүгнэлт хийх	6
	Судалгаат хичээлийг ажиглах, хэлэлцүүлэгт оролцож, судалгаанд суралцах	6
III	Суралцагчийн оношилгоо хийх, явцын болон эцсийн үнэлгээ хийх, эргэцүүлэх, дүгнэх	18
	Тухайн шинжлэх ухааны болон боловсрол судлал, багшлах арга зүйн нэр томъёоны тайлбар толь хөтлөх	6
IV	Сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, үр дүнг тооцох	6
	МХТ ашиглан цахим хэрэглэгдэхүүн боловсруулж, турших, сайжруулах	6
	Тайлан бичих, өөрийн үнэлгээ хийх	6
Нийт цаг		96

Үнэлгээ:

№	Үнэлгээ	Хувь	Хэн үнэлэх
1	Ирц, оролцоо	25%	ЕБС-ийн багш
		15%	МУБИС-ийн багш
2	Дадлагын дэвтэр хөтлөлт	10%	МУБИС-ийн багш
3	Өөрийн үнэлгээ	15%	Оюутан-багш
4	Бүтээлийн сан	25%	Тайлан хамгаалуулах комисс
5	Тайлан үзэсгэлэн	10%	Тайлан хамгаалуулах комисс
	Нийт	100%	

БАГШЛАХ ДАДЛАГА (Т.ТР285) ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА

Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага (CLO):

7. Мэдлэг

- 1.1. Тухайн мэргэжлийн багшийн сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах ажлын онцлог, мөн чанар, үе шатыг ойлгох [PLO 2.1.1, 2.4.5, 2.5.4, 3.1.2, 3.5.2]
- 1.2. Хүүхэд бүрийн нас сэтгэхүйн онцлог, танин мэдэх хэрэгцээнд суурилсан сургалтын арга, хэрэглэгдэхүүнийг төлөвлөхийн мөн чанарыг ойлгох, харьцуулах, тайлбарлах [PLO 2.1.1, 2.1.2, 2.3.4, 2.4.1, 3.1.2]
- 1.3. Анги хамт олны онцлог, анги удирдсан багшийн үүргийг ойлгох, сургалтыг дэмжих үйл ажиллагааг бүтээлчээр төлөвлөхийн учир холбогдлыг мэдэх [PLO 1.1.2, 1.1.6, 2.1.3, 2.2.6]
- 1.4. Хичээлийн судалгааны үе шат, мөн чанарыг ойлгох [PLO 1.1.5, 1.1.6, 2.3.6]
- 1.5. Хүүхэд судлах, оношлох судалгааны аргуудыг жагсаах, харьцуулах, эцэг, эхтэй харилцах, хамтран ажиллах үйл ажиллагааны онцлогийг таних [PLO 1.1.5, 1.1.6, 2.2.4, 2.4.1, 3.5.2]
- 1.6. Үнэлгээ, түүний арга хэлбэрийг мэдэх, харьцуулах, тодорхойлох [PLO 1.1.6, 2.3.4, 2.4.3, 2.4.7]

2. Чадвар

- 2.2. Сургалтын үйл ажиллагааг бие даан төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх, үнэлгээ дүгнэлт өгөх [PLO 2.1.2, 2.5.3, 2.5.4, 3.5.1]
- 2.3. Тухайн мэргэжлийн хичээлээр хүүхэд бүрийг хөгжүүлэх арга зүйг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэлт дүгнэлт өгөх [PLO 2.1.2, 2.5.3, 2.5.4, 3.1.2, 3.5.1]
- 2.4. Сургалтыг дэмжих үйл ажиллагааг бие даан төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлгээ дүгнэлт өгөх [PLO 2.1.2, 2.5.3, 2.5.4, 3.5.1]
- 2.5. Судалгаат хичээлд хамтран бэлтгэх, ажиглалт хийх, хэлэлцэх, сайжруулах [PLO 1.1.5, 1.1.6, 2.3.6, 3.5.1]
- 2.6. Хүүхдийг оношлох, судлах, зөвлөгөө өгөх, эцэг эхтэй харилцах, хамтран ажиллах [PLO 1.1.5, 1.1.6, 2.2.4, 2.4.1, 3.5.2]
- 2.7. Үнэлгээний даалгавар боловсруулах, үр дүнд анализ хийх [PLO 1.1.6, 2.3.4, 2.4.3, 2.4.7, 3.5.2]

3. Хандлага

- 3.2. Багшлах ажилдаа чин сэтгэлээсээ ажил хэрэгч, хариуцлагатай, тууштай хандах итгэл үнэмшилтэй болох [PLO 2.2.1, 3.5.1]
- 3.3. Багшийн ёс зүйн хэм хэмжээг баримтлах [PLO 2.2.2, 3.5.1]
- 3.4. Хүүхдийн хэрэгцээ, сонирхол эрх ашгийг хүндэтгэх [PLO 2.1.1, 2.2.4, 2.2.6]
- 3.5. Өөрийн багшлах ур чадварт анализ хийж эргэцүүлэх [PLO 1.1.1, 1.1.6, 2.2.1, 3.5.1, 3.5.2]

Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр, код: Багшлах дадлага, Е.ТР280
Улирал: IY дамжааны намрын улирал
Хичээлийн задаргаа: 0:4:0:0(2). ЕБС-д суурилсан
Заах багш: МХНУТ, профессорын баг багш нар
Утас: (976)-70112429
Ажлын өрөө: 5 –207
Ажиллах цаг: Даваа-Баасан, 8:40 am - 18:00 pm.

Үндсэн хэрэглэгдэхүүн:

Багш мэргэжлийн дадлагын дэвтэр I, II МУБИС, 2016

Мэргэжлийн сургалтын арга зүй хичээлийн үндсэн сурах бичиг

Дадлагын зорилго:

Оюутан-багш бие дааж хичээл заах, анги удирдах, сурагчийг үнэлэх, тодорхой чиглэлээр судалгаа хийхэд суралцаж, сургалтын болон сургалтыг дэмжих үйл ажиллагааг төлөвлөх чадвар эзэмшинэ.

Хичээлийн залгамж, холбоо: байхгүй

Хичээлийн товч тодорхойлолт: Дадлага нь оюутны суралцах хугацаандаа мэргэжлийн, багш боловсрол болон мэргэжлийн арга зүйн хичээлүүдээр эзэмшсэн мэдлэг, чадвараа хэрэглэн бие даан багшлах, судалгаа хийх чадвар эзэмшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа

Хичээлийн зорилго Оюутан-багш бие дааж хичээл заах, анги удирдах, сурагчийг үнэлэх, тодорхой чиглэлээр судалгаа хийхэд суралцаж, сургалтын болон сургалтыг дэмжих үйл ажиллагааг төлөвлөх чадвар эзэмшинэ.

Агуулга: Оюутан багш бие даан сургалтын үйл ажиллагаа зохион байгуулах, хичээл заах арга зүйг төлөвлөх, тодорхой сэдвийн хүрээнд сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, хэрэгжүүлэх, багшлах арга зүйн чиглэлээр судалгаа хийнэ.

Хичээлийн сургалтын арга зүй: Багш мэргэжлийн дадлагыг оюутан-багш ЕБС-ийн өдөр тутмын практик үйл ажиллагааг ажиглах, асуудал шийдвэрлэх, үйлийн хамтын судалгааны болон хичээлийн судалгааны арга зүйгээр хэрэгжүүлнэ.

Хүснэгт 1. Үр дүнгийн хамаарал

№	Дадлагын үндсэн үйл ажиллагаа	Дадлагаар эзэмших мэдлэг, ур чадвар
1	Хичээлд ажиглалт хийж, анализ хийх	CLO [1.1, 1.2, 1.4, 2.4, 3.6]
2	Сэдэвчилсэн төлөвлөгөө болон ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх	CLO [1.1, 1.2, 1.4, 2.1, 2.2, 3.1, 3.4, 3.6]
3	Хичээлийн судалгааг хамтран боловсруулж, ажиглах, хэлэлцүүлэгт оролцох	CLO [1.1, 1.4, 2.4, 3.4, 3.5, 3.6]
4	Явцын болон эцсийн үнэлгээний даалгавар боловсруулах, шалгалт авах, боловсруулалт, анализ хийх	CLO [1.6, 2.1, 2.6, 3.2, 3.4, 3.6]
5	Тодорхой зорилгоор судалгааны ажил хийх	CLO [1.5, 2.5, 3.3]
6	Сургалтыг дэмжих үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах	CLO [1.3, 1.4, 2.3, 2.5, 3.3, 3.5]
7	Багшлах үйл ажиллагаандаа эргэцүүлэл, өөрийн үнэлгээ хийх	CLO [1.1, 2.1, 2.2, 3.1, 3.2, 3.4, 3.5, 3.6]

Хүснэгт 2. Хичээлийн төлөвлөгөө

7 хоног	Үйл ажиллагаа	Цаг
1	Хичээлд ажиглалт хийж, анализ хийх	24
2-4	Хичээлийн хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх	28
	Судалгаат хичээлд оролцох	12
	Явцын болон эцсийн үнэлгээний даалгавар боловсруулах, шалгалт авах, боловсруулалт, анализ хийх	16
	Судалгааны ажил гүйцэтгэх	18
	Сургалтыг дэмжих үйл ажиллагааг төлөвлөж, зохион байгуулах	16
5-6	Багшлах үйл ажиллагаандаа эргэцүүлэл хийх	8
	Тайлан бичих, өөрийн үнэлгээ хийх	6
Нийт цаг.		128

Үнэлгээ:

№	Үнэлгээ	Хувь	Хэн үнэлэх
1	Хичээлд суусан, оролцсон байдал	30%	Оролцоо гэдгийг дадлагын хугацаанд оюутан багшийн идэвх, санаачилга, хийсэн ажлын үр дүнг тооцсон явцын үнэлгээ байдлаар тооцно. - Дадлагын дэвтэр хөтлөлт - Бүтээлийн сан - Өөрийн үнэлгээ
2	Явцын үнэлгээ	10%	Дадлагын явцын үнэлгээ хийх
3	Бие даан гүйцэтгэх даалгаврын үнэлгээ	10%	Сургалтыг дэмжих үйл ажиллагаа төлөвлөх, зохион байгуулах
4	Эцсийн үнэлгээ - Тайлан хамгаалалт	50%	ЕБС-д тайлан тавих, дадлага хамгаалалт /25 оноо/ МУБИС дахь тайлан хамгаалалт /25 оноо/
	Нийт	100%	

ХҮҮХЭД БҮРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙ (Т.РЕ409) ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА

Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага (CLO):

1. Мэдлэг:

- 1.3. XXI зууны суралцахуйн чиг хандлага, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх онол арга зүй, үзэл баримтлалуудыг боловсролын зорилго, чиглэл бодлоготой уялдуулан тайлбарлах [PLO 2.3.3, 2.5.1, 3.3.1]
- 1.4. Суралцагчдын ялгаатай байдлуудыг харгалзан, тооцож хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, хичээлийг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжилтийг үнэлэх, сайжруулах аргуудыг тайлбарлах [PLO 1.1.3, 2.1.1, 3.1.2]

2. Чадвар:

- 2.1. Суралцагчдын ялгаатай байдлуудыг тодорхойлох аргуудыг ашиглан, суралцагч нэг бүрийг оношлох, дүн шинжилгээ хийх [PLO 2.1.1, 3.1.1, 3.1.2]
- 2.2. Суралцагчдын ялгаатай байдлуудыг харгалзсан сургалт явуулах арга зүй, хэрэглэгдэхүүн, үнэлгээг оновчтой сонгох, хэрэглэх [PLO 2.1.2, 2.1.3, 3.1.2]
- 2.3. Ялгаатай бүлгүүдэд зориулсан хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, сургалтын таатай орчныг бүрдүүлэх, анги, бүлгийн зохион байгуулалтуудыг оновчтой хийх, хэрэглэгдэхүүн бэлтгэх, хэрэглэх талаарх тайлбар, зөвлөмжийг бүтэц, шаардлагын дагуу боловсруулах [PLO 2.3.2, 2.3.3, 2.4.1, 2.4.6, 2.3.7, 3.4.1]
- 2.4. Хүүхэд нэг бүрийн хөгжилд тохируулан эцэг эхэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх арга хэмжээний удирдамж боловсруулах, дэмжих бүлгүүдийг татан оролцуулах арга хэлбэрүүдийг төлөвлөх [PLO 2.2.6, 3.4.3]

3. Хандлага:

- 3.1. Бага ангийн сурагчдын ялгаатай байдал онцлогийг тооцож, суралцахуй болоод багшлахуйд хэрэгжүүлэх боломж арга замыг эрэлхийлж, тэдгээрийг сайжруулах талаар санал дэвшүүлэх [PLO 2.4.2, 3.5.1]
- 3.2. Оюутнууд насан туршдаа өөрийн удирдлагатай, идэвх санаачилгатай, бүтээлчээр суралцах хүсэл эрмэлзэлтэй байх [PLO 3.5.1, 3.5.2]

Үнэлгээний жин, хэлбэр:

Ирц, оролцоо: 10%

Бие даалтууд: 50%

Явцын сорил I, II: 40%

Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр, код:	Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх арга зүй, Т.РЕ409
Улирал:	3, 4 дамжааны дурын улирал
Хичээлийн задаргаа:	0:4:0:0 (3) (семинар)
Заах багш:	Доктор (Ph.D) Ц.Тамир
Е-мэйл хаяг:	ts.tamir@msue.edu.mn
Утас:	(976)-70112429
Ажлын өрөө:	5-р байр 117 тоот
Ажиллах цаг:	Даваа-Баасан, 8:40 am - 18:00 pm.

Үндсэн сурах бичиг:

1. МУБИС, Нээлттэй нийгмийн хүрээлэн. (2019). “Суралцагч бүрийн өвөрмөц байдлыг харгалзсан анги танхимын менежмент” багийн ахлагч Б.Жадамба, Академич... Нар
2. МУБИС, Нээлттэй нийгмийн хүрээлэн. (2019). “Суралцагчдын өвөрмөц байдлыг харгалзан сургах арга зүй” багийн ахлагч Б.Жадамба, Академич... Нар
3. Ариунжаргал, Л ба нар. (2018). Суралцахуй, суралцах хэв маяг. Улаанбаатар. Мөнхийн үсэг ХХК
4. Ариунжаргал, Л ба нар. (2020). Суралцахуйн тухай ойлголт ба суралцах чиг хандлагад гарч буй өөрчлөлт

Нэмэлт унших материалууд:

1. Иргэний нийгмийн үндэсний эвсэл. (2011). “Бүх нийтийн боловсролын төлөө”.
2. Тогтвортой хөгжлийн боловсрол төсөл (2016), “Бага дунд боловсролын жендерийн дүн шинжилгээ”
3. ЮНЕСКО, Боловсролын хяналт шинжилгээний дэлхийн тайлангийн хураангуй “Тэгш хамралт ба боловсрол: Бүх нийт гэсэн бол бүх нийт л байх ёстой”
4. Монголын Сэтгэлзүй Сэтгэц Хэмжилзүйн Үндэсний Хүрээлэн 2020. “Суралцахуйн бэрхшээл”
5. Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг, Жайка тусгай хэрэгцээт боловсролын төсөл (2018), “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй” сэдэвт онол, практикийн v бага хуралын эмхэтгэл
6. Юнеско. БСШУЯ (2015) “Тэгш хамруулан сургах багшийн боловсрол”. Улаанбаатар: Адмон принт
7. Японы Хүүхдийг Ивээх Сан “Бага насны хүүхдийг хөгжүүлэх боломж” Сайн туршлагын эмхэтгэл
8. Суралцахуйн бэрхшээлийн хүйсийн харьцаа (<https://setgelsudlal.mn/childeq/>) Экстровеерт болон Интровеорт хүмүүсийн ялгаа (<https://setgelsudlal.mn/childeq/>)
9. Жадамбаа Б, нар Хүүхдийн хөгжлийн тухай төв үзэл, УБ, 2006
10. Батдэлгэр Ж. нар Бага ангийн сурагчдыг судлах арга зүй УБ., 2000
11. Тунгалаг О. 2013 Зургаан настай сурагчдын сэтгэхүйн хөгжлийн түвшин хэв шинжийн судалгаа (диссертац)
12. Д. Одгэрэл, Н.Оюунтунгалаг (2020) “Зан төрх, танин мэдэхүйн бэрхшээлтэй хүүхдийн талаарх ойлголт, илрүүлэх арга зам” гарын авлага
13. A human rights-based approach to education for all (A Human Rights-Based Approach to Education © United Nations Children’s Fund/ United Nations Educational, Scientific and Cultural Organization, 2007)

14. Equality and diversity policy (Manor Primary School Equality and Diversity Policy)
About Manor Primary - Manor Primary
15. Linda j. Graham “Inclusive education in the 21st century” 2021.
16. Nerida spina “Using assessment data to support student learning” 2021.
17. Kathy cologon & carly lassig “Universal approaches to curriculum, pedagogy and assessment” 2021.
18. Loren swancutt, marijne medhurst, “Making adjustments to curriculum, pedagogy and assessment” 2021.
19. Linda j. Graham, marijne medhurst, haley tancredi, ilek tra spandagou & elizabeth walton “Fundamental concepts of inclusive education” 2021.
20. What is Universal Design for Learning (UDL)? <https://www.understood.org>
21. Common accommodations and modifications in school
22. Examples of Universal Design for Learning in the Classroom
23. 10 Tips to Help Get Your Child Organized
24. Learning strengths.

Хичээлийн залгамж, холбоо:

Хичээлийн товч тодорхойлолт: Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх арга зүй хичээл нь XXI зууны суралцахуйн чиг хандлага, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх онол арга зүй, үзэл баримтлалууд дээр тулгуурлан, суралцагчдын ялгаатай байдлуудыг харгалзан, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх аргуудыг асуудлуудыг бага ангийн багш мэргэжлийн онцлог, түүнд тавигдах шаардлага зэрэгт нийцүүлэн судална.

Хичээлийн зорилго: Оюутан багш нь хүүхэд нэг бүрийн суралцах хэв маяг, суралцах орчин, оюун ухааны хөгжлийн ялгаатай байдлыг үнэлэн, тэдний ялгаатай байдлыг харгалзсан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх арга зүйн үндэс суурийг тавихад оршино.

Агуулга: 21-р зууны суралцахуйн чиг хандлага өөрчлөлт, суралцагч нэг бүрийн сурах онцлог ялгаатай байдлуудыг судлах, оношлох аргуудыг хэрэглэж дүгнэлт хийх, улмаар тэдний ялгаатай байдлуудыг харгалзсан хичээлийн бэлтгэл зохион байгуулалт, агуулга, арга зүй, үнэлгээ бүхий хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх арга зүйд суралцах

Хичээлийн сургалтын арга зүй: Оюутан бичил судалгааны багт хамтран ажиллах, ерөнхий боловсролын сургуулийн орчинд ажиглалт хийх, үр дүнгээ хэлэлцэх замаар мэдлэг бүтээж, туршлагаа баяжуулах, оролцоонд тулгуурлах болно. Семинарын хичээл, бие даах ажлыг гүйцэтгэх явцад суралцах үйл ажиллагаагаа өөрөө хянаж, зохицуулах, өөрийн удирдлагатай, идэвх санаачилгатай, бүтээлчээр суралцах, бусдын суралцахуйг дэмжих замаар оюутан бүрийн насан туршдаа суралцах чадавхыг хөгжүүлэх зорилгоор идэвхтэй сургалтын аргад тулгуурлана. Тухайлбал; үнэлгээний CIPP загвар (Context-агуулга, Input-оролт, Process-боловсруулалт, Product-бүтээгдэхүүн); Сургалтын үнэлгээний RLBR загвар (Reaction – Нөлөөлөл, Learning – Сургалт, Behavior – Төлөв байдал, Results – Үр дүн) RAFT арга (Role-Дүр, Audience-Сонсогч, Format-Төрөл, хэлбэр, Topic- Сэдэв) зэрэг аргуудыг хэрэглэнэ.

Хүснэгт 1. Үр дүнгийн хамаарал

Хичээлийн төлөвлөлт	Хичээлээр эзэмших мэдлэг, чадвар, хандлага
Бүлэг сэдэв -1. XXI зуун ба суралцахуйн чиг хандлага	[CLO 1.1, 2.1, 2.3]
Бүлэг сэдэв -2. Хүүхэд нэг бүрийн ялгаатай байдлыг харгалзан хөгжүүлэх арга зүйн үндсэн ойлголтууд	[CLO 1.2, 1.3, 2.2, 2.6, 2.7, 3.1, 3.3]
Бүлэг сэдэв -3. Хүүхэд нэг бүрийн ялгаатай (өвөрмөц)	[1.4, 1.6, 2.4]

байдлыг харгалзан хөгжүүлэх арга зүй	
--------------------------------------	--

Хүснэгт 2. Хичээлийн төлөвлөгөө

Нийт цаг: 64 цаг

7 хоног	Сэдэв	Семинар
1-4	XXI зуун ба суралцахуйн чиг хандлага	16
5-8	Хүүхэд нэг бүрийн ялгаатай байдлыг харгалзан хөгжүүлэх онол, арга зүй	16
9-16	Хүүхэд нэг бүрийн ялгаатай (өвөрмөц) байдлыг харгалзан хөгжүүлэх арга зүй	32
Нийт цаг		64

Үнэлгээ:

№	Үнэлгээний хэлбэр	Эзлэх хувь	Багтаамж
1	Ирц, оролцоо	10%	Хичээлд хамрагдалт, хичээлийн бэлтгэл, холбогдох эх сурвалжийг уншиж судлах, эрэл хайгуул хийх, хэлэлцүүлэгт тодорхой хувь нэмэр оруулсан байдал зэргийг харгалзана
2	Бие даах ажил	50%	Суралцахуйн гэрээ байгуулна. Оюутанд Бие даалтын зорилго, хэрэгжүүлэх арга замаа өөрөө боловсруулан гүйцэтгэх боломж олгоно.
3	Явцын сорил ба үр дүнгийн үнэлгээ	40%	I. Явцын сорил (мэдлэг, чадвар, хандлагыг шалгах сорил, тест, дасгал, даалгавар) II. Эцсийн үнэлгээ (сорил буюу гүйцэтгэлд суурилсан үнэлгээ)

СЭТГЭЛ ЗАСЛЫН АРГА, ЗӨВЛӨГӨӨ (Т.РЕ408) ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА

Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага (CLO):

1. Мэдлэг

- 1.1. Бага ангийн сурагчдад тулгардаг тодорхой асуудлыг шийдвэрлэхэд сэтгэл заслын энгийн арга, техникүүдээс сонгох, үндэслэлээ тайлбарлах [PLO1.1.6, 2.1.1, 3.1.2, 3.3.2]

2. Чадвар

- 2.1. Сургуулийн бага насны хүүхдийн өмнө тулгарч буй асуудлыг илрүүлэх, зөвлөхөд ярилцлагын арга, техникийг практикт хэрэглэх [PLO1.1.5, 3.3.2]
- 2.2. Сургуулийн бага насны хүүхэд, эцэг эхэд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд сэтгэл заслын тохирох аргуудаас сонгох, хэрэглэх [PLO1.1.2, 2.2.4, 3.4.2]
- 2.3. Сэтгэл зүйн зөвлөгөө, заслын арга техникийг ашиглан хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх [PLO2.1.3, 3.3.2]

3. Хандлага

- 3.1. Сэтгэл зүйн зөвлөгөө, заслын аргуудыг хэрэглэхдээ ёс зүйн шаардлагыг нэн тэргүүнд тавих, судлаачийн хариуцлагыг ойлгож цаашид багшлах үйл ажиллагаандаа тулгуурлан судалгааны зарчмуудыг мөрдөх [PLO 2.2.2]
- 3.2. Сэтгэл заслын арга техник ашиглан, өөрийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаагаа эргэцүүлэх [PLO1.1.1, 3.5.1]

Үнэлгээний жин, хэлбэр:

Ирц, оролцоо: 10%

Бие даалтууд: 50%

Явцын сорил: 20%

Эцсийн шалгалт, үнэлгээ: 20%

Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр, код:	Сэтгэл заслын арга, зөвлөгөө, Т.РЕ408
Улирал:	3, 4 дамжааны дурын улирал
Хичээлийн задаргаа:	0:4:0:0 (3) (семинар)
Заах багш:	Г.Бямбатогтох, Б.Мягмаржав, Ч.Нямсүрэн, Т.Энхмаа
И-мэйл хаяг:	varus2020@yahoo.com , byambatogtokh@msue.edu.mn , eegii2015@gmail.com , t.enkhmaa@msue.edu.mn , nyamsureenchuluundorj@gmail.com
Утас:	(976)-70112429
Ажлын өрөө:	5-208
Ажиллах цаг:	Даваа–Баасан, 9:00 am – 18:00 pm.

Үндсэн сурах бичиг:

1. Мягмар.О, (2019). Сэтгэц заслын зөвлөгөөний онол, арга зүй УБ.

Нэмэлт унших материалууд:

1. Мягмар О. (2020). Сэтгэц заслын удиртгал (семинарын хичээлийн гарын авлага). УБ.
2. Баярмаа.Э.(2020). Психодинамик сэтгэц засал. УБ.
3. Ариунтуяа Н., Гэрэлсүрэн Х. (2015). Сэтгэл зүйн зөвлөгөөний үндэс. УБ.
4. Эрдэнэчулуун Д. (2010). Сэтгэл зүйн зөвлөгөөний арга техник. УБ.

Хичээлийн залгамж холбоо:

Хичээлийн тодорхойлолт: Сэтгэл заслын арга, зөвлөгөө хичээлээр сэтгэл зүйн зөвлөгөө заслын орчин үеийн арга техникийг, хүмүүнлэг сэтгэл судлалын онолын үндсэн зарчимтай уялдуулан судална.

Хичээлийн зорилго: Сургуулийн бага насны хүүхдийн тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, шийдвэрлэхэд сэтгэл заслын энгийн арга техникийг практик амьдралд хэрэгжүүлж сурна.

Агуулга: Сэтгэл зүйн зөвлөгөө, заслын үндсэн асуудал, орчин үеийн сэтгэл зүйн зөвлөгөө заслын ажлын чиглэлийн талаар танин мэднэ. Тухайлбал, үлгэр засал, бүтээлийн заслын арга техник, элсэн заслын арга, зан үйлийн заслын арга техник гэх мэт.

Хичээлийн сургалтын арга зүй: Онол, практикийн хосолсон хэлбэрээр явагдана. Практик хэрэглээнд сэтгэл зүйн тренинг, туршилтын аргуудад тулгуурлан оюутнуудын бүтээлч сэтгэлгээг идэвхжүүлэх, мэргэжлийн баримжаанд тулгуурласан хандлага төлөвшүүлэхэд чиглэгдэнэ. Үүнээс гадна төрөл бүрийн кейс, тулгуур дохио, зөвлөмж зэргийг ашиглана.

Хүснэгт 1. Үр дүнгийн хамаарал

Хичээлийн цөм агуулга	Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадварууд
Сэтгэл зүйн зөвлөгөө, заслын үндсэн асуудал	[1.1, 1.2, 1.3, 3.1, 3.2]
Сэтгэл зүйн зөвлөгөөний чиглэл	[2.1, 2.2, 2.3, 2.4, 2.5, 3.3]

Хүснэгт 2. Хичээлийн төлөвлөгөө

Нийт цаг: 64 цаг

7 хоног	Сэдэв	Семинар
1	Сэтгэл зүйн зөвлөгөө, заслын үндсэн асуудал	4

2	Сэтгэл зүйн зөвлөгөө, заслын орчин үеийн онол, үзэл баримтлал	4
3	Сэтгэл зүйн зөвлөгөө ба заслын холбоо хамаарал	4
4	Сэтгэл зүйн зөвлөгөө, заслын ёс зүйн зарчмууд	4
5-6	Ярилцлагыг хөтлөн явуулах технологи	8
7-8	Бүтээлийн заслын үндсэн арга, техник (Арт засал)	8
9-10	Үлгэр заслын үндсэн арга, техник	8
11-12	Элсэн заслын үндсэн арга, техник	8
13-14	Жүжигчилсэн урлагийн сэтгэл заслын арга техник (Психодрам)	8
15-16	Зан үйлийн заслын арга техник	8
Нийт цаг		64

Үнэлгээ:

№	Үнэлгээний хэлбэр	Эзлэх хувь	Багтаамж
1	Ирц, оролцоо	10%	Нийт 64 цагийн танхимын хичээлд биечлэн суусан тохиолдолд ирцийг 10 оноогоор тооцно.
2	Бие даах ажил	50%	Бие даалтыг 2 удаа гүйцэтгэнэ: • Үйлчлүүлэгчтэй хийх анхны уулзалт хийх - 20% • Тодорхой асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн зөвлөн туслах ажлын хөтөлбөр боловсруулах - 30%
3	Явцын сорил	20%	• I сорил түвшинчилсэн даалгавар /модуль -1/ - 10% • II сорил түвшинчилсэн даалгавар /модуль-2/- 10%
4	Эцсийн шалгалт, үнэлгээ	20%	Багш шаардлагатай гэж тооцсон тохиолдолд эцсийн сорилыг зохион байгуулж болно. Ингэхдээ 6 түвшинг агуулсан тест байна. Ийм тохиолдолд сорилын оноог 20% (эцсийн/нэгдсэн сорил) тооцно.

БАГА БОЛОВСРОЛЫН БАГШЛАХУЙГ ДЭМЖИХ АРГА ЗҮЙ (Т.РЕ410)

ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА

Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага (CLO):

1. Мэдлэг

- 1.1.Бага боловсролын багшийн загвар, стандарт, бага боловсролын бодлого, эрх зүй, хэм хэмжээг тайлбарлах [PLO1.1.6, 2.2.2, 2.3.1, 3.5.1]
- 1.2.Бага ангийн багшийн чадамж, багшлах ур чадвар, багшийн стандартуудыг харьцуулан тайлбарлах [PLO1.1.6, 2.2.2, 2.3.1, 3.5.1]
- 1.3.Багшийн ёс зүйн талаарх үндсэн ухагдахуун, хэм хэмжээ, зарчмыг тайлбарлах [PLO1.1.6, 2.2.2, 2.3.1, 3.5.1]

2. Чадвар

- 2.1.Багшлах арга зүйг төллөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах арга, техникийг практикт хэрэгжүүлэх [PLO1.1.6, 2.3.4, 3.3.2]
- 2.2.Багшлах ур чадвар, эв дүйг ажиглаж судлан, өөр нөхцөлд шилжүүлэн хэрэглэх туршлага, санааг ялгаж, дахин бүтээх
- 2.3.Багшийн ёс зүйн алдааг таньж, түүнээс сэргийлэх тодорхой санал дэвшүүлж чаддаг болно [PLO1.1.6, 2.2.2, 2.3.1, 3.5.1]
- 2.4.Гарааны багшийн заавал эзэмших мэдлэг, чадвар, хандлага, үнэт зүйлсийг ялган сонгож, задлан шинжлэх [PLO1.1.6, 2.2.2, 2.3.1, 3.5.1]

3. Хандлага

- 3.1.Багшийн ёс зүйн шаардлагыг нэн тэргүүнд тавих, судлаачийн хариуцлагыг ойлгож цаашид багшлах үйл ажиллагаандаа тулгуурлан судалгааны зарчмуудыг мөрдөх [PLO 2.2.2]
- 3.2.Багшлах арга техник ашиглан, өөрийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаандаа эргэцүүлэл хийх [PLO1.1.1, 3.5.1]

Үнэлгээний жин, хэлбэр:

Ирц, оролцоо: 10%

Бие даалтууд: 50%

Явцын сорил I, II: 20%

Эцсийн шалгалт : 20%

Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр, код:	Бага боловсролын багшлахуйг дэмжих арга зүй, Т.РЕ410
Улирал:	3, 4 дамжааны хаврын улирал
Хичээлийн задаргаа:	0:4:0:0 (5) (семинар)
Заах багш:	Ц.Тамир, Г.Бямбатогтох
И-мэйл хаяг:	eegii2015@gmail.com
Утас:	(976)-70112429
Ажлын өрөө:	5-208
Ажиллах цаг:	Даваа–Баасан, 9:00 am – 18:00 pm.

Үндсэн сурах бичиг:

1. Цэвээнлхазал Я., Энхээ Д. (2010). Бага боловсролын сурган хүмүүжүүлэх зүй. УБ
2. Пүрэвдорж. Ч.(2013). “Багшлахуйн менежмент” УБ
3. Turnbull. A, Turnbull. R, & Wehmeyer. L. M. (2010). Exceptional lives: Special education in today’s schools. Sixth edition. Columbus, OH: Pearson Education.
4. Wood. C. (2007). Yardsticks: Children in the Classroom Ages 4-14. Third edition. Turners Falls, MA: Northeast Foundation for Children, Inc.

Нэмэлт унших материалууд:

2. Алсын хараа 2050., (2019). Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого УБ
3. Ирээдүйгээ хамтдаа дахин төсөөлөх нь. Боловсролын нийгмийн шинэ гэрээ ЮНЕСКО 2022\ <https://books.google.mn/books?id>
4. Боловсролын тухай хууль
5. Бага, дунд боловсролын тухай
6. Дээд боловсролын тухай
7. Бага дунд боловсролын тухай хууль 2002/шинэчлэн боловсруулагдсан 2012/
8. ЕБС-ийн багшийн стандарт 2009
9. Багшийн ёс зүйн дүрэм УБ, 2009
10. ЕБС-ийн багшийн үнэлгээний журам, 2012
11. ЕБС-ийн суралцагчдын боловсролын чанарын үнэлгээний журам. УБ. 2013.
12. Энхээ Д., Ванчигсүрэн Д. Оюунчимэг. 2010 он. “Эрсдэлтэй бүлгийн хүүхдүүдтэй ажиллах аргазүй.” Улаанбаатар хот, Монгол улс.

Хичээлийн залгамж холбоо:

Хичээлийн товч тодорхойлолт: Багшийн загвар, багшлахуйн орчин үеийн чиг хандлагыг судалж танин мэдэх, суралцах үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах мэдлэг, чадвар, дадлага туршлагаа гүнзгийрүүлэх

Хичээлийн зорилго: Бага боловсролын үйлчилгээг хэрхэн үзүүлэх, зохион байгуулах сургуулийн бага насны сурагчдыг суралцаж сурах/мэдэхүйн/, бүтээж сурах /бүтээхүйн/, бие даан амьдарч сурах/оршин тогтнохуйн/, нийгэмшиж, иргэншиж сурах /нийгэмшихүйн/ цогц чадамжтай болгоход оршино.

Агуулга: Шинэ зууны багшийн загвар, хичээлийн хэв, багшийн заах хэв шинжид харьцуулалт хийх, хүүхэд нэг бүрийн онцлог ялгаатай байдлыг

Бага боловсролын онолын үндэс, Сургуулийн бага насны хүүхдийн суралцах үйл ажиллагааны хөгжил, төлөвшил, хандлага. Тэгш хамруулах боловсрол, Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх суралцахуйн түгээмэл загвар, Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн онцлог, дэмжих арга замууд, сэргээн засалт, ганцаарчилсан сургалтын төлөвлөлт. Бага боловсролын удирдлага, анги зохион байгуулалт хамтын ажиллагаа.

Хичээлийн сургалтын арга зүй: Багш оюутны хамтын оролцоо төвтэй, оюутан бүрийг сэдэлжүүлсэн, тэдний бие даан хөгжих боломжийг эрэлхийсэн, судалгаа баримт дээр тулгуурлан үнэлгээ, дүгнэлт гаргах чадвартай асуудлыг бүтээлчээр шийдвэрлэх арга зүйд суурилна.

Хүснэгт 1. Үр дүнгийн хамаарал

Хичээлийн төлөвлөлт	Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар
Бага Боловсролын Багшийн стандарт	[CLO 1.1,]
Бага боловсролын багшийн төлөвлөлт, зохион байгуулалт	[CLO 2.1, 2.2, 3.1, 3.2]
Багшлахуйн явцад үйлийн судалгаа хийх онол арга зүй	[CLO 3.1, 3.2]
Бага боловсролын багш хөгжил, хөгжих орчин	[CLO 3.1, 3.2]

Хүснэгт 2. Хичээлийн төлөвлөгөө

Нийт цаг: 64 цаг

7 хоног	Сэдэв	Семинар
1-2	Бага Боловсролын Багшийн стандарт	8
3-4	Бага боловсролын багшийн төлөвлөлт, зохион байгуулалт	8
5-6	Бага сургуульд “Хичээлийн судалгаа” явуулах онол арга зүйн үндэс	8
7-9	Багшлахуйн явцад үйлийн судалгаа хийх онол арга зүй	12
9-16	Бага боловсролын багш хөгжил, хөгжих орчин	28
Нийт цаг		64

Үнэлгээ:

№	Үнэлгээний хэлбэр	Эзлэх хувь	Багтаамж
1	Ирц, оролцоо	10%	Ирц, идэвх оролцоо 10% -иар үнэлнэ.
2	Бие даах ажил	50%	Бие даалтыг 2 удаа гүйцэтгэнэ. • 21-р зууны багш эссэ бичих 20% • Хичээлийн судалгаа хийх 30%
3	Явцын сорил	20%	• I модулийн агуулгаар I сорил (10%) • II модулийн агуулгаар I сорил (5%) • III модулийн агуулгаар I сорил (5%)
4	Эцсийн шалгалт, үнэлгээ	20%	64 цагийн семинар, бие даан гүйцэтгэх даалгаврын агуулгаар Блүмийн таксономын 6 түвшнөөр сорил боловсруулж үнэлнэ. Эцсийн сорилын эзлэх хувь 20% байна.

ЭХ ЗАДЛАХ АРГА ЗҮЙ (Т.МЛ312) ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА

Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага (CLO):

1. Мэдлэг

- 1.1. Эхийн тухай ойлгох, түүнийг хэлний бусад нэгжээс ялгах, эхийн талаарх онол, үзэл баримтлалыг судлан, эхийг тодорхойлох [PLO 1.1.5, 3.2.1]
- 1.2. Баримтын ба баримтын бус эхийг ялгах, эх тус бүрийн онцлогийг тодорхойлох, баримтын ба баримтын бус эхэд хамаарагдах эхүүдийг жагсаах [PLO 1.1.6, 3.2.1]
- 1.3. Албан бичгийн эхүүд, түүнийг ялгах, албан бичгийн эхүүдэд тавигдах шаардлагыг жагсаах, бусад эхээс ялгарах онцлогуудыг мэдэх, тайлбарлах [PLO 1.1.6, 3.2.1]

2. Чадвар

- 2.1. Эхийг хэв маягаар ангилж бүлэглэх, бүтэц, зохиомж, үгийн сан, өгүүлбэр зүйн онцлогоор нь задлан тайлбарлах, улмаар төрөл бүрийн эхэд задлал хийх [PLO 1.1.5, 1.2.1, 3.2.1]
- 2.2. Баримтын ба баримтын бус эхийг боловсруулах, зураг, хүснэгт, график, диаграмм, схемийг онож хэрэглэх, мэтгэлцэх, баримтын ба баримтын бус эхийг харьцуулах, задлан шинжлэх [PLO 1.1.5, 1.2.1, 3.2.1]
- 2.3. Албан бичгийн эхийн найруулгын үгийн сангийн онцлогийг тодорхойлох, албан бичгийн эх боловсруулах, боловсруулахдаа зураг, хүснэгт, график, диаграмм, схемийг онож хэрэглэх, албан бичгийн эхүүдийг хооронд нь жиших, тэдгээрийг үнэлж дүгнэх [PLO 1.1.6, 1.2.1, 1.2.2]

3. Хандлага

- 3.1. Найруулгын алдааг засах, өөрийн бичгийн боловсруулалтдаа шүүмжлэлтэй хандах, өөрийгөө үнэлдэг болсон байх [PLO 1.2.1, 1.2.2]
- 3.2. Илтгэл, эсээг бичих, түүнийгээ танилцуулах буюу илтгэх, мэтгэлцээн зэрэг агуулгын хүрээнд эзэмшсэн чадвараа өөрийн үзэл бодлыг зөв боловсон, өөртөө итгэлтэй, ойлгомжтой илэрхийлэх чадвартай болж, бусадтай эерэг харилцааг чухалчлахад хэрэглэдэг болсон байна. [PLO 1.1.3, 1.2.1]

Үнэлгээний жин, хэлбэр:

Ирц, оролцоо: 20%

Бие даалтууд: 50%

Явцын сорил: 30%

Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр, код:	Эх задлах арга зүй Т.МЛ312
Улирал:	намрын улирал
Хичээлийн задаргаа:	0:4:0:0(3), 2 кредит (семинар, бие даалт)
Заах багш:	П.Жаргалсайхан
Е-мэйл хаяг:	jargalsaikhan.p msue.edu.mn
Утас:	(976)-70112429
Ажлын өрөө:	5- 101
Ажиллах цаг:	Даваа-Баасан, 8:40am-18:00pm
Үндсэн сурах бичиг:	

1. Алтанцэцэг,С.,Мөнцэцэг,Б., (2012) ОЦМХ-ний эх судлал
2. Базаррагчаа,М., (1989) Монгол хэлний эхийн тухай
3. Бямбацэрэн, Г.,(2013) Хэлний сургалт ба танин мэдэхүй.
4. Нандинбилиг,Г., (2016) Хүүрнэл зохиолыг задлан шинжилж сургахуй
5. Цог-Очир,А., Эрдэнэсан,Д., Монгол хэлний эхийн хэв маяг
6. Цэдэнбал,Ч., Бямбацэрэн,Г, (2010) Бага боловсролын монгол хэл бичиг, уран зохиолын онол, дидактик

Нэмэлт унших материалууд:

1. Баттогтох,Х., (200Г) Эрдэм шинжилгээний зохиолын найруулга
2. Бага боловсролын МХ-ний сурах бичиг I-Ү анги
3. Бигэрмаа,Р., (2005) Албан бичиг боловсруулалт, түүний найруулга
4. Галбаатар,Д., (2002) Уран зохиолын онолын ойлголт, нэр томъёоны тайлбар толь
5. Монголын уран зохиолын дээжис 108 боть
6. МУБИС,БС., (2012) 90 тоглоомын аргачлал
7. Мэндээ,Ж., (2010) Уншихуй ба жүжиглэхүй
8. Сүхбаатар,Ц., (2007) Монгол хэлний найруулга зүй

Хичээлийн залгамж, холбоо:

Хичээлийн товч тодорхойлолт:

Төрөл бүрийн эхийг найруулан бичих,баримтын болон баримтын бус эхийг утга, бүтцээр задлан тайлбарлах, найруулгын алдааг илрүүлэх,засах, шаардлагын дагуу бичих, эхийг зохиохдоо тохирсон үг, хэллэг сонгон хэрэглэх, эх дээр ажиллах арга зүйг эзэмшихдээ эхийн талаарх онолын мэдлэг эзэмшиж, мэдлэгээ практикт хэрэглэж сурахад оршино.

Хичээлийн зорилго:

Хэрэглээний болон уран зохиолын эхийн задлал хийх, задлал хийх явцдаа үлгэр жишээч эхийн бүтцийг ашиглан дуурайлган эх зохиох, өгөгдсөн сэдвийн дагуу болон чөлөөт сэдвээр баримтын болон баримтын бус эх зохиох, үүний тулд мэдээлэл цуглуулах, боловсруулалт хийх, ярилцах, сайжруулах, тайлагнах, аливаа асуудалд шинжлэх ухаанчаар хандах, цаашид сурах үйл ажиллагаандаа хичээлээр олж авсан мэдлэг чадвараа бие даан хэрэглэх чадварт суралцана.

Агуулга:

Эхийн тухай онолын мэдлэгээ бататган, хэлний бусад нэгжээс ялгах, эхийн талаарх онол, үзэл баримтлалыг судлан, баримтын ба баримтын бус эхэд задлал хийж сурах юм.

Хичээлийн сургалтын арга зүй : Идэвхтэй сургалтын интерактив ба чадваржуулах когнитив, конструктив онолын баримтлалаар сургалтыг хөтөлнө.

Хүснэгт 1. Үр дүнгийн хамаарал

Хичээлийн төлөвлөлт	Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадварууд
Эх, эхийг уншиж ойлгох	CLO1.1,1.2, 1.3, 2.1, 2.2, 2.3, 2.4, 3.1, 3.2, 3.3
Хэрэглээний эхэд задлал хийх	CLO 1.2, 1.3, 2.2, 2.3, 3.1, 3.2, 3.3
Уран зохиолын эхэд задлал хийх	CLO1.1, 1.2, 1.4, 2.1, 2.2, 2.4, 3.1, 3.2, 3.3

Хүснэгт 2. Хичээлийн төлөвлөгөө

Нийт цаг:64 цаг

7 хоног	Сэдэв	Сем
1-6	Эх, эхийг уншиж ойлгох	24
7-11	Хэрэглээний эх	20
12-16	Уран зохиолын эх	20
Нийт		64

Үнэлгээ

№	Үнэлгээний хэлбэр	Эзлэх хувь	Багтаамж
1	Ирц, оролцоо	20%	Лекц ба семинарын ирцийг 10%, семинарын хичээл дэх оюутны оролцоог 10% байхаар үнэлнэ.
2	Бие даалтууд	50%	Хичээлийн агуулгатай холбоотой бие даалтын ажлыг хийж гүйцэтгэсэн байдлыг 50%-иар тооцно. - В-1 Эхэд боловсруулалт хийх /10%/ - В-2 Хэрэглээний эхэд задлал хийх /20 %/ - В-3 СБ дэх уран зохиолын эх дээр задлал хийх, ажиллах /20%/
3	Явцын сорил I, II	30%	Бүлэг сэдвийн агуулгаар үнэлүүлэх явцын сорилыг 30%-иар тооцно. - Бүлэг сэдвийн агуулгаар (10 %) - Хэрэглээний болон уран зохиолын эхэд утга, бүтэц айгаар задлах агуулгаар (20 %)

УТГА СУДЛАЛ, (Т.МЛ306) ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА

Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага (CLO):

1. Мэдлэг

- 1.1. Утга судлалын үндсэн ойлголтыг ялган таних, үгийн утга, утгалбарыг тодорхойлох [PLO1.2.1, 3.2.1]
- 1.2. Хэлний нэгжүүдийн утгыг тодорхойлох, жагсаах, нэгжүүдийн гадаад, дотоод утгын харьцаа үүсгэх [PLO 1.2.1, 3.2.1]

2. Чадвар

- 2.1. Үгийг бүтцээр задлан ялгаллах, утгыг ажиглан хам сэдвээс үүдсэн утгын ялгааг тайлбарлах [PLO 1.2.1, 2.4.5, 3.2.1]
- 2.2. Үгийн олон утгыг эх сурвалжид тулгуурлан задлан шинжлэх, үүсмэл үгийн үүр үүсгэх, үгийн харьяа, төрөл, төсөөт утга үүсгэн өгүүлбэр эхийн түвшинд хэрэглэх, хөгжүүлэх [PLO 1.2.1, 2.4.5, 3.2.1]

3. Хандлага

- 3.1. Оюутан эх хэлний үнэт зүйлийг мэдрэх, суралцах, ярих, бичих чадвараа хөгжүүлэх эрмэлзэлтэй болох [PLO 1.2.1, 1.2.2, 3.2.1]
- 3.2. Хэлний тогтвортой нэгжийг гүнзгийрүүлэн судалснаар эх хэлээ хайрлах, хамгаалах, бахархах эрмэлзэлтэй болох [PLO 1.2.1, 1.2.2, 3.2.1]

Үнэлгээний жин, хэлбэр:

Ирц, оролцоо: 20%

Бие даалтууд: 50%

Явцын сорил: 30%

Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр, код:	Утга судлал, Т.МЛ306
Улирал:	III дамжааны хавар, намрын улирал
Хичээлийн задаргаа:	семинар: (0:4:0:0 (3))
Заах багш:	С.Гандэлгэр Т.МЛ13
Е-мэйл хаяг:	gandelger.s@msue.edu.mn
Утас:	(976)-77774664
Ажлын өрөө:	5-р байр 107 тоот
Ажиллах цаг:	Даваа-Баасан, 8:40 am - 18:00 pm.

Үндсэн сурах бичиг:

1. Бадамдорж, Д. (2001). *Монгол хэлний утга судлал*. 1, 2 дэвтэр. Уб.
2. Бадамдорж, Д. (2016). *Монгол хэлний үгийн сангийн утга зүй*. Уб.

Нэмэлт унших материалууд:

1. Бямбацэрэн. Г, нар. (2015). *Үгийн сан судлал*. Уб.
2. Бадамдорж, Д. (2003). *Утга зүйн сорилго, дасгал*. Уб.
3. Төмөрцэрэн, Ж. (1974). *Монгол хэлний үгийн сангийн судлал*. Уб.
4. Баттөгс, Ш. (1998). *Орчин цагийн монгол хэлний үгийн сангийн дасгал, түүний тайлбар*. Уб.
5. Бага боловсролын монгол хэл, бичиг, уран зохиолын онол, дидактик. (2010). Уб.

Хичээлийн залгамж, холбоо:

Хичээлийн товч тодорхойлолт: Төрөлх хэлний нэгжүүдийн утга, тогтвортой нэгжүүд тэдгээрээс үүдсэн хэл, соёлын асуудал, монгол сэтгэлгээ, улмаар хэл сэтгэхүйн холбоог ухаарах, тайлбарлах, мэдлэг бүтээлгэх, онож хэрэглэх, зөв зохистой ярих, найруулан бичихэд энэхүү хичээл хөтөлнө.

Хичээлийн зорилго: Монгол хэлээрээ зөв, оновчтой, товч, тодорхой ярьж сурахын тулд хэлний нэгжүүдийн утгыг сэрж мэдрэхээс ойлгож мэдрэх, ухаарахаас ухамсарлахад тулгуурлан эх хэлээ судлах, эзэмших, заахад оршино.

Агуулга: Хэлний нэгжүүд болох авиалбар, бүтээвэр, үг, өгүүлбэр, цогцолбор, эхийн утга, утгын харьцаа, хувиргал, тэдгээрийг хэлний хэрэглээ, тэдгээрийн баримтын болон баримтын бус эхэд тулгуурлан утгыг тодорхойлох, задлан ялгаллах, зарим утгыг лавшруулан гарал, утга талаас нь судлах, бага сургуулийн хөтөлбөр, стандарт дахь агуулгатай харьцуулах зэргээр онол, дадлага, судалгаа гэсэн харьцаа үүсгэн агуулгаа сонгосон.

Хичээлийн сургалтын арга зүй: Хичээлийг оюутны оролцоо төвтэй, сургалтын явцад суралцагчдын бүтээлч үйл ажиллагааг сэдэлжүүлсэн, оюутан нэг бүрийн хөгжих боломжийг бүрдүүлсэн сургалтын сэтгэл зүйн таатай орчныг бүрдүүлэн ажиллахад анхаарна. Сургалтад түгээмэл хэрэглэгдэх асуудал дэвшүүлэн шийдвэрлэх арга болон бусад бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх сургалтын аргууд байна.

Хүснэгт 1. Үр дүнгийн хамаарал

Хичээлийн төлөвлөлт	Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадварууд
Бүлэг сэдэв-1. Утга судлалын судлагдахуун хийгээд авиалбар, бүтээврийн утга	CLO [1.2, 3.1, 3.2, 2.4]
Бүлэг сэдэв-2. Үглэвэр, өгүүлбэр, цогцолбор, эхийн утга	CLO [1.2, 2.4, 3.1, 3.2]

Хүснэгт 2. Хичээлийн төлөвлөгөө

7 хоног	Сэдэв	Сем
1-8	Утга судлалын тухай үндсэн ойлголт хэлний бага нэгжүүдийн утга	
9-16	Хэлний их нэгжүүдийн утга	
Нийт		64

Үнэлгээ:

№	Үнэлгээний хэлбэр	Эзлэх хувь	Багтаамж
1	Ирц, оролцоо	20%	Семинарын хичээлд суусан ирц, семинарын сэдэвтэй холбоотой гүйцэтгэх ёстой дасгал даалгаврыг хийсэн байдал болон идэвх, оролцоог 20%-иар тооцно.
2	Бие даалтууд	50%	Бие даалтыг 2 удаа гүйцэтгэнэ: • Судалгаанд суурилсан эсээ бичих-30 % • Хэлний нэгжүүд, тэдгээрийн утга, бүтэц, задлан ялгал хийх-20%
3	Явцын сорил I, II	30%	1. 1-р бүлэг сэдвийн агуулгын хүрээнд сорил №1- авах ба онолын мэдлэгийн сонгох, нөхөх, гүйцээх тест, утгын хүрээ, харьцаа үүсгэх даалгавраар, чадварын үнэлгээг бүтээврийн задлан ялгал хийхээр үнэлнэ. 2. 2 дугаар бүлэг сэдвийн агуулгаар сорил №2-ыг авах ба үглэвэр, өгүүлбэр, эхийн утга, бүтцэд задлан ялгах хийхээр үнэлнэ.

УНШИХУЙ БА ЖҮЖИГЛЭХҮЙ (Т.МЛ307) ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА

Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага (CLO):

1. Мэдлэг

- 1.1. Үр дүнтэй уншлага түүний зарчмуудыг ухаарч мэдэх [PLO 1.2.1, 3.5.1]
- 1.2. Уран уншлагад бэлтгэх, зохиол бүтээлийг ойлгох авианы зөв тод дуудлага, утга зохиолын хэлний бичгийн болон ярианы дуудлагын ялгаа мөн чанарыг ойлгох, илэрхийлэх [PLO 1.2.1, 3.2.5]

2. Чадвар

- 2.1. Зохиол бүтээлийг бүтээлчээр уншин ойлгох чадварт суралцах, сурахуй ба суралцахуйн үйлийг уран уншлага ба багшийн яриа, жүжиглэх чадвартай холбон бүтээлчээр хэрэгжүүлэх [PLO 1.2.1, 3.2.5]
- 2.2. Дүрийн дотоод сэтгэл зүй, зохиол бүтээлийн үйл явдалд тулгуурлан тайлбарлах [PLO 1.2.2, 3.2.5]
- 2.3. Нөхцөл байдалд тохируулан өөрийгөө зөв илэрхийлэх, эргэцүүлэх [PLO 1.1.2, 1.2.1, 3.2.5]

3. Хандлага

- 3.1. Суралцагчдын болон өөрийн ярианы чадварт (уран уншлагад) шүүмжлэлтэй хандах эрмэлзэлтэй болох [PLO 1.1.2, 3.2.5]
- 3.2. Ярих чадварт тулгуурлан хичээлийг сонирхолтой, үр өгөөжтэй заах хүсэл тэмүүлэлтэй болох [PLO 1.2.1, 3.2.6]

Үнэлгээний жин, хэлбэр:

Ирц, оролцоо: 20%

Бие даалтууд: 60%

Явцын сорил: 20%

Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр, код:	Уншихуй ба жүжиглэхүй, Т.МЛ307
Улирал:	дурын
Хичээлийн задаргаа:	0:2:0:0(2) семинар:
Заах багш:	А.Амардалай, Б.Нанжид,
Е-мэйл хаяг:	nanjid@msue.edu.mn , amardalai@msue.edu.mn
Утас:	(976)-70112429, 89114882
Ажлын өрөө:	МУБИС V байр 207 тоот
Ажиллах цаг:	Даваа-Баасан, 8:40 am - 18:00 pm.
Үндсэн сурах бичиг	

1. Жачин, Ч. Цэнд, С. (2015), Уран уншлага. Улаанбаатар: Арвай бархан.
2. Баатархүү, Ц. (2006), Ярих урлаг. Улаанбаатар: Бэмби сан.
3. Зоригт, С. (2005), Тайзны яриа. Улаанбаатар: Жиком.

Нэмэлт унших материалууд:

1. Амарсанаа, Ц. (2010), Үгээр урлахуйн ухаан. Улаанбаатар: Өнгөт хэвлэл.
2. Ганчулуун, Г. (2018), Тайзны хэл ярианы урлаг ба жүжигчний хөдөлмөр. Улаанбаатар: Жиком.

Хичээлийн залгамж, холбоо: Хүүхдийн уран зохиол, Т.МЛ405

Хичээлийн товч тодорхойлолт: Бага боловсролын багшийн зөв цэгцтэй ярих, ойлгож унших, илтгэх чадварыг хөгжүүлж багшлах ажил үйл ажиллагаандаа хэрэглэх хандлагыг төлөвшүүлэх.

Хичээлийн зорилго: Оюутан-багш нь уран яруу өгүүлэх, зөв, цэгцтэй, боловсон ярих чадвар, илтгэх урлагийн үнэ цэнэ, ач холбогдлыг ухааран ойлгож, илтгэх урлагийн техникүүдийг эзэмших, зохих түвшинд илтгэх, ярих чадвараа хөгжүүлж өөрийн цаашдын амьдрал үйл ажиллагаандаа бүтээлчээр хэрэгжүүлэх чадвартай болгоно.

Агуулга: Бага боловсролын багшид олон төрлийн суурь чадвар, арга зүй, ур чадвар эзэмших шаардлага тулгарч байна. Түүний нэг нь уран яруу өгүүлэх, зөв, цэгцтэй, боловсон ярих чадвар, урлаг уран зохиолыг ойлгох, унших ба ярих чадварыг хөгжүүлэх боломжийг бүрдүүлнэ. **Хичээлийн сургалтын арга зүй:** Суралцагч төвтэй, гүйцэтгэлд суурилсан (performance-based approach) арга зүйг голлон ашиглаж оюутнуудад унших, уран унших, ойлгож унших, урнаар илэрхийлэх талаар суралцах, бүтээлчээр оролцох, үнэлэх, багаар ажиллах боломжийг бүрдүүлнэ.

Хүснэгт 1. Үр дүнгийн хамаарал

Хичээлийн төлөвлөлт	Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадварууд
Бүтээлчээр унших	CLO 1.1, 2.1, 3.2
Урнаар унших	CLO 1.2, 3.1, 3.2
Урнаар илэрхийлэх	CLO 2.2, 2.3,

Хүснэгт 2. Хичээлийн төлөвлөгөө

7 хоног	Сэдэв	Сем
1-4	Уншихуй ба ойлгох	18
5-8	Жүжиглэхүй	16
9-16	Уран уншлага	30
Нийт		64

Үнэлгээ:

№	Үнэлгээний хэлбэр	Эзлэх хувь	Багтаамж
1	Ирц, оролцоо	20%	- Семинарын хичээлд суусан ирц, оролцоо түүний тэмдэглэгээг 10%-иар, - Семинарын хэлэлцүүлэг, дасгал даалгавар хийсэн байдлыг 10%-иар тооцно.
2	Бие даалтууд	50%	Бие даалтыг 3 удаа гүйцэтгэнэ. - Өөрийн судалгааны үндсэнд цээжилсэн эх зохиолыг уран яруу унших. 25% - Уншлага ба ойлгоцын ахиц - 10% - Багаараа бэлтгэсэн жүжигчилсэн тоглолт -15%

ДЭЛХИЙН ХҮҮХДИЙН УРАН ЗОХИОЛ (Т.МЛ406) ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ, ТАНИЛЦУУЛГА

Нэг. ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

Хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага (CLO):

1. Мэдлэг

- 1.1. Дэлхий нийтийн эрт эдүгээгийн уран зохиолын дурсгалуудаас, хүүхдийн уншлагад холбогдох зохиол бүтээлүүдийг судлах [PLO 1.1.3, 1.1.6]
- 1.2. Орчуулгын уран зохиол, хүүхдийн нас сэтгэхүйн онцлогийн харилцан хамаарлыг судлах, тайлбарлах [PLO 1.1.6, 1.2.1]

2. Чадвар

- 2.1. Гадаадын хүүхдийн зохиол бүтээлийн сэдэв агуулга, дүр дүрслэлийг задлан шинжлэх, харьцуулах, тайлбарлах [PLO 1.1.3, 1.1.6, 3.2.5]
- 2.2. Орчуулгын хүүхдийн уран зохиолыг, монголын хүүхдийн уран зохиолтой харьцуулах, тодорхойлох, онцлог ялгааг илрүүлэх [PLO 1.1.3, 1.1.6]

3. Хандлага

- 3.1. Эх хэлээ хайрлах, зохиол бүтээлээр дамжуулан түгээн дэлгэрүүлэх, бахархах хүсэл эрмэлзэлтэй болох [PLO 1.2.1, 3.2.5]
- 3.2. Эх зохиолыг сонгохдоо, судлаач-уншигчийн үүднээс хандах [PLO 1.2.1, 3.2.5]

Үнэлгээний жин, хэлбэр:

Ирц, оролцоо: 20%

Бие даалтууд: 50%

Явцын сорил: 30%

Хоёр. ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хичээлийн нэр, код:	Дэлхийн хүүхдийн уран зохиол Т.МL406
Судлах улирал:	дурын
Хичээлийн задаргаа:	0:4:0:0:[2] , 2 кредит
Заах багш:	А.Амардалай Т.МL18, Б.Нанжид Т.МL17
Е-мэйл хаяг	amardalai@msue.edu.mn Nanjid11@gmail.com
Утас:	(976)-70112429, 88067869, 89114882
Ажлын өрөө:	5-207
Ажиллах цаг:	Даваа–Баасан, 08:40 am – 18:50 pm.

Үндсэн сурах бичиг:

1. Хөвсгөл.С. (2010). *Дорно дахины уран зохиол*. Уб: Бемби сан.
2. Хөвсгөл.С. (2013). *Өрнө Дахины уран зохиол*. Уб: Жиком пресс.

Нэмэлт унших материалууд

1. Батжаргал.Д, Амарзаяа.Э. (2017). *Хүүхдийн уран зохиолын тайлбар толь*. Уб: Бемби сан.
2. Галбаатар.Д. (2012). *Уран зохиол: Онол, түүх, шүүмжлэл Нэвтэрхий толь*. Уб.
3. Галбаатар.Д. (2013). *XX зууны өрнө дорны уран зохиол*. Уб.
4. Оюунбадрах.Д. (2007). *Монголын хүүхдийн уран зохиол*. Уб.
5. Ред.Аюурзана.Г. (2003). *Дэлхийн уран зохиолын 85 сод туурвил*. Уб.
6. Ред.Цэдэв.Д, Оюун-Эрдэнэ.Б. (2012). *Уран зохиол /Соёмбо нэвтэрхий толь/*. Уб: Соёмбо пресс.
7. Ред.Энхбаяр.С. (2021). *Утга зохиол шинжлэл*. Уб: Жиком пресс.
8. Хүү.Д. (2004). *Дэлхийн хүүхдийн уран зохиол*. Уб: Оюунтүлхүүр.
9. Цэрэнсодном.Д. (2010). *Монгол ардын домог үлгэр*. Уб: Тод бичиг.
10. Эмх.Дадшондог.Ж. (2019). *Дэлхийн хүүхдийн хүүрнэл зохиолын дээж II боть*. Уб: Сэлэнгэпресс.
11. Эмх.Соёмбопринтинг. (2006). *Өрнө дорнын шилдэг өгүүллэгүүд*. Уб: Соёмбо принтинг.
12. Энхбаяр.С, Батсуурь.Г. (2018). *Уран зохиолын тухай яриа*. Уб: Жиком пресс.

Хичээлийн залгамж, холбоо:

Хичээлийн товч тодорхойлолт:

Өрнө, дорнын хүүхдийн уран зохиолыг цаг үе, гол төлөөлөгчдийн дагуу системтэйгээр гүнзгийрүүлэн судална.

Хичээлийн зорилго:

Энэхүү хичээлийг судалснаар оюутан дэлхийн хүүхдийн уран зохиолын үечлэл, онол, судалгаа, онцлог, төрөл зүйл, гол төлөөлөгчдийн шилдэг бүтээлүүдэд тулгуурлан бүтээлчээр задлан шинжилж, дэлхийн хүүхдийн уран зохиолын талаар тодорхой системтэй мэдлэгийг эзэмшин, зохиол бүтээлүүдийг ойлгон мэдэрч, практикт сонгон

хэрэглэх чадвар эзэмшсэн багшлах үйл ажиллагаандаа бүтээлчээр хэрэглэх чадвар, хандлагатай болсон байна.

Агуулга:

Гадаадын уран зохиол, өрнө ба дорно дахины хүүхдийн уран зохиолын онцлог, гол төлөөлөгчид, зохиол бүтээлийн тоймыг өрнө дахины хувьд эртний Грек, Ромын үеэс өнөөг хүртэлх, дорно дахины уран зохиолын хувьд эртний Энэтхэг, Хятадын уран зохиолоос өнөөг хүртэлх, Америк, Африк тивийн уран зохиолын шилдэг бүтээлийг хамарна.

Арга зүй:

Хичээлийг оюутны оролцоо төвтэй, сургалтын явцад суралцагчдын бүтээлч үйл ажиллагааг сэдэлжүүлсэн, оюутан нэг бүрийн хөгжих боломжийг бүрдүүлсэн сургалтын сэтгэл зүйн таатай орчныг бүрдүүлэн ажиллахад анхаарна. Сургалтад түгээмэл хэрэглэгдэх сургалтын арга зүйнүүд нь бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх сургалтын аргууд байна.

Хүснэгт 3 Үр дүнгийн хамаарал

Агуулгын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг	Хичээлээр эзэмших мэдлэг, чадвар
Домог зүй ба хүүхдийн уран зохиол	CLO [1.1, 1.2, 1.3, 2.3, 3.3]
Орчин үеийн үлгэр	CLO [1.1, 1.2, 2.1, 2.3, 3.2]
